



МОНГОЛБАНК

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

**УЛААНБААТАР
2014 ОН**

ГАРЧИГ

I.	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	5
II.	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 57 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	15
III.	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	27
IV.	МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БОЛОН ОЙРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААР ХИЙСЭН ТООЦОО СУДАЛГАА	39
4.1	ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	40
4.1.1	Эдийн засгийн өсөлт	40
4.1.2	Мөнгөний үзүүлэлтүүд	41
4.1.3	Зээлийн өсөлт	42
4.1.4	Төсөв	43
4.1.5	Хүүний түвшин	45
4.1.6	Гадаад сектор, хани	47
4.1.7	Инфляци	57
4.1.8	Банкны салбарын тогтвортой байдал	58
4.2	ЭДИЙН ЗАСГИЙН ОЙРЫН ТӨЛӨВ	69
4.2.1	Гадаад эдийн засгийн төлөв	69
4.2.2	Оюу Толгойн үйлдвэрлэлийн таамаглал	72
4.2.3	Хөтөлбөр, Чингис бонд	73
4.2.4	Төсөв	75
4.2.5	Мөнгөний үзүүлэлтүүдийн төлөв	76
4.2.6	Бодит эдийн засгийн өсөлт	80
4.2.7	Инфляцийн төсөөлөл	82

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Төсвийн тогтвортой байдлыг хангаж, гадаад валютын урсгалыг сайжруулан, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн Газар (Н.Алтанхуяг)-т, эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллахыг Монголбанк (Н.Золжаргал)-нд тус тус даалгасугай.

3. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Тол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга хэрэгслүүдийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэр рүү шат дараатай шилжүүлэх, хөтөлбөрүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг)-т даалгасугай.

4. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал), Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд тус тус даалгасугай.

5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийг Олон улсын байгууллага (ФАТФ)-аас тогтоосон стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх, Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулах, холбогдох журмыг батлах, хэрэгжилтэнд хяналт тавихыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал)-нд тус тус даалгасугай.

6. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар (Н.Алтанхуяг), Монголбанк (Н.Золжаргал), Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд тус тус даалгасугай.

7. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо (Б.Гарамгайбаатар)-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын
2013 оны сарын-ны өдрийн
.... дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Мөнгөний бодлогын гол зорилт нь инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн дархлааг сайжруулахад чиглэнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2014 оны эцэст 8 хувь, 2015-2016 онд 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгана. Үүний үр дүнд дунд хугацаанд макро эдийн засаг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.

2. Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1 Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, үүсч болзошгүй системийн шинжтэй эрсдэлийг даах чадварыг нэмэгдүүлнэ.

2.2 Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг сайжруулна.

2.3 Банкны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн эрх зүйн орчинг шинэчилнэ.

3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2014-2016 онд эрчимжүүлнэ.

3.2 Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлнэ.

3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангах замаар бодлогын үр нөлөөг сайжруулна.

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын төлөв байдалд үндэслэн шаардлагатай зорилтуудыг дэвшүүлдэг. Энэ дагуу эдийн засгийн өнөөгийн болон ойрын төлөв байдлыг Бодит сектор, Гадаад сектор, Улсын төсвийн болон Мөнгө, санхүүгийн гэсэн үндсэн 4 сектор тус бүрээр нь авч үзье.

Бодит сектор

Энэ оны 1 дүгээр улиралд 7.1 хувь болж саараад байсан эдийн засгийн бодит өсөлт 2 дугаар улирлын байдлаар 14.3 хувьд хүрсэн нь олон улсын түвшинд өндөрт тооцогдох үзүүлэлт болж байна. Энэхүү өсөлтөд барилгын салбар 154 хувиар, хөдөө аж ахуйн салбар 21 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 11 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөллөө.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2013 оны эцэст 14.4 хувь гарахаар төсөөлөгдөж байгаа нь уул уурхай, хөдөө аж ахуй, барилгын салбарын өсөлтөөр хангагдахаар байна.

Оюу толгой төслийн үйлдвэрлэл идэвхжиж, 3 дугаар улиралд 36.2 мянган тонн зэс, 3.3 тонн алт, 8.8 тонн мөнгө үйлдвэрлэхээр төлөвлөснийг уул уурхайн салбарын өсөлтөд тусгаснаар ДНБ-ий өсөлтөд 9.5 нэгж хувийн нөлөө үзүүлнэ гэж таамаглаж байна. Салбар хоорондын тэнцлийг ашиглаж тооцсон таамаглалаар “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр” болон “Чингис” бондын хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь барилга, боловсруулах салбарын өсөлтөд гол нөлөө үзүүлэхээр байна.

Нийт эрэлт талаас авч үзвэл, 2013 оны эхний хагас жилд эцсийн хэрэглээ эдийн засгийн өсөлтөд өндөр хувийн нөлөө үзүүлэв. Энэхүү нөлөө оны сүүлийн хагаст ч мөн хадгалагдахаар байна. Өрхийн хэрэглээ, цэвэр экспорт нь нийт эрэлтэд эерэг нөлөө үзүүлэхээр байгаа юм. Эдийн засгийн хурдацтай өсөлтийн үед Засгийн газар, хувийн хэвшил, өрхийн хөрөнгө оруулалт, хуримтлалаас илүүтэйгээр хэрэглээ нэмэгдэх хандлага даамжирвал урсгал тэнцлийг урт хугацаанд тогтворгүйжүүлэх эрсдэлтэйг анхаарах шаардлагатай юм.

Гадаад сектор

Гадаад эдийн засагт 2012 оны эхнээс бий болсон сөрөг нөхцөл байдал 2013 онд ч үргэлжилж, гадаад худалдааны нөхцөл өнгөрсөн гурван жилийн дундажтай харьцуулахад 2013 оны эхний найман сарын байдлаар 22 хувиар муудаж, экспортын эрэлт 10 хувиар буураад байна.

Дэлхийн эдийн засгийн төлөв (АНУ, Евро бүс) сайжрахгүй хэвээр байгаагаас Хятадын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт удааширч, эрдэс түүхий эдийн эрэлт, үнэд сөргөөр нөлөөлөв. Тухайлбал, 2013 оны эхний 7 сарын байдлаар дэлхийн зах зээлд коксжих нүүрсний үнэ оны эхнээс 32 хувиар, А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ 14 хувиар, төмрийн хүдрийн үнэ 17 хувиар тус тус буурсан.

Монгол Улсын төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2013 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.4 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өндөр байна. Өмнөх онуудад хөрөнгө оруулалтаар голлон санхүүжигдэж байсан тоног төхөөрөмж болон бараа материалын импорт, түүнчлэн өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт энэ онд буурсан нь нийт импортыг

9.7 хувиар бууруулж, барааны гадаад худалдааны алдагдал 17.5 хувиар багасгахад нөлөөлсөн хэдий ч, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 23.6 хувиар өссөн, орлогын дансны алдагдал тогтвортой байсан, урсгал шилжүүлэг 55.1 хувиар буурсан нь ийнхүү урсгал дансны алдагдал өсөхөд нөлөөлөв. 2013 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр урсгал дансны нийт алдагдлын 42.5 хувийг барааны худалдаа, 38 хувийг үйлчилгээний худалдаа, 23.2 хувийг орлогын дансны алдагдал, 3.7 хувийг урсгал шилжүүлэг тус тус бүрдүүлж байна.

Өнгөрсөн онд дэлхий дахинд хөрөнгө оруулалтын урсгал 18 хувиар буурсан, хөгжиж байгаа орнуудад Хятад улсаас хийсэн хөрөнгө оруулалт 50 хувиар багассан, бүс нутгийн хөрөнгө оруулалтын орчинд тодорхой бус байдал үүссэн, дотоодын хууль эрх зүйн орчинд гарсан сөрөг өөрчлөлт, хөрөнгө оруулалтын тогтворгүй, тодорхой бус байдлын улмаас Монгол дахь бага, дунд хэмжээний хөрөнгө оруулалт огцом буурсан, Оюу толгой төслийн ил уурхайн хөрөнгө оруулалтын үндсэн хэсэг хийгдсэн, далд уурхайн төслийн санхүүжилттэй холбоотой асуудал удааширсан зэрэг хүчин зүйлс нь Монголд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр дүнг оны эхний 8 сард 47 хувиар буюу 1.6 тэрбум ам.доллараар буурахад нөлөөлөв. Ингэснээр өмнөх онуудад урсгал дансны алдагдлыг бүрэн санхүүжүүлж байсан хөрөнгө, санхүүгийн тэнцлийн ашиг 48.9 хувиар буурч, төлбөрийн нийт тэнцэл 1.4 тэрбум ам.долларын алдагдалтай болоод байна.

Ийнхүү төлбөрийн тэнцэл, гадаад валютын улсын нөөц дэх дарамт нэмэгдсэн нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад нөлөөллөө. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2013 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 1,646.48 төгрөг болж, оны эхнээс 18.3 хувиар, төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 2013 оны 8 дугаар сарын байдлаар 9.5 хувиар тус тус суларсан байна. Харин төгрөгийн бодит үйлчилж буй ханш энэ оны 7 дугаар сарын байдлаар 1.2 хувиар суларч, урт хугацааныхаа тэнцвэрт түвшний орчимд ирсэн нь импортыг орлох дотоодын үйлдвэрлэл болон экспортыг дэмжих, үр ашиггүй, тэвчиж болох импортыг цаашид бууруулах, гадаад секторын эрсдэл, төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгах, улмаар эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадвар, дархлааг сайжруулах боломжийг бүрдүүлж байна.

Улсын төсвийн сектор

Гадаад эдийн засгаас дотоодын эдийн засагт үзүүлж буй өөр нэг сөрөг нөлөөлөл нь төлбөрийн тэнцэл, татварын орлого бүрдэлтээр дамжин улсын төсөвт ирэх дарамт юм. Энэ оны эхний 8 сард төсвийн зарлагын гүйцэтгэл 76.5 хувь, тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 94.8 хувийн биелэлттэй, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 131.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Орлогын гүйцэтгэл харьцангуй өндөр хувьтай гарсан нь төсвийн дахин төлөвлөлт хийж, тэнцвэржүүлсэн орлогыг 2013 оны батлагдсан төсвөөс 945.7 тэрбум төгрөгөөр бууруулсантай холбоотой байна. Цаашид 2013 оны төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс нэмж тасрах эрсдэлтэй хэвээр байна. Иймд төсвийг хэт өөдрөгөөр төсөөлөхгүй байх, төсвийн төлөвлөлтийг илүү бодитой, үндэслэл сайтай хийх нь чухал байгааг улсын 2014 оны төсөвт харгалзан үзэх нь зүйтэй байна.

Улсын төсөвт суугаагүй буюу түүнээс гадуур хийгдэж буй төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын огцом бууралтын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулж байгаа боловч энэ нь дунд, урт хугацаанд төсвийн дарамтыг нэмэгдүүлэхээр байна. Тухайлбал, 10 жилийн хугацаатай “Чингис” бондын хөрөнгөөр санхүүжигдэж байгаа дэд бүтцийн 5 төсөл (авто зам, дэд бүтэц, шинэ төмөр зам, Таван толгойн цахилгаан станц зэрэг)-ийн эргэн төлөлт болон хүүний төлбөр нь ирэх онуудын төсөвт суух бөгөөд эдгээр төслүүдэд нийтдээ 1,490 тэрбум төгрөг (921.7

сая ам.доллар) зарцуулахаар баталсан байна. Энэ нь 2013 оны ДНБ-ий хүлээгдэж буй гүйцэтгэлийн 8.8 хувьтай тэнцэх дүн юм. Иймээс “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн дагуу энэ оны төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй байхаар Засгийн газар үүрэг хүлээн ажиллаж байгаа нь улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд, хөрөнгө оруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагуудад Монгол улсын макро тогтвортой орчин хангагдахаар байна гэсэн итгэлийг төрүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын бонд болон түүний баталгаатай бондыг гадаад зах зээлд арилжаалан, эх үүсвэр бүрдүүлсэн нь өнгөрсөн 8 улирлын турш муудсан үзүүлэлттэй байгаа гадаад эдийн засгийн орчинд дотоодын санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад туйлын чухал нөлөө үзүүлсэн билээ. Гэхдээ урсгал тэнцлийн алдагдал буурахгүй байгаа өнөөгийн орчинд улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангаж, төлбөрийн тэнцлийн болон өрийн болзошгүй хямралаас сэргийлэхэд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөнгөний сектор

Банкны салбарын зээлийн өсөлт өнгөрсөн оны 4 дүгээр улирлаас эхлэн огцом буурч, санхүүгийн салбарт зээлийн тасалдал бий болох эрсдэл нүүрлэхээр байлаа. Санхүүгийн болон макро эдийн засгийн болзошгүй хямралаас сэргийлэх зорилгоор Монголбанкнаас сүүлийн 11 сарын турш хэрэгжүүлсэн цогц арга хэмжээний үр дүнд банкны салбарт зээлийн тасалдал бий болоогүй бөгөөд 2013 оны эхнээс мөнгө, зээлийн өсөлт тогтвортой байна. Энэ оны 1 дүгээр улирлаас хойшхи хугацаанд банкны салбарын зээлийн өсөлтийн хурд нэмэгдсээр 8 дугаар сарын байдлаар 46.6 хувийн өсөлттэй гарсан нь М2 мөнгөний 20.2 хувийн өсөлт болон нэрлэсэн ДНБ-ий 20.5 хувийн өсөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт болов. Зээлийн энэхүү өсөлтөд орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцооны хүрээнд шинээр олгогдож байгаа орон сууцны ипотекийн зээл, барилга, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр ба агуулахын салбарт олгогдож байгаа зээлүүд голлох нөлөөг үзүүлж байна. Хэдийгээр мөнгө, зээлийн үзүүлэлтүүд тогтворжиж, өсөх хандлагатай болсон ч, банкны системийн эрсдэлийг бууруулах, банкуудын төлбөрийн чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлийг даах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг Монголбанкнаас авах болно.

Макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, гадаад орчноос дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нэг салбараас хэт хамаарах хамаарлыг багасгах, эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дархлааг нь сайжруулах, дотоодын үйлдвэрлэл, хуримтлалд суурилсан, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахын тулд богино хугацаанд экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын урсгалыг сайжруулах арга хэмжээ авах, харин дунд болон урт хугацаанд импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх шаардлага гарч байна.

Иймээс эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв байдалтай уялдуулан мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн дархлааг сайжруулахад чиглэх нь зүйтэй гэж үзэн, дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2014 оны эцэст 8 хувь, 2015-2016 онд 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгана. Үүний үр дүнд дунд хугацаанд макро эдийн засаг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-д "Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино" гэж заасан нь үнийн тогтвортой байдлыг хангах буюу хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжигдэх инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах тухай зорилт юм.

Монголбанк санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх, макро тогтвортой байдлыг хангах, иргэдийн бодит орлогыг хамгаалах үүднээс 2014 онд инфляцийг 8 хувь, 2015-2016 онуудад 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгах зорилт тавьж байна.

2013 оны 8 дугаар сарын байдлаар инфляци улсын хэмжээнд 9.4 хувь, Улаанбаатар хотод 8.4 хувь болон буурч, энэ оны зорилтот түвшинтэй ойртлоо. Үүнд төсвийн тогтвортой байдал хангагдаж, эрэлтийн гаралтай инфляцийн дарамт бага байсны зэрэгцээ Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр"-ийн үр дүнд нийлүүлэлтийн буюу зардлын шалтгаантай инфляци мэдэгдэхүйц буурсан нь эерэгээр нөлөөлөв. Энэ оны инфляцийн зорилтыг хангах нь ирэх онуудад инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах суурийг бүрдүүлнэ.

Монголбанк дээрх зорилтод хүрэхийн тулд мөнгөний уламжлалт ба уламжлалт бус бодлого, арга хэрэгслийг хослуулан хэрэгжүүлэх замаар дотоодын үнийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийн бодит орлогыг хамгаалах болно.

Мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр"-ийг үргэлжлүүлж, үр дүнг цаашид сайжруулна. Учир нь Монгол Улсад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн механизм олон жилийн турш үр ашиг муутай, тогтвортой бус байснаас нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляци байнга өндөр байж, тэр нь хэрэглээний үнийн индексийн өсөлтийг олон жилийн турш хоёр оронтой тоонд байлгаж ирсэн юм. Өндөр инфляцитай орчинд эдийн засгийн тогтвортой өсөлт хангагдахгүй тул Монголбанкнаас нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах арга хэмжээг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсан билээ.

Иймээс "Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах", "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах", "Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах", "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах", "Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах" гэсэн 5 дэд хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна.

Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлснээр: (i) махны үнийн өсөлт өнгөрсөн 3 жилийн дунджаас 2.1 дахин бага, (ii) гурилын үнэ тогтвортой, (iii) 2011-2012 онуудад 190 төгрөг, 310 төгрөгөөр тус тус огцом өсч байсан А92 шатахуун, дизель түлшний үнэ маш тогтвортой, (iv) газрын тосны бүтээгдэхүүний биет нөөц өнгөрсөн 3 жилийн дунджаас 2.2 дахин нэмэгдсэн, (v) өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэх болон ачих хугацаа өнгөрсөн 3 жилийн дунджаас харгалзан 3.1 болон 2.2 дахин түргэссэн, (vi) суурь инфляци өнгөрсөн 3 жилийн дунджаас 5.9 хувиар

буурсан, (vii) хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляци өнгөрсөн 3 жилийн дундажтай харьцуулахад улсын хэмжээнд 3 нэгж хувиар, Улаанбаатар хотод 4.2 нэгж хувиар тус тус буурсан, (viii) эдийн засгийн бодит өсөлт дэх хувийн хэвшлийн оролцоо 127 хувиас 147 хувь болон өсч, Засгийн газрын оролцоо 12 хувиас 6 хувь болж буурсан, (ix) мөнгө, зээлийн үзүүлэлтүүд тогтвортой болсон, (x) эдийн засгийн бодит өсөлт тогтвортой өндөр түвшинд хадгалагдсан зэрэг үр дүнд хүрээд байгаа юм.

Суурь инфляци, импортлогдож буй инфляцийн нөлөөллийг багасгах зорилгоор Монголбанкнаас төгрөгийн орлоготой этгээдийн валютын ханшийн эрсдэлийг бууруулах санхүүгийн бүтээгдэхүүнийг илүү боловсронгуй болгож, түүний зах зээл дэх хэрэглээг нь нэмэгдүүлнэ. Ингэснээр валютын ханшийн өөрчлөлтийн инфляцид үзүүлэх нөлөөллийг сулруулж, инфляцийн дунд, урт хугацааны зорилтод хүрэх боломжийг эрс сайжруулах юм.

Улсын төсөв тогтвортой, гадаад валютын урсгал өнөөгийнхөөс эрс сайжирсан орчинд Монголбанк импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллана. Ингэхдээ чанартай ажлын байрыг олноор бий болгодог эдийн засгийн бодит сектор дахь урт хугацаатай хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлээр дамжуулан нэмэгдүүлэх зарчим баримтална. Ингэснээр дотоодын үйлдвэрлэл хөгжих, чанартай, тогтвортой ажлын байрны тоо нэмэгдэх, дундаж давхаргын хүрээ тэлэх, үндэсний хэмжээнд хуримтлал өсөх, эдийн засгийн дархлаа сайжрах бөгөөд эдгээр нь цогцоороо инфляцийг дунд, урт хугацаанд нам, тогтвортой түвшинд байлгах зорилтод хүргэх болно.

Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангахдаа санхүүгийн тогтвортой байдлыг онцгойлон авч үзнэ. Учир нь мөнгөний бодлого зөвхөн санхүүгийн эрүүл, тогтвортой системээр дамжин үр дүнтэй хэрэгжих боломжтой. Иймд Монголбанк банкны салбарын төлбөрийн чадварыг хадгалж, системийн хяналт шалгалт, зохистой харьцааны дүрэм журмыг сайжруулан, санхүүгийн секторт итгэх итгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Санхүүгийн тогтвортой байдалд чухал нөлөөлөх үзүүлэлт болох орон сууцны үнийн индекс (ОСҮИ)-ийг хараат бус байгууллагаар сар бүр үнэн зөв тооцуулах, улмаар олон нийтэд зарлах ажлыг Монголбанк зохион байгуулна. Үүний сацуу банкны зээлийн хүү тооцох олон улсын жишигт суурилсан аргачлалыг боловсруулж, банкуудаас зээлийн хүүний бодит дарамтыг харилцагчдад үнэн зөвөөр танилцуулдаг байх тогтолцоог нэвтрүүлнэ. Ингэснээр банк санхүүгийн үйлчилгээг иргэдэд жигд, хүртээмжтэй болгох, иргэдийн санхүүгийн суурь боловсролыг нэмэгдүүлэх юм.

Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх ажлыг цаашид Монголын Ипотекийн корпораци, Барилга, хот байгуулалтын яам, банкуудтай хамтран гүйцэтгэнэ. Энэ тогтолцооны хүрээнд үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжиж, Нийгмийн даатгалын сан дахин хөрөнгөжиж, хөдөлмөрийн зах зээл, татвар, шимтгэлийн орчин илүү ил тод болно. Ингэснээр тус сангийн орлого нэмэгдэхийн зэрэгцээ тогтолцоог хэрэгжүүлэгч талууд санхүүгийн хувьд үлэмж чадавхижих ба уг тогтолцоо нь цаашдаа Монголбанкны оролцоогүйгээр тогтвортой хэрэгжих боломж бүрдэнэ. Монголбанкнаас орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий

болгосноор иргэдийн орлого хэрэглээнээс хуримтлал руу шилжих болно. Иргэдийн хөдөлмөрийн хөлс, үнэлгээ, бүтээмж нэмэгдэж, эдийн засгийн ил тод, тунгалаг байдал бүхэлдээ сайжран, Нийгмийн даатгалын сангийн хуримтлал өснө. Энэ бүхэн нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж, хэрэглээний үнийн индексийг 2014 оны зорилтот 8 хувь, дунд хугацааны зорилтот 7 хувьд байлгахад чухал ач холбогдолтой байх юм.

Хэдийгээр Монголбанк инфляцийг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт албан ёсоор шилжээгүй байгаа хэдий ч, уг бодлогын онцлог, давуу тал болох макро эдийн засгийн хэтийн төлөвт суурилан, ирээдүйг харсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлж хэвших, инфляцийн зорилтыг хангах замаар инфляцийн хүлээлтийг төлөвшүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд Монголбанк ЕСБХБ-ны техник туслалцаагаар OGREsearch байгууллагатай хамтран “Төсөөлөл бодлогын шинжилгээний систем (FPAS)”-ийг хөгжүүлж байна. Энэхүү систем нь инфляцийн төсөөллийг онилох тогтолцоонд шилжихээр зэхэж буй орнуудын бодлогын шийдвэр гаргалтыг дэмжихэд чухал ач холбогдолтой. Улирлын төсөөллийн загвар нь микро үндэслэл сайтай, хүлээлт агуулсан тул эдийн засгийн харилцан хамаарлыг бүхэлд нь нэгтгэж үзүүлдгээрээ давуу талтай юм. Тус загварыг ашиглан төсөөлөл хийх тогтолцоог 2014 онд нэвтрүүлснээр бодлогын хариу үйлдэл, эдийн засаг дахь сөрөг нөлөөллийн шалтгаан, эдийн засаг хэрхэн ажилладаг талаарх төрөл бүрийн таамаглалуудаас гарсан эрсдэлүүдийг авч үзэх боломжтой болж, мөнгөний бодлогын шийдвэр гаргалт улам бүр сайжрах юм.

Үнийн тогтвортой байдлыг хангах нь Төв банкны зүгээс эдийн засгийн өндөр, тогтвортой өсөлтөнд оруулж буй үндсэн хувь нэмэр билээ. Иймд Монголбанк инфляцийг боломжит нам, тогтвортой түвшинд байлгаснаар дунд хугацаанд эдийн засаг тогтвортой өсч, иргэдийн бодит орлого, ажлын байр хамгаалагдах, санхүүгийн тогтолцоо үр ашигтай ажиллах орчин бүрдэнэ гэж үзэж байна.

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.

Ханш уян хатан тогтох нь гадаад зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, экспортын болон дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжих замаар урт хугацааны өсөлтөд эерэгээр нөлөөлнө.

Дэлхийн улс орнуудын сүүлийн 30 гаруй жилийн хандлагаас харахад гадаад зах зээлийн огцом өөрчлөлтийн үндэсний эдийн засагт учруулах сөрөг нөлөөлөл нь уян хатан, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмтэй орнуудыг ханшаа тогтмол түвшинд, тодорхой хязгаарт барьдаг орнуудтай харьцуулахад 1.5 дахин бага, нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт нь дунджаар 0.85 хувиар өндөр байсан байна¹.

Сүүлийн жилүүдэд манай улс урсгал дансны алдагдлаа гадаадын хөрөнгө оруулалтаар бүрэн санхүүжүүлж ирсэн бол 2013 онд гадаад худалдааны нөхцөл, гадаад эдийн засгийн орчин муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үеэс үлэмж буурсан зэрэг нь төлбөрийн тэнцлийг муутгаж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамтыг бий болгосон билээ.

¹ Kanda Naknoi, Real exchange rate fluctuations, endogenous tradability, and exchange rate regime, 2006

Монголбанкнаас энэ нөхцөлд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг тууштай баримтлан, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр валютын захад оролцож байсны үр дүнд гадаад зах зээлийн дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, гадаад худалдаанд шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлэн, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлээ удирдах боломжийг хувийн хэвшилд олгосон юм.

Цаашилбал, уян хатан ханшийн бодлого нь үнийн тогтвортой байдлыг хангах замаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чухал урьдач нөхцөл болдог билээ. Ханшийн өнөөгийн төлөв байдал нь импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулах, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, төлбөрийн тэнцэл, нийт эдийн засгийн дархлаа, өрсөлдөх чадварыг сайжруулах таатай орчинг бүрдүүлж байна.

Валютын ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэхгүй байгаа үед төлбөрийн тэнцэл тогтворгүй болох, ханшийн хямрал, довтолгооны эрсдэл өсөх, санхүү, эдийн засгийн хямралын эрсдэл нэмэгдэх, үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар буурах, урт хугацаанд эдийн засгийн дархлаа нь суларч, байнгын тогтворгүй эдийн засагтай болох зэрэг сөрөг нөлөөтэй байна. Энэ нь Азийн орнуудад тохиолдож байсан ханшийн хямрал, 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас тодорхой харагддаг билээ.

Гадаад зах зээлээс шалтгаалан дотоодын эдийн засагт үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих нэг суурь нөхцөл нь уян хатан ханшийн өнөөгийн бодлогыг тууштай баримтлах явдал гэж үзэж байна. Иймд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг Монголбанк үргэлжлүүлэн баримтлах болно.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2.1 Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, үүсч болзошгүй системийн шинжтэй эрсдэлийг даах чадварыг нэмэгдүүлнэ.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтийг нэмэгдүүлсэн, банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2 дахин өсгөсөн зэрэг арга хэмжээний үр дүнд банкны системийн эрсдэл даах чадвар нэмэгдэж байгаа бөгөөд цаашид гадаад болон дотоод хүчин зүйлийн өөрчлөлт, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банкны салбарын төлбөрийн чадварыг хадгалах, тогтвортой хөгжлийг хангах арга хэмжээг үргэлжлүүлэн авч ажиллана. Банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг эдийн засгийн мөчлөг, үүсч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, банкны үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшинтэй уялдсан байх шаардлагыг шат дараатайгаар нэвтрүүлнэ.

Банкны эрсдэл даах чадварыг илэрхийлдэг өөрийн хөрөнгийн зохистой харьцааг тооцоход ашиглагдах аргачлал, өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын бүтэц, ангиллын талаарх шаардлагатай мэдээллийг нийтэд ил тод болгох, тодорхой бус байдлыг арилгах, Монголбанкнаас арилжааны банкуудад хийж буй хяналт шалгалтын үйл ажиллагааг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчмуудтай нийцүүлэх ажлыг үргэлжлүүлэх, банкны үйл

ажиллагаанд хийгдэх хяналт шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх болно.

Банкны эрсдэлээр жигнэсэн активыг тооцоход эрсдэл өндөртэй салбарт олгож буй зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлж, улмаар банкуудын зээлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бодитоор үнэлнэ.

Банкуудын гадаад валютаар татсан эх үүсвэр нэмэгдэхэд үүсч болзошгүй эрсдэлийг тогтворжуулах, нийт системд учрах хохирлыг бууруулах зорилгоор гадаад валютын эх үүсвэрийг банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт тохируулан актив хөрөнгөд оновчтой байршуулах макро-зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглах боломжийг судалж нэвтрүүлэх юм.

Банкны салбарын хөрөнгийн эх үүсвэр харилцах, хадгаламж давамгайлсан, хугацааны хувьд богино хэвээр байсаар байна. Энэ нь урт хугацаатай, томоохон хэмжээний хөрөнгө оруулалт, зээл олгох бололцоог бууруулах бөгөөд нөгөө талаас хугацааны зөрүүнээс хамаарсан хөрвөх чадварын эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймд банкны салбарын хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах, хөрөнгө гэнэт гадагшлах эрсдэлд оруулахгүй байлгах зорилгоор хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, төлбөрийн чадварын хүндрэлийг даван туулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2 Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг сайжруулна.

Базелийн хяналт шалгалтын хорооноос гаргасан банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартад нийцүүлэн Монголбанкнаас 2013-2019 онд хяналт шалгалтын үйл ажиллагааны талаар баримтлах дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулсан бөгөөд энэхүү стратегид тусгасан ажлын төлөвлөгөөтэй уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх юм.

Банкны хяналт шалгалтыг банкуудын системд үзүүлэх нөлөө, эрсдэлийн түвшинтэй уялдуулан үр ашигтай хуваарилах тогтолцоог бүрдүүлэх нь эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх гол хүчин зүйл бөгөөд энэхүү нөхцөлийг бүрдүүлэхэд холбогдох хууль эрх зүйн орчин, санхүүгийн дэд бүтцийг боловсронгуй болгох шаардлагатай. Үүнтэй уялдан банкны тухай хууль тогтоомжид оруулах шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг Хяналт шалгалтын дунд хугацааны стратегитай уялдуулан боловсруулах болно.

Монголбанкнаас банкны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн өөрийн орны банк санхүүгийн үйл ажиллагааны онцлогт тохируулж "Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал"-ыг боловсруулсан бөгөөд 2014 оноос нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр банкны салбарын санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, тайлан тэнцэл нь бизнесийн үйл ажиллагааг бодитой илэрхийлдэг байх, банкны эрсдэлийн удирдлагыг сайжруулах, үйл ажиллагаа нь банкны хөрөнгө оруулагч, харилцагчдад ил тод, ойлгомжтой байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

“Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн баталж,

Монголын банкны салбарт зохистой удирдлага, компанийн засаглал хөгжих үндсийг тавьсан бөгөөд банкны зохистой засаглалын хэм хэмжээг бүрэн биелүүлэх шаардлагыг банкуудад тавьж, хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, зайнаас хяналт тавин ажиллаж байна. Банкны зохистой засаглалыг сайжруулах, банкны харилцагч, зах зээлийн бусад оролцогчийн зүгээс банкинд тавих хяналтыг сайжруулах зорилгоор банкны зохистой засаглалын үнэлгээний аргачлалыг Базелийн хорооноос гаргасан стандарт болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын компанийн засаглалын үндсэн зарчмуудтай нийцүүлэн боловсруулж, мөрдүүлж ажиллана.

2.3 Банкны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн эрх зүйн орчинг шинэчилнэ.

Зээлийн барьцаа хөрөнгийн өмчлөх эрхийг банкны мэдэлд шилжүүлэхэд их хэмжээний зардал, хугацаа зарцуулдаг түгээмэл зөрчлийг арилгах, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг оновчтойгоор хангуулах зорилгоор Монгол Улсын нэр бүхий 7 хуулийн 59 зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулаад байгаа бөгөөд УИХ-д зохих журмын дагуу өргөн барьж батлуулна.

Барьцаа хөрөнгийн худалдан борлуулах эрхийг банкинд шуурхай шилжүүлэх боломжийг хангаснаар банкны үндсэн үйл ажиллагааны эрсдэл буурч, өмнө нь зарцуулж байсан үр ашиггүй зардлыг хэмнэж, банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, улмаар зээлийн хүүг бууруулах зэрэг эерэг нөхцөл бүрдэх юм.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2014-2016 онд эрчимжүүлнэ.

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлттэй холбоотойгоор төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Төлбөрийн системийн оролцогч хооронд 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 33.3 их наяд төгрөгийн 9.5 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс гүйлгээний дүн 78 хувиар буюу 14.6 их наяд төгрөгөөр, гүйлгээний тоо 2.3 дахин буюу 6.7 сая ширхэгээр өссөн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн картаар 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар нийт 731 тэрбум төгрөгийн, 14.6 сая ширхэг гүйлгээ хийгдэж, өмнөх оны мөн үеийнхээс картын гүйлгээний дүн 280.7 тэрбум төгрөг буюу 42 хувиар, картын гүйлгээний тоо 4.3 сая ширхэг буюу 62 хувиар тус тус өсчээ.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагаа нэн чухал юм.

Иймд 2014-2016 онд санхүүгийн цогц үйлчилгээг иргэн бүрт, үр өгөөжтэй, найдвартай хүргэх төлбөрийн системийн шинэчлэлийг эрчимжүүлнэ. Уг ажлын хүрээнд бэлэн бус төлбөр тооцооны чип, соронзон тууз, зайнаас хандах технологи

хосолсон карт гаргах, үндэсний брэнд Т картад тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлэх, гар утастай холбох, иргэний ухаалаг үнэмлэхийг төлбөр тооцоонд ашиглах, интернетийн орчинд төлбөр хийх боломжийг боловсронгуй болгох ба хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлнэ.

Үүний үр дүнд банкны үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжоор хязгаарлагдмал иргэдэд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн үйлчилгээг шуурхай хүргэж, бэлэн бус төлбөр тооцооны хүртээмжийг нэмэгдүүлэх юм.

3.2 Санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлнэ.

Санхүү, банкны салбарын өсөлт эрчимжиж байгаа өнөө үед санхүүгийн салбарын 95 хувийг дангаараа эзэлж байгаа банкуудын найдвартай, тогтвортой байдлыг хангах, санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, шударга өрсөлдөөнийг бэхжүүлэх зорилгоор банкуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэж байгаа харилцагч, хадгаламж эзэмшигч нарын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага бий болж байна.

Энэхүү шаардлагыг хангаснаар иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх боломжтой болно.

Дэлхийн банкнаас 2012 оны эхний хагаст Монгол Улсын санхүүгийн салбар дахь бүтээгдэхүүн үйлчилгээг хүртэж буй харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал болон тэдгээрийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын өнөөгийн байдлыг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа хийсэн. Уг судалгаанд Монголын эрх бүхий байгууллагуудаас харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал болон харилцагчдын банк санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг дутмаг байгаа талаар дүгнэлт хийсэн бөгөөд цаашид энэ талаарх холбогдох зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах, бусад шаардлагатай арга хэмжээ авах санал зөвлөмжүүдийг өгсөн.

Иргэдийн санхүү, банкны суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар зэрэг төр захиргааны байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг үе шаттайгаар, нэгдсэн бодлогын хүрээнд нийгмийн давхарга, тэдгээрийн ерөнхий боловсролын түвшинтэй нь уялдуулан боловсруулж эхэлнэ. Банкны үйлчилгээг хүртэж байгаа харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор банкуудын Ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, харилцагчдаас ирэх санал гомдлыг шийдвэрлэх, иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг хариуцан ажиллана. Түүнчлэн шинэ бүтээгдэхүүн, санхүүгийн хэрэгсэл, ажил үйлчилгээ олноор бий болж байгаагаар уялдан мобайл банк, интернет банк, электрон мөнгөн гүйлгээний үйл ажиллагааг зохицуулах болон харилцагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангах замаар бодлогын үр нөлөөг сайжруулна.

Орчин үеийн Төв банкны салшгүй хэсэг нь олон нийттэй харилцах харилцаа, нээлттэй ил тод байдал билээ. Төв банкнаас эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэн, хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдээ олон нийтэд зөв тайлбарлах нь мөнгөний бодлогын шийдвэр гаргасан үндэслэл, шалтгааныг санхүүгийн зах зээлд оролцогчид болон олон нийт зөв ойлгох, түүнд зөв хариу үйлдэл үзүүлэх боломж олгох төдийгүй эргээд мөнгөний бодлогын хэрэгжилт, түүний үр дүнд эерэгээр нөлөөлнө.

Монголбанкнаас 2012 оны 10 дугаар сард “Мөнгөний бодлогын зөвлөл”-ийг шинээр байгуулан ажиллуулж, мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, бодлогын арга хэрэгсэл, түүний шилжих механизм, үр дүнгийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулж ажиллалаа. Энэ нь мөнгөний бодлогын үр нөлөөг эрс сайжруулж байгаа тул мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, бодлогын арга хэрэгслийн ил тод, нээлттэй байдлыг цаашид үргэлжлүүлж, иргэдийн Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 57 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

(2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар)

2. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) нь макро эдийн засгийн төлөв байдал, эдийн засагт учирч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд, бодлогын харилцан уялдааг хангах тухай болон цаг үеийн шинжтэй асуудлаар зөвлөлдөж, хамтарсан тушаал, шийдвэр гаргаж ажиллалаа.

СТБЗ-ийн 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд санал боловсруулах, “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсэн. Энэ дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба (СТБЗАА)-ыг Монголбанкинд төвлөрүүлж, 5 хүний орон тоотой ажиллуулж байна.

Сангийн яаманд Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа MSTAR төслийн хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, түүний ажлын албаны чадавхийг сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын зөвлөхийг тус зөвлөлийн Ажлын албатай хамтран ажиллуулав. Энэ хүрээнд санхүүгийн тогтвортой байдлын асуудал эрхэлсэн институцийн хэм хэмжээ, бусад орны сайн туршлага, санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд өгөх үнэлгээ дүгнэлт, бодлогын болон техникийн түвшинд учирч буй асуудлууд зэрэг өргөн хүрээг хамарсан эхний шатны тайлан гарч, Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороог хамарсан хоёр удаагийн семинарыг зохион байгууллаа.

СТБЗАА нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээлэл хүлээн авч, **“Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан-2012”**-г нэгтгэн боловсруулав. Уг тайланг хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж, олон нийтийн хүртээл болгоод байна. СТБЗАА санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн хоёр дахь дугаарыг 2013 оны эхний хагас жилийг хамарсан байдлаар боловсруулж байна. Уг тайланг 2013 оны 11 дүгээр сард нийтэд мэдээлнэ.

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн явц байдал, Засгийн газартай хамтарсан хөтөлбөрүүдийн үр дүн, банк санхүүгийн салбарын байдлыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо (ЭЗБХ)-нд улирал бүр тайлагнаж байна. Макро эдийн засгийн төлөв хандлага, Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлого, эдийн засагт учирч буй эрсдэлийн талаар Монголбанкнаас УИХ-ын ЭЗБХ-нд 2013 оны 4 дүгээр сард дэлгэрэнгүй танилцуулга хийсэн. Түүнчлэн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд **“Эдийн засагт тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам”** сэдэвт илтгэл, танилцуулга, саналыг 2013 оны 2 болон 8 дугаар саруудад тус тус танилцуулж, холбогдох зөвлөмж, чиглэл, шийдвэрийг тус зөвлөлөөс гаргуулан ажиллалаа. Монголбанк санхүүгийн салбар, гадаад сектор, макро эдийн засгийн талаарх тайлан мэдээ, статистик мэдээлэл, судалгаа шинжилгээг боловсруулж, өдөр, сар, улирлын давтамжтайгаар, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол түгээж байна.

3. Иргэдийн өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээ авч, үнийг тогтворжуулах цогц механизм боловсруулах.

Монгол Улсад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн механизм олон жилийн турш үр ашиг муутай, тогтвортой бус байснаас нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляци байнга өндөр байсаар ирсэн. Иймд Монголбанк инфляцийг бууруулж, иргэдийн бодит орлогыг хамгаалах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах замаар гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, улмаар зах зээлийн зарчимд суурилсан, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн байнгын, тогтвортой тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон юм.

Дээрх зорилтын хүрээнд Монголбанк, Засгийн газар хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталж², энэ хүрээнд дараах дэд хөтөлбөрүүдийг хувийн хэвшлээр дамжуулан хэрэгжүүлж, үр дүнд хүрч байна. Тухайлбал:

• Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (FPS) дэд хөтөлбөр

Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах хөтөлбөр: Дэд хөтөлбөрийн хүрээнд хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагаанд шинэ тогтолцоо нэвтрүүлэн, амжилттай зохион байгуулж дуусаад байна.

ҮХААЯ-наас Улаанбаатар хотод “Жаст Агро” ХХК, Дархан хотод “Баатрууд тэнгэр”

² Төвбанкны тухай хууль, УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус үндэслэсэн.


ХХК, Эрдэнэт хотод “Эрдмийт” ХХК-ийг нөөцийн махны менежерээр сонгон шалгаруулж, 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллав.

Хөтөлбөрт оролцогч банкууд нь ҮХААЯ-наас сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан нөөцийн махны менежер компаниудад махны нөөц бүрдүүлэхэд зориулж 87 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон бөгөөд олгогдсон зээл бүхэлдээ компаниудаас банкинд, банкнаас Монголбанкинд бүрэн төлөгдсөн.


Тухайлбал, дэд хөтөлбөрийн хүрээнд 11,446.1 тонн махны нөөц бэлтгэснээс Дархан хотод 1025.1 тонн, Эрдэнэт хотод 1016.1 тонн мах нөөцөлж, нийт нөөцийг 100 хувь борлуулжээ. Эдгээр хотууд дахь нөөцийн менежерүүд нь нөөцийн махны худалдан авалтад 5.45 тэрбум төгрөгийн зээл авч, төлбөрийн хуваарийн дагуу 7 дугаар сарын эцэст зээлийг бүрэн төлж дууссан байна. Улаанбаатар хотод 9405 тн мах нөөцөлж, борлуулалт нь 7 дугаар сард 88.1 хувь байлаа. Жаст Агро ХХК 76.1 тэрбум төгрөгийн зээл авч, үүнээс ашиглаагүй байсан зээлийн үлдэгдэл болох 22.5 тэрбум төгрөгийг 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зээл олгогч банкинд буцаан төлсөн. Мөн 2013 оны 7 дугаар сарын 2-ны өдөр хүртэлх борлуулалтын буцаалтаар нийт 29 тэрбум төгрөгийг эргүүлэн төлсөн. Зээлийн үлдэгдэл болох 24.7 тэрбум төгрөгийг 2013 оны 7 дугаар сард буцаан татсанаар махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах зорилгоор олгосон 87 тэрбум төгрөгийн зээл бүрэн төлөгдөж дууссан болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд буюу 2012 оны 10 дугаар сараас 2013 оны 7 дугаар сарын хооронд махны дундаж үнийн өсөлт өмнөх оны мөн үеэс 2 дахин бага байна. Мөн үхрийн цул махны үнийн жилийн өсөлт 2013 оны 7 дугаар сард өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 2.5 дахин бага, үхрийн ястай махны үнийн жилийн өсөлт 2.2 дахин бага, хонины махны үнийн жилийн өсөлт 3.4 дахин бага байна (Зураг1).

Зураг 1: Махны үнийн жилийн өсөлт, 7 дугаар сард



Эх сурвалжууд: УСХ



Мах, махан бүтээгдэхүүний жилийн инфляцийн түвшин 2013 оны 7 дугаар сарын байдлаар 6.2 хувьтай байгаа нь өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 3.7 дахин бага байгаа юм.

Гурилын үнийг тогтворжуулах хөтөлбөр: Гурилын үйлдвэрүүдийн улаан буудай худалдан авах зардлыг хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх замаар гурилын нөөц бүрдүүлэх, нөөцийн чанар, борлуулалтад хяналт тавих ажлуудыг хэрэгжүүлж байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас дотоодын банкуудаар дамжуулан нийт 61 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн шугамыг 36 гурилын үйлдвэрт нээхээр төлөвлөсөн бөгөөд 2013 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар банкууд Засгийн газартай гэрээ байгуулсан 24 гурилын үйлдвэрт 48.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гурилын үйлдвэрүүд үр тарианы нөөцөө барьцаалж эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авах, агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлж, хүнсний бүтээгдэхүүний хангамжийн зах зээлийн механизмд суурилсан байнгын тогтолцоо бүрдэнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 4.1 тэрбум төгрөгийн зээлийг банкуудад, банкуудаас Монголбанкинд буцаан төлсөн байна. Ингэснээр банкуудаас олгосон зээлийн үлдэгдэл 44.6 тэрбум төгрөг болов. Зээл эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлөгдөнө.

2013 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хөтөлбөрт хамрагдсан гурилын үйлдвэрүүдийн буудайн үлдэгдэл 34.8 мян.тн, үйлдвэрлэсэн гурил 60.1 мян.тн, гурилын үлдэгдэл 7.3 мян.тн бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд 62.9 мян.тн гурилыг ҮХААЯ-тай байгуулсан гэрээнд заасан үнэ болох 525 төгрөгөөр борлуулжээ. Энэ нь дотоодод үйлдвэрлэсэн гурилын үнэ оны эхнээс тогтвортой байхад эерэгээр нөлөөлөв.

Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд инфляци буурч, хөдөө аж ахуйн салбарын бодит өсөлт 2013 оны эхний хагаст **21** хувьд хүрч, тогтвортой өндөр өсөлтөө хадгалсан. Мөн оны эхний улиралд 1 хувийн бууралттай байсан бөөний ба жижиглэнгийн худалдааны салбар болон огт өсөлтгүй зогсонги байсан тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 2-р улиралд харгалзан **7** хувь, **11** хувийн бодит өсөлттэй гарлаа.

• ***Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах (HPS) дэд хөтөлбөр***

Тус хөтөлбөрийг Барилга, хот байгуулалтын яамтай хамтран 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дараах үндсэн чиглэл, зорилттойгоор хэрэгжүүлж байна:

Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах:

- Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
- Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах;
- Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих;
- Орон сууцны барилгын нийлүүлэлтийг дэмжих.

Энэ хүрээнд Засгийн газартай гэрээ байгуулсан барилгын материал үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөх боломжийг олгох, барилгын гол нэрийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад зориулж 68 компанид 166.7 тэрбум төгрөг, зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгахад зориулж 55 компанид 125.4 тэрбум төгрөг, нийт 292.1 тэрбум төгрөгийн зээлийг банкуудаар дамжуулан олгоод байна. Засгийн газартай гэрээ байгуулсан, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд нь БХБЯ-тай байгуулсан гэрээнд заасан үнээр цемент, арматурыг борлуулж байгаа нь дотоодын зах зээлд эдгээр бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад эерэгээр нөлөөлж байна. Хөтөлбөрийн үр дүнд цаашид цемент, арматур зэрэг барилгын гол нэр төрлийн материалын нийлүүлэлтийн дийлэнх хэсгийг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой болох юм.

Монголбанк оны эхнээс инфляцийг бууруулах, банкны салбарын чадавхийг бэхжүүлэх, санхүүгийн болзошгүй хямралын эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлсний зэрэгцээ эдийн засгийн идэвхжил, бодит секторыг дэмжих арга хэмжээ авсан. Тухайлбал, барилгын салбарыг дэмжих, орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк гэрээний үндсэн дээр банкуудад зөвхөн орон сууцны барилгын зээлд ашиглагдах 429.5 тэрбум төгрөгийн зээлийг 7 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай олгосон. Үүнээс 2013 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар банкууд 411.2 тэрбум төгрөгийг 79 компанид олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 318.6 тэрбум төгрөгийн зээлийг олгосон мэдээтэй байна. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр орон сууцны барилгын нийлүүлэлт нэмэгдэж, орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх урьдач нөхцөл хангагдах юм.

Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд инфляци буурч, 2012 оны эхний хагаст 21 хувиар өсч байсан барилгын салбар энэ оны 2 дугаар улиралд **154** хувийн, эхний хагаст **129** хувийн бодит өсөлттэй гарлаа.

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох:

Инфляци буурч макро тогтвортой байдал хангагдсан, банкуудын өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтүүд сайжирч банкны салбар бэхжсэн, санхүүгийн салбарыг зээлийн тасалдал, болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлсэн, орон сууцны барилгын нийлүүлэлт болон эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжсэн орчинд Монголбанкнаас нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх зорилгоор “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоо”-г хэрэгжүүлж эхэлсэн юм.

Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг Монголбанк Засгийн газартай 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. Энэ хүрээнд Монголбанкнаас 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын дагуу ерөнхий гэрээг банкууд болон МИК-тай байгуулж, өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхэд болон шинээр ипотекийн зээл олгоход зориулж 1.1 их наяд төгрөгийг банкуудад байршуулсан болно.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийг 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхлэв. Үүнээс банкууд 2013 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 16,080 зээлдэгчийн 449.2 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, зээлийн хүүг 8 хувьд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ хугацаанд банкууд 7518 иргэнд 443.7 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгожээ.

Хүснэгт 1: Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцооны хэрэгжилт

	2013 он							8 сар/ 5 сар (%)
	5-р сар	6-р сар	сар (%)	7-р сар	сар (%)	8-р сар	сар (%)	
Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээл (тэрбум төг.)	62	68	9%	168	149%	213	26%	
Нийт ипотекийн зээлийн үлдэгдэл (тэрбум төг.)	986	1,054	7%	1,222	16%	1,434	17%	45%
Нийт зээлдэгчдийн тоо	32,247	33,028	2%	37,750	14%	40,596	8%	26%
Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү (%)	16.6	12.9	-22%	9.2	-29%	8.9	-3%	-46%
Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	148	168	14%	202	20%	208	3%	40%

Эх сурвалжууд: Монголбанк, банкуудын тайлан мэдээлэл, УСХ

Ийнхүү орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор Монгол Улс хэрэглээний эдийн засгаас хуримтлалтай эдийн засагт шилжих, нийгмийн дундаж давхаргын хуримтлал, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хүрээг тэлэх, бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлнэ. Уг тогтолцоо нь эргээд урт хугацаанд инфляцийг бууруулахад эерэгээр нөлөөлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангах болно.

• **Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах TLF дэд хөтөлбөр**

Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго: Монгол Улсын гадаад худалдааны тээвэр, логикийн өндөр зардал, хүчин чадлын дутагдалтай байдал нь бүтээгдэхүүний үнийг өсгөх, нийлүүлэлтийн хомсдлыг үүсгэх байдлаар олон жилийн турш инфляцид сөргөөр нөлөөлж байлаа. Иймд өргөн хэрэглээний импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор гадаад худалдааны тээвэр, логикийн дэд бүтцийг сайжруулах шаардлагатай болсон.

Дээрх шаардлага, зорилгыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Зам, тээврийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан тушаалаар “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь дунд хугацаанд хэрэгжих бөгөөд төмөр замын үйлчилгээг сайжруулах, хөнгөвчлөх зорилгоор гадаад, дотоод харилцааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлэхийн сацуу нийт 303 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр дараах арга хэмжээг санхүүжүүлэхээр дэд хөтөлбөрт тусгасан.

1. Вагоны паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	136 тэрбум төгрөг
2. Зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	95 тэрбум төгрөг
3. Шатахууны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх	22 тэрбум төгрөг
4. Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх	50 тэрбум төгрөг

Хэрэгжилтийн байдал:

- Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн шатахууны эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэхээр 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан жилийн 3.8 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 22 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлт Замын-Үүдээс Улаанбаатар

чиглэлд 2-3 хоног байсныг 1 хоногт багтаан тээвэрлэдэг болгон хурдасгасан.

- Замын-Үүд өртөө, Замын-Үүд шилжүүлэн ачих ангийн ачилтын технологийн цаг 24 байсныг 11 цаг болгон бууруулснаар, ачигдсан вагонууд тухайн өдөртөө хатуу зурмагт галт тэргэнд холбогддог болсон.
- Цементийн тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулснаар Улаанбаатар хотод 1 тонн цементийн бөөний үнэ 130,000 /нэг зуун гучин мянга/ орчим төгрөг болж, тогтвортой байна.
- Нэг цэгийн үйлчилгээ бий болгох, цаасгүй технологийг нэвтрүүлэх, үйлчилгээг хөнгөн шуурхай болгох зорилгоор Замын-Үүд шилжүүлэн ачих ангид ачаа тээврийн програм, автомашины дараалал хянах програм хангамж шинээр хийлгэж ашиглалтад оруулсан.
- Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тодорхой ажлуудыг гүйцэтгэж, “Улаанбаатар төмөр зам”-ын бүтцийг шинэчлэх талаар санал боловсруулах Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
- “Улаанбаатар төмөр зам”-ын хэмжээнд зардал бууруулах талаар Замын даргын баталсан тушаалын дагуу бүх аж ахуйн нэгж түлш, цахилгаан, уур, ус, бусад зардлыг хэмнэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.
- Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах, үнэлэх ажлын хүрээнд 2013 оны 7 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн галт тэргээр үйлчлүүлэгч нийт 214 зорчигч, Замын-Үүд боомтын шилжүүлэн ачих терминалууд дээрх тээврийн үйлчилгээ үзүүлдэг 43 жолоочоос санал асуулгын түүвэр судалгаа авах, шилжүүлэн ачих байгууламжийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, Хилийн бүсийн ГЕГ болон МХБ-ын байцаагч нартай уулзаж, нөхцөл байдалд үнэлгээ хийсэн болно. Түүвэр судалгааны үр дүнг нэгтгэж, дэд хөтөлбөрийн зорилтын биелэлтийг үнэлбэл дараах байдалтай байна:
 - Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж, хурдасгах (сайн)
 - Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулах (дунд)
 - Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх (хийгдэж байна)
 - Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх (дунд)

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд өргөн хэрэглээний импортын бараа бүтээгдэхүүн Замын-Үүд боомтоос Улаанбаатар хотод 24 цагийн дотор тээвэрлэгдэн хүргэгддэг болсноор импортын бүтээгдэхүүний өртөг дэх дэд бүтцийн хязгаарлалтаас шалтгаалсан сөрөг нөлөөллийг үлэмж бууруулж байна. Ингэснээр суурь инфляци бага байх нөхцөл бүрдэнэ.

Одоо хийгдэж байгаа ажил:

- "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгт шаардлагатай ачааны 400 хагас вагон, 60 битүү вагон, гол замын 3 зүтгүүр, сэлгээний 3 зүтгүүрийг 70 тэрбум төгрөгийн зээлээр худалдан авах асуудал Ерөнхий хорооны хурлаар дэмжигдэн, улмаар ОХУ-ын Трансмашхолдинг компанитай худалдан авах гэрээ хийхээр тохиролцож, бэлтгэж ажлыг хангаж байна.
- 2013 оны 5 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Бээжин хотноо болсон Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын XIII хуралдаанаар Хятадын тал тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэр, далайд гарах гарц болон төмөр замын тээврийн салбарын бусад асуудлуудаар Монголын талд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхээр тохиролцсон.

Цаашид авах арга хэмжээ:

- Хятад-Монголын хилийн өртөөдийн хооронд галт тэрэгний ойртолтын мэдээ солилцох асуудлаар Хятадын төмөр замтай гэрээ байгуулж шийдвэрлүүлэх.
- “Замын-Үүдийн логистикийн төвийн шилжүүлэн ачих битүү болон дээвэр бүхий задгай агуулах барих төсөл”-ийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, санхүүжилтийн асуудлыг журмын дагуу шийдвэрлэх, төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих.

Олон нийтэд нээлттэй байдал: Хамтарсан тушаалын дагуу Монголбанк, Зам, тээврийн яам хамтран дэд хөтөлбөрийн зорилтот ажлын хэрэгжилтийн байдлыг дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон үнэлгээний тайлангуудыг Монголбанкны цахим хуудаст байршуулсан.

- **Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS дэд хөтөлбөр**

Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго: Газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын үнийн инфляцид үзүүлэх шууд болон шууд бус нөлөө хүчтэй байдаг тул шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах нь үнийн тогтвортой байдлыг хангах Монголбанкны үндсэн зорилттой шууд хамааралтай юм.

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулахын тулд Засгийн газраас нефть боловсруулах үйлдвэр байгуулах, улсын нөөц бүрдүүлэх зэрэг дунд болон урт хугацаанд хэрэгжих ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Гэхдээ эдгээр ажлууд хийгдэх хүртэлх хугацаанд шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгахын тулд шатахууны импортын санхүүжилтийн өртгийг багасгах, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах зэрэг арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх шаардлага гарсан.

Иймд дээрх шаардлага, зорилтыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан тушаалаар энэхүү дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.


Хэрэгжилтийн байдал: (Монголбанкны хэрэгжүүлсэн ажил)

- Дэд хөтөлбөрийн хүрээнд Уул уурхайн яамтай гэрээ байгуулсан, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 13 компанид хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан 3.8 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай 192 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 173.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Валютын ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2-6 сарын хугацаатай форвард хэлцлийг хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй хийж байгаа бөгөөд 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар төлбөр тооцоо хийгдсэн хэлцлийн дүн 516 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний ам.доллар болсон байна.
- Дээрх арга хэмжээ авсны үр дүнд шатахуун импортлогч компаниудын эргэлтийн хөрөнгийн дутагдал, валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ өсөх эрсдэлийг бууруулж, түлш шатахууны үнийн тогтвортой байдлыг хангаж чадлаа.


Уул уурхайн яам болон бусад төрийн байгууллагуудын хэрэгжүүлсэн ажил:

- Компаниудын газрын тосны бүтээгдэхүүний нөөц 2013 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар хөтөлбөрийг эхлүүлсэн үетэй харьцуулахад 2.3 дахин нэмэгдэж, газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тасралтгүй байдал хангагдсан.
- Уул уурхайн яамнаас санаачлан “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх ажлын хүрээнд Засгийн газар БНХАУ-ын “Чайна Ойл” ХХК-тай гэрээ байгуулж, сар бүр 10 мянга хүртэл тонн шатахуун худалдан авахаар болсны зэрэгцээ БНСУ-ын “SK Energy” зэрэг компаниудаас шатахуун худалдан авах боломжтой болсон.
- Уул уурхайн яамнаас БНСУ-ын компаниудтай шатахуун худалдан авах талаар хэлэлцээр хийж байгаатай холбогдуулан БНХАУ-ын “Хятадын төмөр зам” компанитай жилд 200 мянган тонн шатахууныг тус улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэх гэрээ байгуулсан бөгөөд шатахууны тээвэрлэлтийг шийдвэрлэсэн.
- ОХУ-ын “Роснефть”, БНХАУ-ын “Чайна Ойл” компаниудаас худалдан авдаг шатахууны үнийг газрын тосны олон улсын биржийн үнэд суурилан тооцдог болсон. Ингэснээр нийлүүлэгч талаас шалтгаалах үнийн өсөлтийг хязгаарлах, үнийг тогтвортой байлгах, үнийн таамаглал хийх боломж бүрдсэн.
- Шатахууны импортын татварыг хилийн үнийн бууралттай уялдуулан сэргээж, татварын зохицуулалтын орон зайг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн “Газрын тосны зарим бүтээгдэхүүний гааль, онцгой албан татварын тухай” Засгийн газрын 236 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг нэмэгдүүлсэн.

Зураг 3: А-92 шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)



Зураг 4: Дизель түлшний жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)



Эх сурвалжууд: Монголбанк, УУЯ, ГТГ

Хөтөлбөрийн үр дүн:

- Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулсан.
- Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ дэх валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах эрсдэл эрс буурсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний биет нөөц нэмэгдсэн.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлсэн.
- Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний үнийн талаар гадаад талтай зөвшилцөх чадавхи сайжирсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний татварын зохицуулалтыг сэргээсэн.

Монголбанк, Уул уурхайн яам хамтран дэд хөтөлбөрийн үр дүн, зорилтот ажлуудын биелэлтийг 2013 оны 2 дугаар сарын 14-ний өдөр, 2013 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн 1, 2 дахь шатны үнэлгээгээр дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх асуудлуудыг тодорхойлсон.

Олон нийтэд нээлттэй байдал: Хамтарсан тушаалын дагуу Монголбанк, Уул уурхайн яам хамтран дэд хөтөлбөрийн зорилтот ажлын хэрэгжилтийн байдлыг дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон үнэлгээний тайлангуудыг Монголбанкны цахим хуудаст байршуулсан.

- ***Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах дэд хөтөлбөр***

Түлш, эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын санхүүгийн чадавхийг бүрдүүлэх замаар 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Эрчим хүчний сайдын 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан тушаалаар энэхүү дэд хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгааны үнэ тарифыг 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 20 хувиар нэмэгдүүлэх шийдвэрийг энэхүү дэд хөтөлбөр батлагдахаас өмнө гаргасан байна. Иймд цаашид зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг огцом нэмэгдүүлэхгүй байлгах зорилтын хүрээнд энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага гарсан юм.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Түлш, эрчим хүчний үнэ, тарифт өөрчлөлт оруулах бодит шаардлага гарсан тохиолдолд тухайн оны зөвхөн 6-12 дугаар сард өөрчлөлт оруулах, ингэхдээ нэг сард ногдох тарифын өөрчлөлтийг 2 хувиас ихгүй байлгах жишгийг ЭХЯ, Эрчим хүчний зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Засгийн газрын холбогдох яамд хамтран хэрэгжүүлнэ.
- ТӨК-иудад 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц бүрдэнэ.
- Түлш, эрчим хүчний нийлүүлэлт тасралтгүй, найдвартай байх нөхцөл хангагдана.
- Цахилгаан, дулааны үнэ, тариф тогтвортой байж, зардлын шалтгаантай инфляцийн дарамт буурах суурь нөхцөл бүрдэнэ.

Хөтөлбөрийн хүрээнд банкууд Засгийн газартай гэрээ байгуулсан, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ТӨК-иудад 42 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн үр дүн:

Ийнхүү Монголбанкнаас хэрэгжүүлсэн эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрсөн, болзошгүй хямралаас урьдчилан сэргийлсэн бодлогын хүрээнд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний үр дүнд:

- 2012 оны эцэст 14 хувь байсан инфляци 2013 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд **9.4** хувь, Улаанбаатар хотод **8.4** хувь болж бууран, энэ оны зорилтот түвшний орчимд байснаар иргэдийн бодит орлогыг хамгааллаа.
- Санхүүгийн тогтвортой байдлыг ханган, банкны салбарын чадавхийг сайжруулж хамгаалснаар банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ энэ оны эхний хагас жилийн байдлаар **15.9%** болж өслөө.
- Эдийн засгийн бодит сектор, түүний идэвхжилийг дэмжиж, ажлын байрыг хамгаалснаар ДНБ-ий бодит өсөлт 2013 оны 2-р улиралд **14.3%**, эхний хагас жилд **11.3%** болж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгаллаа.
- Санхүү, эдийн засгийн болзошгүй хямралын эрсдэлээс сэргийллээ.


Цаашид Засгийн газраас энэхүү хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга хэрэгслүүдийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэр рүү шат дараатай шилжүүлэх, хөтөлбөрүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах шаардлагатай юм.

Удсын төсөв тогтвортой, гадаад валютын урсгал сайжирсан орчинд Монголбанкнаас экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох дотоодын үйлдвэрлэл болон эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллана.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлээгүйгээс эдийн засаг, санхүүгийн салбарт үүсэх байсан эрсдэл:

Монголбанк, Засгийн газраас дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байсан бол санхүү, эдийн засгийн ноцтой хямрал нүүрлэж, эдийн засаг бүхэлдээ уналтад орохоор байсныг эмпирик судалгаа, симуляцийн үр дүн нотолж байна. Болзошгүй байсан эрсдэлийн үнэлгээг зураг 5-7-д дэлгэрэнгүй тусгасан болно.


Зураг 5: М2 мөнгө -10.9 хувиар огцом унахаас сэргийлж, нийт мөнгөний өсөлтийг тогтворжуулав



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрж, төгрөгийн нийлүүлэлт хийгээгүй байсан бол М2 мөнгө 5.2 их наяд төгрөг болж -27%-иар буурах эрсдэлтэй байв.


Зураг 6: ДНБ -9.6 хувиар буурахаас сэргийлж, эдийн засгийн бодит өсөлтийг тогтворжуулж, ажлын байр, иргэдийн бодит орлогыг хамгаалав



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас эдийн засгийн удаашралын
мөчлөгийг сөрж, төгрөгийн нийлүүлэлт
хийгээгүй байсан бол ДНБ огцом унаж,
эдийн засгийн хямрал болохоор байв.

Зураг 7: Зээлийн тасалдлыг зогсоож, санхүү эдийн засгийн болзошгүй хямралаас сэргийлэв



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрж, төгрөгийн нийлүүлэлт хийгээгүй байсан бол зээл тасалдаж, чанаргүй зээл огцом өсч, санхүүгийн хямрал нүүрлэхээр байв.

Хүснэгт 2: Эдийн засгийн бодит секторыг дэмжив

	2013			2012		
	Q1	Q2	III	Q1	Q2	III
ДНБ	7.1%	14.3%	11.3%	15.9%	11.3%	13.1%
Хөдөө аж ахуй	20%	21%	21%	21%	21%	21%
Уул уурхай, олборлолт	5%	7%	6%	10%	14%	12%
Боловсруулах үйлдвэрлэл	19%	-1%	7%	12%	6%	8%
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	6%	10%	8%	8%	-4%	3%
Барилга	8%	154%	129%	-6%	37%	27%
Бөөний болон жижиглэн худалдаа	-1%	7%	3%	35%	6%	18%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0%	11%	6%	11%	2%	6%
Мэдээлэл, холбоо	16%	4%	10%	7%	10%	8%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10%	16%	13%	19%	19%	19%

Эх сурвалж: УСХ

Монголбанкнаас эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрж, төгрөгийн нийлүүлэлт хийгээгүй байсан бол хөдөө аж ахуй, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт дээрх өсөлт гарахгүйгээс гадна 179 мянган ажлын байраа алдахаар байв.

4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон бусад шаардлагатай хууль тогтоомжийг олон улсын холбогдох стандартад нийцүүлж, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-аас тогтоосон Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх.

2013 оны 5 дугаар сарын 31-нд Улсын Их Хурлын чуулганаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Терроризмтэй тэмцэх тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг тус тус баталсан. Хуулиудын шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтийг Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тодорхой ахиц гаргасан гэж үнэлэн, Монгол Улсыг нийтэд зарлах мэдэгдлийн сөрөг арга хэмжээ авагдах орнуудын жагсаалт (хар жагсаалт)-д оруулалгүй хяналтад байгаа улсуудын жагсаалт (саарал жагсаалт)-д 2013 оны 10 дугаар сар хүртэл үлдээхээр шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Хууль зүйн яамнаас боловсруулж байгаа багц хуулиудын нэг болох Гэмт хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн төсөлд мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай заалт шинээр орсон. 2013 оны 5 дугаар сарын 31-нд УИХ-аар батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлд сэжигтэй гүйлгээний талаарх тодорхойлолт, Терроризмтэй тэмцэх тухай хуульд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргадаг хориг арга хэмжээний хүрээнд хөрөнгө битүүмжлэх тухай зүйлийг ФАТФ-ын стандартын дагуу тус тус оруулсан.

Хэрэв Монгол Улсын Засгийн газар терроризмтэй тэмцэх тухай хуулийн дагуу террористуудын хөрөнгийг царцаах, битүүмжлэхтэй холбоотой дэлгэрэнгүй журмыг 2013 оны 10 дугаар сарын 14-нд болох ФАТФ-ын хурлаас өмнө баталж амжвал манай улсын зэрэглэлийг сайжруулах асуудлыг дахин эргэж харах боломжтойг ФАТФ-аас мэдэгдсэн. Энэ журмыг ФАТФ-ын хурлаас өмнө баталж амжихгүй тохиолдолд Монгол Улс хар жагсаалтад орох эрсдэлтэй нөхцөл байдалд байна. Дээрх журмын төслийг 2013 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Монголбанк боловсруулсан бөгөөд журмыг 2013

оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө Засгийн газраар батлуулах асуудлаар Хууль зүйн яам, Тагнуулын Ерөнхий газартай хамтран ажиллаж, тогтоосон хугацааны дотор журмыг батлуулсан тохиолдолд манай улсын үнэлгээг бууруулахгүй байх, ФАТФ-ын саарал жагсаалтад байх хугацааг дахин 5 сараар сунгуулах болзлыг ФАТФ-ын төлөөлөгч нараар гаргуулан ажиллаж байгаа болно.


III. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2013 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

(2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар)

Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

1.1. Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцийг тогтвортой нам түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг хязгаарлах бодлого баримтална. Үүний үр дүнд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2013 оны эцэст 8 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, улмаар 2014-2015 онд инфляцийг 5-7 хувийн түвшинд байлгах нөхцөл бүрдүүлнэ.

Зураг 8: Улаанбаатар хотын сарын ба жилийн инфляци



Эх сурвалж: УСХ

Зураг 9: Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)



Эх сурвалж: УСХ

Жилийн инфляци 2013 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 9.4 хувь, Улаанбаатар хотод 8.4 хувь байгаа нь инфляцийн зорилтот түвшинтэй ойр байна. Харин 2013 оны эхний 7 сарын байдлаар дунджаар 0.5 хувь байсан Улаанбаатар хотын сарын инфляци 8 дугаар сард 2.6 хувь болж өсчээ. Инфляци өмнөх сараас өссөн нь төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ болох цахилгааны үнэ тариф өссөн болон боловсролын үйлчилгээний үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

2013 оны 8 дугаар сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (8.4%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн 0.8 нэгж хувь, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 1.1 нэгж хувь, шатахуун 0.1 нэгж хувь, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.3 нэгж хувь, бусад бараа, үйлчилгээ 5.1 нэгж хувийг тус тус эзэлж байна. (Зураг 9). Бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн инфляцид эзлэх хувь хэмжээг өмнөх 7 дугаар сартай харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн болон махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь тус бүр 0.2 нэгж хувиар буурсан бол төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн инфляцид эзлэх хувь хэмжээ харгалзан 1.0 болон 0.8 нэгж хувиар өсчээ.

2012-2013 оны төрийн мөнгөний бодлогын үр дүн, Төсвийн тогтвортой байдлын тухай

хуулийн хэрэгжилт, “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн үр дүн зэрэг нь өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлтийг мэдэгдэхүйц бууруулахад эерэгээр нөлөөлж байна. Тухайлбал, жилийн инфляци улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод 2012 оны 8 дугаар сард харгалзан 14.9 хувь, 15.6 хувь байсан бол энэ оны 8 дугаар сард 9.4 хувь, 8.4 хувь болж, харгалзан **1.6** болон **1.9** дахин буураад байна.

Инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй байсан, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурч, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл багассан, улсын төсвийн зардал нь орлоготойгоо уялдаж бага байсан, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр амжилттай хэрэгжиж үр дүнд хүрсэн, инфляци буурч, энэ оны зорилтот түвшний орчимд байсан зэрэг нь мөнгөний бодлогын хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Иймд, Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны эхнээс мөнгөний бодлогын хүүг 3 удаа, нийтдээ 2.75 нэгж хувиар бууруулан **10.5** хувь болгоод байна. Бодлогын энэхүү арга хэмжээ нь мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулах, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн идэвхжилийг дэмжихэд эерэгээр нөлөөллөө. Гэхдээ мөнгөний бодлогоор эдийн засгийн идэвхжилийг үүнээс илүү дэмжихэд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдал 2012 оноос эхлэн үргэлжилсээр байсан нь гол хязгаарлалт болж байв. Үүнийг Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс 2013 оны 1, 4, 6 дугаар саруудад гаргасан мэдэгдлээрээ тогтмол анхааруулж байсан юм.

Сүүлийн 19 сард гадаад худалдааны нөхцөл 23 хувиар муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 онд 5, 2013 онд 46 хувиар тус тус буурч, санхүүгийн эх үүсвэр хомсдож, гадаад цэвэр актив мөн хугацаанд Чингис бондын хөрөнгийг оруулахгүй тооцвол 1.2 тэрбум ам.доллараар буураад байна. Санхүүгийн эх үүсвэр гадагшилж зээлийн тасалдал бий болох эрсдэл өндөр үед улсын төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүйгээс төсөв хумигдаж, эдийн засгийн өсөлт удаашрах, улмаар уналтад орох хүндрэл тулгарахаар байлаа. Үүний эсрэг Монголбанк сүүлийн 11 сарын турш мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, мөнгөний нийлүүлэлтийг шаардлагатай тухай бүр хувийн хэвшлээр дамжуулан, тодорхой хөтөлбөрийн хүрээнд нэмэгдүүлж ирсний үр дүнд иргэдийн бодит орлогыг хамгаалж, бодит секторын идэвхжилд дэмжлэг үзүүлэн, эдийн засаг хумигдах сөрөг нөлөөллийг саармагжуулсан болно.

Эрсдэлээс урьдчилан сэргийлсэн, мөчлөг сөрсөн макро бодлогын хүрээнд Монголбанкнаас бодлогын дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн юм. Үүнд:

- “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг эрс бууруулж, эдийн засаг дахь бүтээмжтэй төгрөгийн нийлүүлэлтийг тухай бүр нэмэгдүүлэн, эдийн засгийн бодит секторт дэмжлэг үзүүлж, санхүүгийн болон макро эдийн засгийн болзошгүй хямралаас сэргийлэв.
- Банкны салбарын чадавхийг сайжруулж хамгаалах, санхүүгийн тогтворгүй байдал бий болох эрсдэлээс сэргийлэх зорилгоор банкуудад 900 тэрбум төгрөгийн хадгаламжийг тодорхой үе шаттай байршуулав³. Банкууд уг эх үүсвэрийг эдийн засгийн бодит секторт ажлын байр, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх зээл болгон гаргаснаар зээлийн тасалдал бий болох эрсдэлээс сэргийлж, бизнесийн идэвхжилтийг дэмжин, эдийн засгийн бодит өсөлтөд дэмжлэг болж байна.
- Дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүний коридорыг шинээр нэвтрүүлэв. Ингэснээр богино хугацаат хүүг

³Энэ нь “Чингис” бондын хөрөнгө бус, Монголбанкны өөрийн эх үүсвэр.

илүү үр дүнтэй удирдан, хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах, Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурах, эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлөх зэрэг олон талын ач холбогдолтой боллоо.

- “Тадаад худалдааг дэмжих, экспортыг урамшуулах механизмыг бий болгох замаар экспортын болон эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх бодлогын санал”-ыг боловсруулж Засгийн газарт хүргүүлэн, тусгайлсан хөтөлбөр боловсруулах чиглэлд хамтран ажиллалаа. Уг бодлогын саналд ашигт малтмалын бус салбарын экспортыг дэмжих механизм, институциональ бүтэц, санхүүжилтийн схемийг цогцоор нь шийдвэрлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг тусгасан бөгөөд үүний үр дүнд Засгийн газар “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- “Хөдөөг хөгжүүлэх, орон нутаг дахь бизнесийг дэмжих бодлогын санал”-ыг боловсруулж Засгийн газарт хүргүүлэн, тусгайлсан хөтөлбөр боловсруулах чиглэлд хамтран ажиллалаа. Уг бодлогын саналд: (i) аймаг, сум бүрийн онцлог, давуу талыг судалсны үндсэн дээр тухайн орон нутагт “брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, тогтвортой ажлын байр бий болгох, (ii) орон нутаг дахь суурь бүтцийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх, (iii) орон нутаг дахь тээвэр, логикийг хөгжүүлж, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг бууруулах, (iv) орон нутагт ажиллахад Улаанбаатарт ажиллахаас илүү таатай нөхцөл (цалин урамшуулал, амьдрах нөхцөлийн оновчтой схем) бүрдүүлэх замаар хот руу ирэх урсгалыг багасгаж, хотоос орон нутагт чиглэсэн урсгалыг бий болгох, (v) орон нутаг дахь банк, санхүүгийн үйлчилгээний өртгийг бууруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг тусгасан. Үүний үр дүнд Засгийн газар “Хөдөөгийн бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг батлахаар ажиллаж байна.
- Засгийн газрын үнэт цаасыг анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, арилжааг тогтмол зохион байгуулав. Ингэснээр улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх болон урт хугацааны зорилтот төсөл, хөтөлбөрийг эрсдэлийн боломжит түвшинд, хамгийн бага зардалтайгаар санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны зах зээл, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны буюу төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох, төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой байна.
- Холбогдох хууль эрх зүйн орчинг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд: Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль эрх зүйн шинэчлэл, Банкны зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой эрх зүйн шинэчлэл зэрэг болно.
- Төсвийн тогтвортой байдлыг тууштай хангасан орчинд мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит секторуудыг дэмжих, эдийн засагт дутагдалтай байгаа мөнгөний нийлүүлэлтийг санхүүгийн болон макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан үе шаттай хийх, ингэхдээ тодорхой зорилтот хөтөлбөрүүдийн хүрээнд инфляцийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, бодит секторыг дэмжих, эдийн засагт дотоодын үйлдвэрлэл, ажлын байр, бүтээмж бий болгоход чиглэсэн бодлогыг үргэлжлүүлж байна.
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох

хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангах үндсэн нөхцөлийг бүрдүүллээ. Ингэснээр эдийн засаг дахь урт хугацаатай төгрөгийн эх үүсвэр, хуримтлалыг нэмэгдүүлж, санхүүгийн салбар дахь хэрэглээний шинжтэй зээлийг багасгах, дундаж давхаргад зориулагдсан чанартай ажлын байрыг олноор нь бий болгодог үйлдвэрлэлийн зээлийг, тэр дундаа барилга, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр болон агуулахын салбар дахь зээлийг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

- Монгол Улсын эдийн засагт тулгарч буй хүндрэл, бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх илтгэл, судалгаа, шинжилгээ, Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийн тухай танилцуулгыг 2013 оны эхнээс Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хэлэлцүүлж, холбогдох байгууллагуудад шаардлагатай мэдээлэл, авах арга хэмжээний саналыг хүргүүлж, хамтран ажиллалаа.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.

Төв банкны тухай хуулийн 22.2-т “Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зарчмыг баримтална” гэж заасны дагуу Монголбанкнаас ханшийн бодлогыг хэрэгжүүлдэг.

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг удирдлага болгон, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтож байх нөхцөлийг ханган ажиллаж байгаа бөгөөд валютын ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай тухай бүр оролцож байна.

Урсгал дансны алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар бүрэн санхүүжүүлж ирсэн сүүлийн жилүүдийн хандлага 2013 онд эрс өөрчлөгдлөө. Тухайлбал, урсгал дансны алдагдал энэ оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.3 хувиар өссөн байхад гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үеэс 47 хувиар буурсан нь төлбөрийн тэнцэл, валютын захын дарамтыг нэмэгдүүлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад нөлөөлсөн суурь хүчин зүйл болсон юм.

Зураг 10: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш ба гадаад секторын үндсэн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголбанк


Оны эхнээс 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийг дуусталх хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.29 хувиар чангарч, 1.69 хувиар суларч, өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.21 хувь байна. Мөн хугацаанд ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 80 хувьд нь 0-4 төгрөг, үлдсэн 20 хувьд нь хамгийн ихдээ 1.69 хувиар хэлбэлзжээ. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.21 хувь байгаа нь 2012 оны мөн үеэс 0.04 хувиар их, 2011 оны мөн үеэс 0.03 хувиар бага байна (Зураг 11).

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш нь 2013 оны эхнээс 17.1 хувиар суларсан байна. Энэ нь гадаад худалдааны нөхцөл муудсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, гадаад валютын орох урсгал эрс татарсантай нийцтэй байгаа юм.

Монголбанк валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригт тогтмол зохион байгуулж ирлээ. Валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны, түр зуурын шинжтэй зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, захад оролцогчдын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор Монголбанк оны эхнээс нийт 75 удаагийн валютын дуудлага худалдааг зохион байгуулж, шаардлагатай зохицуулалтыг тухай бүр хийсний үр дүнд гадаад зах зээлийн дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, гадаад худалдаа, эдийн засаг дахь зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлэн, валютын ханшийн хямралын эрсдэлээс сэргийлэв. Мөн шаардлагатай үед ам.доллар, юанийн спот захад оролцох нөхцөлийг бүрдүүлэн ажилласны зэрэгцээ төгрөг-ам.долларын болон төгрөг-юанийн своп, форвард хэлцлүүдийг банкуудтай хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг бууруулах, ханшийн эрсдэлээс хамгаалах зэрэг ач холбогдолтой болж байна.

Монголбанкны зохицуулалт, оролцооны үр дүнд 2012 оны 2 дугаар сараас энэ оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд валютын зах тогтвортой, ханшийн хэлбэлзэл маш бага түвшинд байсан (Зураг 10). Гэтэл энэ оны 7 дугаар сарын гадаад валютын урсгал огцом муудсан, мөн сарын сүүл үеэс зах зээлд олон тооны сөрөг мэдээлэл, мэдэгдлүүд гарсан, зах зээлийн болон олон нийтийн хүлээлт сөрөг чиглэлд огцом өөрчлөгдөн, “валютын урсгал эрс сайжирна, Оюу толгой, Таван толгой төслүүд хэрэгжсэнээр иргэдийн амьдрал сайжирна” гэсэн их итгэл, хүлээлт алдарсантай уялдан валютын ханшийн хэлбэлзэл өссөн юм (Зураг 12).

Зураг 11: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт (интервалаар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 12: Монголбанкнаас зарласан ханшийн хэлбэлзэл /2013 оны 7-9 сар/



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк төрийн мөнгөний бодлогод заасан чиг үүргийнхээ дагуу валютын захад оролцож, шаардлагатай зохицуулалтыг тухай бүр хийсэн, валютын урсгал 9 дүгээр сараас өмнөх саруудтай харьцуулахад бага зэрэг сайжирсан, валютын захын хүлээлтэд эерэгээр нөлөөлөх хэд хэдэн үйл явдал өрнөж, эерэг мэдээллүүд гарснаар ханшийн хөөс арилж, валютын зах тогтворжоод байна (Зураг 12).

Энэ оны 8 дугаар сарын байдлаар төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 9.5 хувиар суларч, бодит үйлчилж буй ханш (REER) 7 дугаар сарын байдлаар 1.2 хувиар суларсан үзүүлэлттэй байна. Нэрлэсэн ханш суларсантай уялдан төгрөгийн бодит үйлчилж буй ханш нь урт хугацааныхаа тэнцвэрт түвшний орчимд ирсэн нь импортыг орлох дотоодын үйлдвэрлэл, экспортыг дэмжин, үр ашиггүй, тэвчиж болох импортыг бууруулах, гадаад секторын эрсдэл, төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгах, улмаар

эдийн засгийн өрсөлдөх чадвар, урт хугацааны дархлааг сайжруулах боломжийг бүрдүүлж байна⁴.

Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн, чанартай ажлын байр бий болгоход чиглэсэн, үндэсний хуримтлалыг урамшуулсан мөнгөний бодлогыг Монголбанк үргэлжлүүлэх бөгөөд ханшийн бодлогыг үүнтэй нийцтэйгээр хэрэгжүүлнэ.

1.3. Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах, нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үндсэн зорилтын хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах замаар Төв банкны хариуцлагыг сайжруулна.

Мөнгөний бодлогын бие даасан, хараат бус байдлыг хангах, бодлогын шийдвэр гаргах үйл явцыг сайжруулах чиглэлд гарсан чухал дэвшил нь 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-ийг Монголбанкнаас томилогдсон 8 гишүүн, төрийн байгууллага, их сургууль буюу академи, хараат бус судлаачдыг төлөөлсөн 5 гишүүн, нийт 13 гишүүнтэйгээр шинээр байгуулсан явдал юм. Ингэснээр тус зөвлөл нь мөнгөний бодлогын саналыг батлагдсан журмын дагуу 2-3 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг тал бүрээс нь авч үзсэн мэтгэлцээний үр дүнд бодлогын шийдвэр гаргадаг, шийдвэрийг хэвлэлийн хурал, мөнгөний бодлогын мэдэгдлээр олон нийтэд нэн даруй мэдээлж, гаргасан шийдвэрийн үндэслэлийг тайлбарладаг, хуралдааны протоколыг нийтэд танилцуулдаг болсон. МБЗ нь тайлант хугацаанд 4 удаа мөнгөний бодлогын шийдвэрийг гаргав. МБЗ-ийн ажиллах журамд заасны дагуу хэвлэлийн хурал болсноос хойш 14 хоногийн дотор мөнгөний бодлогын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн товчлолыг гарган Монголбанкны цахим хуудсанд байршуулж олон нийтийн хүртээл болгов. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурлыг тухай бүр зохион байгууллаа.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогыг олон улсын болон дотоодын хурал, зөвлөгөөн, семинар, сургалтаар тайлбарлан таниулж, санхүүгийн зах зээлд оролцогчид, судлаачид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын санал, шүүмжийг хүлээн авч, бодлого, үйл ажиллагаандаа тусгаж ажиллалаа. Мөнгөний бодлогын хэрэгжилтэд Төв банкны нээлттэй, ил тод байдал чухал үүрэгтэй тул Монголбанкнаас олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулан, мөнгөний бодлогын хэрэгжилтийг нийтэд ил тод, тогтмол тайлагнах замаар иргэд, олон нийтийн зүгээс бодлогын үр дүнд итгэх итгэлийг бэхжүүлэв.

Монголбанкны цахим хуудсаар дамжуулан цаг үеийн болон графикт мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ “Тол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллүүдийг цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр тухай бүр мэдээлж, ярилцлага, тодруулга, тайлбар өгөх ажлыг үргэлжүүлсэн. Мөн Twitter, facebook зэрэг хэрэгслүүдэд Монголбанкны мэдээ мэдээллийг тогтмол байршуулан ажилласан болно.

Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор Монголбанкнаас мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэл, үйл ажиллагаа, ил тод байдал, бодлогын харилцан уялдаа, макро эдийн засаг, санхүүгийн суурь ойлголт зэрэг өргөн хүрээтэй асуудлаар олон нийт болон хэвлэл, мэдээллийн ажилтнуудад зориулсан цуврал сургалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, хэрэгжүүлж буй

⁴ Жишээ нь, 2012 оны эхний 8 сард хэрэглээний бараа бүтээгдэхүүний импорт 22 хувийн өсөлттэй байсан бол 2013 онд 6 хувиар буураад байна. 2013 оны 6 дугаар сард 50 хувиар буураад байсан нүүрсний экспорт 8 сарын байдлаар 44 хувийн бууралттай болж, ялимгүй сэргэх хандлага ажиглагдаж эхлээд байна.

бодлоготой холбоотой бүхий л эрх зүйн баримт бичиг, журам, заавар, судалгааны ажил, тайлан, мэдээлэл, статистик мэдээ, хэвлэмэл бүтээгдэхүүнийг Монголбанкны цахим хуудаст байршуулан нийтэд танилцуулж ажиллав. Тухайлбал, их дээд сургуулийн оюутан залуусыг Төв банкны үйл ажиллагаатай танилцах экскурсын хүрээнд МУИС болон СЭЗДС-ийн оюутнуудыг Монголбанкинд зочлуулж Эрдэнэсийн сан үзүүлэн Монголбанкны түүхэн замнал, үйл ажиллагаатай танилцуулах, сэтгүүлчдэд тогтмол давтамжтайгаар сургалт зохион байгуулах, их дээд сургууль, бусад байгууллагуудад лекц унших, уулзаж мэдээлэл өгөх зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Хоёр. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1. Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлнэ.

Банкуудын эрсдэл даах чадварыг дээшлүүлж, хувьцаа эзэмшигчдийн санхүүгийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 404 дүгээр тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 16 тэрбум төгрөг болгосон бөгөөд бүх банкууд энэхүү шаардлагыг хангаж ажиллалаа. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд Монголбанкнаас сар бүр хяналт тавьж ажиллав. Энэ хүрээнд 2013 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг бүх банкууд хангасан бол, зээлийн төвлөрлийн үзүүлэлтүүдийг 4 банкнаас бусад бүх банкууд хангаж ажилласан байна. Иймд зарим шаардлага хангаагүй банкуудад зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгөөд байна.

Мөн банкуудын зээлийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд банкуудад газар дээр нь хийх шалгалтын давтамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төвлөрөл ихтэй, холбогдох этгээдийн зээлүүдийг шалган тогтооход илүү анхаарал хандуулж, тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасан арга хэмжээг тухай бүр авч ажиллав. Банкны системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор газар дээр хийх хяналт шалгалтыг хуваарийн дагуу гүйцэтгэж, 2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар бүх банкуудад давхардсан тоогоор нийтдээ 15 удаагийн иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалт явуулж үнэлгээ дүгнэлт гарган, холбогдох үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Үүнээс гадна газар дээрх шалгалтыг банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх чиглэлд түлхүү хандуулж, банкны эрсдэлийн үнэлгээний аргачлал нь оновчтой эсэх, хүлээж болзошгүй эрсдэлийг бууруулах бодлого нь үр дүнтэй эсэх, дотоод хяналтын систем нь хангалттай эсэх зэрэгт үнэлгээ өгч байна.

Хадгаламж банкинд хяналт шалгалтын дунд хугацааны хөтөлбөрийг өнгөрсөн 2 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн боловч үр дүн нь хангалтгүй байсан тул 2013 оны 7 сард Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тус банкинд эрх хүлээн авагч томилж, банкны зарим актив, пассив хөрөнгийг Төрийн банкинд ажлын нэг хоногт багтаан амжилттай шилжүүлсэн. Үүний үр дүнд Хадгаламж банкны 1.7 сая харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалж чадсан. Банкуудыг системийн хэмжээний хямрал болон төлбөрийн чадварын хүндрэл үүсэхэд авах шаардлагатай арга хэмжээний бэлтгэлийг хангуулах зорилгоор болзошгүй хямралын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг банк тус бүрээр гаргуулан авсан бөгөөд энэ чиглэлээр Дэлхийн банкны төслийн нэгжтэй хамтран 2013 оны 10 дугаар сард сургалт зохион байгуулахаар

болоод байна.

Гол нэрийн бараа, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/176 дугаар тушаалаар баталсан “Банкны өөрийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх түр журам”-ын хэрэгжилтийг хөтөлбөрт оролцогч банк тус бүрээр хянаж, холбогдох үүрэг даалгавар өгч ажиллаж байгаа болно.

2.2. Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хийх хяналт шалгалтын Олон улсын стандарт, зарчмуудаас бодлогын хувьд хэрэгжүүлэх боломжтой арга хэрэгслүүдийг нэвтрүүлж эхлээд байна. Энэ хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг тодорхойлж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг нэмэлт шаардлага хэлбэрээр 2012 оны 2 дугаар улирлаас 2013 оны 2 дугаар улирал хүртэл хагас жилийн давтамжтайгаар, шат дараалан нэмэгдүүлэхээр тогтсон бөгөөд нэмэгдүүлсэн шаардлагыг 2013 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар системийн нөлөө бүхий банкууд болох Голомт, Хаан, Хас, Худалдаа хөгжлийн банкууд тус тус хангасан байна.

Мөн 2013 оны 3 дугаар сард хянан шалгагч нарт зориулан олон улсын зөвлөхтэй хамтран Базел стандарт, Макро зохистой бодлогын талаарх гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулсан бөгөөд олон улсын стандартад орсон сүүлийн үеийн шаардлагуудыг хэрхэн нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, гадаад зөвлөхтэй санал солилцсон. Монголбанкнаас хяналт шалгалтын талаар 2018 он хүртэл баримтлах дунд хугацааны стратегийн баримт бичгийг олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, олон улсад нийтээр мөрдөх хэм хэмжээг үндэслэн боловсруулсан бөгөөд Монголбанкны Захирлуудын зөвлөлөөр батлуулахаар ажиллаж байна. Уг стратегийн хүрээнд банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгож, эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын арга, аргачлалыг нэвтрүүлж эхлэх юм.

Банкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор банкуудын мөрдөж буй “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг шинэчлэн боловсруулаад байна. Цаашид олон улсын стандартыг хэрэгжүүлэх стратеги, үр нөлөөллийн судалгаанд үндэслэн 2014 оноос банкуудад мөрдүүлэхээр төлөвлөж байна. Нийгмийн дундаж давхаргад зориулсан чанартай ажлын байрыг бий болгодог барилга, боловсруулах үйлдвэр, тээвэр ба агуулахын салбарыг хөгжүүлэх Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогыг банкны санхүүжилтээр дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээ, эрсдэлийн түвшинг оновчтой тодорхойлох зорилгоор “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнд хяналт тавих журам”-д холбогдох өөрчлөлтийг оруулан мөрдүүлж эхэллээ.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа тэлэхийн хэрээр банкны байгууллага оролцсон санхүүгийн нэгдлүүд нэмэгдэх хандлагатай байгаагаас тухайн санхүүгийн нэгдлүүдэд нэгдсэн байдлаар хяналт шалгалт хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлага үүссэн. Иймд Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын журмын төслийг боловсруулж, тайлант оны 3 дугаар сард тусгайлсан удирдамжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороотой хамтран туршилтаар зарим банк санхүүгийн нэгдэлд шалгалт хийсэн бөгөөд гарсан үр дүнг журмын төсөлд тусгахаар ажиллаж байна. “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-д заасны дагуу банкуудаас хагас жил тутам ирүүлсэн зохистой удирдлагын тайланг хянаж, шаардлагатай үед газар дээр нь шалгаж байсан бөгөөд

банкны зохистой засаглалыг хөгжүүлэх, түүнийг үнэлэх аргачлалыг сайжруулах үүднээс тус журмыг шинэчлэн боловсруулав.

Банкны үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж байгаатай уялдан “Банкны зөвшөөрлийн журам” болон “Банкны нэгжийн журам”-ыг хууль эрх зүйн шинэчлэл, зах зээлийн нөхцөл байдал болон Монголбанкнаас баримтлах бодлогод нийцүүлэн шинэчилж байна.

2.3.Зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгийн эрх зүйн орчныг шинэчилнэ.

Зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөл бүрдүүлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн эрх зүйн орчинг шинэчлэх хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-155 тоот тушаалаар “Зээлийн барьцааны эрх зүйн орчинг сайжруулах” ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс “Иргэний хууль”, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын дээд шүүх болон Хууль зүйн яаманд хүргүүлэв.

Зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээг өргөжүүлж, Хөдөлмөрийн яам, Монголын цахилгаан холбоо ТӨХК, Хөгжлийн банк, Санхүүгийн зохицуулах хороо, Орон сууц санхүүжилтийн корпораци, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Зээлийн батлан даалтын сан, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудтай гэрээ байгуулан өр төлбөрийн мэдээллийг онлайн горимд харилцан солилцон ажиллаж байна.

Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг хийснээр 2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 13 банк, 128 бичил санхүүгийн байгууллага буюу 89 банк бус санхүүгийн байгууллага, 37 хадгаламж зээлийн хоршоо, 2 санхүүгийн түрээсийн компанитай мэдээлэл солилцож байна.

Гурав. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Төрөөс мөнгөн хадгаламжид гаргах баталгааг хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжүүлснээр төрд учрах эрсдэлийг бууруулж, банкны салбарын санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлнэ.

“Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11 дүгээр сард дууссан учраас Улсын Их Хурлын 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталсан. Ингэснээр төрөөс мөнгөн хадгаламжид баталгаа гаргах хэлбэрээс хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжих эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Хууль батлагдсантай холбоотойгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 76/А-66 дугаар хамтарсан тушаалаар Хадгаламжийн даатгалын корпорацийн үндэсний хороог байгуулж, ажлын нэгдсэн төлөвлөгөөг баталсан бөгөөд 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Хадгаламжийн даатгалын корпораци албан ёсоор нээлтээ хийж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

“Хадгаламжийн даатгалын корпорацийн дүрэм”, “Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны ажиллах журам”, “Хадгаламжийн даатгалын корпорацийн бүтэц, орон тоо,

ажил үүргийн хуваарь”-ийг боловсруулах ажлын хэсэгт Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл хамтран ажиллаж, тэдгээрийг Үндэсний хороонд танилцуулан, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2013 оны А-106/118 дугаар хамтарсан тушаалаар батлуулан ажиллаж байна. Үүнээс гадна хадгаламжийн даатгалын шимтгэл хэлбэрээр банкуудаас татан төвлөрүүлэх хөрөнгийг Монголбанкн дахь Засгийн газрын тусгай дансанд байршуулах ажлыг зохион байгуулж байна.

3.2. Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2013-2015 онд эрчимжүүлэх ажлын хүрээнд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, боловсронгуй болгоно.

- **Үндэсний брэнд “Т” картын хэрэглээг нэмэгдүүлэх, иргэний ухаалаг үнэмлэхийг төлбөр тооцоонд ашиглах боломжийн талаар судалгаа, санхүүжилтийн тооцоо хийх, хэрэгжүүлэх:**

Үндэсний брэнд “Т” карт хэрэглэгчдийн тоо эрчимтэй нэмэгдэж, 2013 оны эхний хагас жилийн байдлаар банкууд 453.5 мянган ширхэг “Т” картыг гаргасан байна. Иргэний ухаалаг үнэмлэхэд суурилсан үндэсний төлбөрийн “Т” картыг АТМ, ПОС, ПОБ төхөөрөмжөөр дамжуулан төлбөр тооцоонд ашиглах боломжийг иргэдэд олгох ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Монголбанк харилцан тохиролцож “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Тус санамж бичгийн хэрэгжилтийг удирдлагын түвшинд зохион байгуулж, хурдасгах үүднээс ажлын хэсэг байгуулах тухай Хууль зүйн яам (ХЗЯ) болон Монголбанкны хамтарсан тушаалын төслийг ХЗЯ-нд хүргүүлсэн болно. Түүнчлэн иргэний үнэмлэх нийлүүлэгч байгууллагатай уулзалт зохион байгуулах, техникийн шийдлийг судлахаар тохиролцоод байна.

- **“Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөрийн систем, картын нэгдсэн сүлжээ болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах:**

“Банксүлжээ” систем, бага дүнтэй болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2013 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийг дуусталх хугацаанд:

- ҮЦГТ-өөр нийт 800.3 тэрбум төгрөгийн дүнтэй 15.9 сая ширхэг картын гүйлгээ, 590.5 тэрбум төгрөгийн дүнтэй 12 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ,
- Банксүлжээ системээр 36 их наяд төгрөгийн дүнтэй 724.7 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ тус тус амжилттай боловсруулагдсан байна.
- **“Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг эхлүүлэх:**

“Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх тухай ТЭЗҮ-г боловсруулж, албан бичгийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. 2013 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаан, УИХ-ын холбогдох Байнгын хороодоор уг асуудлыг тус тус хэлэлцэж дэмжсэн болно. Мөн АХБ-наас 2013 оны 9 дүгээр сарын 5-6-ны өдрүүдэд “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн зээлийн хэлэлцээрийг зохион байгуулсан.

3.3. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэлэх олон улсын жишигт суурилсан аргачлалыг нэвтрүүлж эхэлнэ. Банк, санхүүгийн үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй болгох, иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх арга

хэмжээ авч ажиллана.

Банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн хэмжээг олон нийтэд тодорхой болгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах журам”-ын төслийг боловсрууллаа.

Энэхүү журамд банкуудын ижил төстэй бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэлийн мэдээллийг Монголбанкны цахим хуудаст байршуулах, олон улсад түгээмэл хэрэглэгддэг зээлийн бодит өртөг тооцох аргачлал, түүнийг хэрхэн ашиглах зарчмыг тодорхойлох зэрэг зохицуулалтуудыг тусгасан. Уг журмыг мөрдөж эхэлснээр харилцагч санхүүгийн бүтээгдэхүүнийг оновчтой сонгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бололцоо бүрдэнэ. Иргэдийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх зорилгоор санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн, нэр томъёоны тайлбарыг агуулсан толь бичгийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

3.4. Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, тэдгээрийг хөрөнгөөр баталгаажсан, Засгийн газрын болон орон нутгийн үнэт цаасны зах зээлд оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, тэдгээрийг хөрөнгөөр баталгаажсан, Засгийн газрын болон орон нутгийн үнэт цаасны зах зээлд оруулах нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкнаас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зарчмын саналыг Эдийн засгийн хөгжлийн яам болон Хууль зүйн яаманд хүргүүлсэн билээ. УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2013 оны 5 дугаар сард баталсан болно.

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 217/A161 дүгээр хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”, 2013 оны 32/A21 дүгээр хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

3.5. Алт цэвэршүүлэлтэд олон улсын стандартыг нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана.

Монголбанк дотоодын зах зээлээс алтыг төгрөгөөр худалдан авч, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар цэвэршүүлж мөнгөжүүлэн, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэн ажилладаг. Алт олборлолтын хэмжээ 2012 онд 3.3 тоннд хүрсэн нь 2010 онтой харьцуулахад 1.2 тонноор нэмэгдсэн боловч дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр барихад хангалттай хэмжээнд хүрээгүй байна.

Алт олборлолтын хэмжээ жилд 25-30 тоннд тогтвортой байх нөхцөлд дотоодод алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах нь техник, эдийн засгийн үндэслэлийн хувьд боломжтой гэж үздэг байна. Нөгөө талаар алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудал нь ихээхэн хөрөнгө оруулалт, түүхий эдийн бааз суурь, цаг хугацаа шаардана. Эдгээр шалтгааны улмаас алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Засгийн газраас бодлогын санал ирээгүй, шийдвэр гараагүй байна.

Уг асуудлыг судлах үүрэгтэй Засгийн газраас томилсон ажлын хэсэгт Монголбанк төлөөллөө оролцуулан ажиллуулж, ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан болно.

IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БОЛОН ОЙРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААР ХИЙСЭН ТООЦОО СУДАЛГАА

ХУРААНГУЙ

Дэлхийн эдийн засаг төдийлөн сэргэхгүй, аж үйлдвэрлэлийн өсөлтийн төсөөллүүд өмнөхөөс буурч байгаагаас үзэхэд ирэх онд түүхий эдийн үнэ өсөхөөргүй байна гэсэн дүгнэлтийг олон улсын шинжээчид хийж байна. Энэ нь манай улсын экспортын бүтээгдэхүүнүүдийн эрэлт, үнэ төдийлөн өсөхгүй байх төлөвтэй гэсэн үг юм. АНУ, Европ, Японы Төв банкууд эдийн засгаа дэмжих зорилгоор сүүлийн 2 жилийн хугацаанд бодлогын хүүний түвшинг тэг орчимд байлгаж, мөнгөний уламжлалт бус бодлого хэрэгжүүлж байна. Үүнтэй уялдан хүүний илүү өндөр өгөөж хайсан хөрөнгө оруулагчид хөгжиж буй орнуудыг зүглэж байлаа. Энэ хандлага нь хөгжиж буй орнуудын эдийн засагт халалт үүсгэх, урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэх, түүнийг хөрөнгө ба санхүүгийн дансаар нөхөх зэрэгт нөлөөлж байв. Харин АНУ-ын Төв банк 2013 оны 5 дугаар сард мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогоо энэ оны сүүлээр хязгаарлаж эхлэхээ зарласан нь урт хугацаат бондын хүү өсөхөд нөлөөлж, энэ нь улмаар хөгжиж буй орнуудаас хөрөнгө эргээд гадагшилж эхэлсний өдөөгч боллоо. Иймээс ирэх онд манай улсын гадаад худалдааны тааламжгүй нөхцөл эерэг чиглэлд огцом өөрчлөгдөхөөргүй, валютын орох урсгал мэдэгдэхүйц нэмэгдэхээргүй, төлбөрийн тэнцэлд бий болсон дарамт бүрэн арилахааргүй төлөв ажиглагдаж байна.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”, Чингис бондоор санхүүжигдэх төслүүд үргэлжлэн хэрэгжиж, мөнгө, зээлийн үзүүлэлтүүд тогтворжин, хөдөө аж ахуй, барилга, тээвэр ба агуулахын салбарын өсөлт өндөр байгаагийн зэрэгцээ Оюу толгой төслийн бүтээгдэхүүнийг 2013 оны 3-р улирлаас экспортолж эхэлсэн зэрэг нь оны сүүлийн хагаст эдийн засгийн бодит өсөлтөд эерэгээр нөлөөлөхөөр байна. Ингэснээр ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 14 орчим хувьд байх төсөөлөлтэй байна.

Энэ оны 9 дүгээр сард хийсэн инфляцийн интервалан үнэлгээгээр 2013 оны эцэст инфляци 8.7 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 5.0-13.7 хувийн хооронд, 2014 онд 10.3 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 5.4-17.3 хувийн хооронд байх төсөөлөлтэй байна. Инфляцийн төсөөллийг хийхдээ эрэлтийн талыг голчлон тусгасан. Улсын төсвийн гүйцэтгэл, төсвөөс гадуурх санхүүжилт, нийлүүлэлтийн гаралтай инфляци, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт зэрэг нь төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж болзошгүй юм.

Монгол Улс дахь валютын орох урсгал, түүний дотор экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт өнөөгийнхөөс сайжирч нэмэгдэхгүй, үргэлжлэн муудах тохиолдолд мөнгөний бодлогыг хатууруулах шаардлага ч үүсч болзошгүй бөгөөд энэ нь 2014 оны ДНБ-ий бодит өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Иймд 2014 онд эдийн засагт орж ирэх валютын урсгалыг нэмэгдүүлэх, экспортыг урамшуулах, тэвчиж болох импортын зардлыг бууруулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, улмаар гадаад зах зээлийн хамаарлыг алхам алхмаар багасгаж, эдийн засгийн дархлааг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүснэгт 3: Зарим гадаад, дотоод үзүүлэлтийн урьдчилсан таамаглал

		2013				2014			
		I	II	III	IV	I	II	III	IV
АНУ		1.1	1.7	2.3	2.6	2.8	3.0	3.0	3.0
БНХАУ		7.7	7.5	7.5	7.3	7.5	7.5	7.4	7.35
Инфляци									
АНУ		1.5%	1.8%	1.6%	1.5%	1.8%	2.1%	2.0%	2.1%
БНХАУ		1.9%	3.1%	2.7%	2.8%	3.4%	3.4%	3.5%	3.5%
Түүхий эдийн үнэ									
Нүүрс	\$/тн	87.8	77.8	86.2	89.2	92.5	91.7	93	93
Цэвэр зэс (дундаж төсөөлөл)		7510	6731	7159	7210	7156	7159	7140	7132
	Bloomberg төсөөлөл			7112	6879	6707	6477	6586	6615
	Bloomberg төсөөлөл			7165	7150	7060	7000	7035	7080
	EU төсөөлөл			7200	7600	7700	8000	7800	7700
Алт	\$/унц	1630	1415	1267	1300	1308	1309	1303	1283
Төмрийн хүдэр	\$/тн	137.3	116.5	119.5	112.65	113.5	114.5	110	114
Газрын тос (Brent)	\$/баррель	110.4	102.2	107.5	107.1	107.0	104.0	106.0	105.0
Газрын тос (Урал)	\$/баррель	108.6	101.7	103.8	103.5	103.8	101.4	101.8	103.1
ОХУ-н шатахууны татвар	\$/тн	328.1	280.3	312.5	312.5	312.5	312.5	312.5	312.5
Хүнсний үнийн индекс 2002=100		213.2	215.5		199.7				193.5
Санхүүжилтийн хуваарь									
Үнэ тогтворжуулах хөтөлбөр, цэвэр		49.4	1664.2	608.4	190.0	95.1	77.0	77.0	77.0
Чингис бондын хөрөнгө оруулалт /тэрбум			181.5	766.7	792.0	149.7	132.4	154.8	77.0
Монголбанкнаас банкуудад байршуулсан хадгаламж									
		850.0	50.0	-	-	-	-	-	-

Эх сурвалж: Монголбанк, Олон улсын санхүүгийн болон судалгааны байгууллагуудын төсөөлөл, тайлан

4.1 ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

4.1.1 Эдийн засгийн өсөлт


2013 оны эхний хагас жилд Монгол Улсын эдийн засаг 11.3 хувиар өслөө. Барилгын салбар 129.4 хувиар буюу хамгийн өндөр өсөлттэй байсан бол бөөний болон жижиглэнгийн худалдаа 3.1 хувиар буюу хамгийн бага өсөлттэй байв.

Хүснэгт 4: Бодит ДНБ, салбараар (тэрбум төгрөг)

	2007	2008	2009	2010	2011	2012	2013 I хагас*
ДНБ	3640	3964	3913.7	4162.8	4891.8	5498.5	2702.1
өсөлт	10.2%	8.9%	-1.3%	6.4%	17.5%	12.4%	11.3%
Уул уурхай	683.8	672.6	711.5	736.9	791	854.5	430.5
өсөлт	1.1%	-1.6%	5.8%	3.6%	7.3%	8.0%	6.1%
Уул уурхайн бус	2956.1	3291.3	3202.2	3425.8	4100.8	4643.9	2271.6
өсөлт	12.6%	11.3%	-2.7%	7.0%	19.7%	13.2%	12.4%
Хөдөө аж ахуй	734.1	768.4	796.3	664.2	660.7	803.2	426.8
өсөлт	14.4%	4.7%	3.6%	-16.6%	-0.5%	21.6%	20.6%
Боловсруулах үйлдвэрлэл	250.8	257.5	234.3	248.6	269.2	294.5	136.3
өсөлт	27.5%	2.7%	-9.0%	6.1%	8.3%	9.4%	6.6%
Цахилгаан, хий, уур, ус	98.8	106.8	113.4	112.8	122.3	126.6	70
өсөлт	6.3%	8.2%	6.1%	-0.5%	8.5%	3.5%	7.8%
Барилга	90.9	78.4	51.7	60.2	81.7	113.5	50.4
өсөлт	7.2%	-13.8%	-34.0%	16.5%	35.6%	38.9%	129.4%
Бөөний болон жижиглэн худалдаа	274.3	315.5	278.2	387.5	535.8	667.5	300.7
өсөлт	5.5%	15.0%	-11.8%	39.3%	38.3%	24.6%	3.1%
Тээвэр ба агуулах	356.8	425.5	459.4	491.5	536.3	585	276.8
өсөлт	25.2%	19.3%	8.0%	7.0%	9.1%	9.1%	5.7%
Мэдээлэл, холбоо	132.4	157.6	169.5	180.3	189.7	202.4	110.5
өсөлт	24.2%	19.0%	7.5%	6.4%	5.2%	6.7%	9.9%
Үйлчилгээний бусад салбар	608.5	701.3	705.5	710.9	804.9	948.5	517.1
өсөлт	5.9%	15.2%	0.6%	0.8%	13.2%	17.8%	13.0%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	409.5	480.2	394	569.9	900.2	902.7	382.9
өсөлт	6.8%	17.2%	-18.0%	44.7%	57.9%	0.3%	12.2%
*урьдчилсан гүйцэтгэл							

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Зураг 13: ДНБ-ий бодит өсөлт, салбараар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2013 оны эхний хагас жилийн байдлаар эрэлт талаас тооцсон ДНБ өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар өсчээ. Энэхүү өсөлтөд өрхийн хэрэглээний 20.4 нэгж хувийн өсөлт, гадаад худалдааны алдагдлын 8.6 нэгж хувийн бууралт гол нөлөө үзүүлсэн бол үндсэн хөрөнгийн хуримтлал болон засгийн газрын хэрэглээ тус бүр харгалзан -12.0, -4.9 нэгж хувиар буурч ДНБ-ий бодит өсөлтөд бууруулах нөлөө үзүүлжээ.

Зураг 14: Эрэлт талаас тооцсон ДНБ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4.1.2 Мөнгөний үзүүлэлтүүд

2013 оны 8 дугаар сарын байдлаар нийт импортын хэмжээ буурсан нь гадаад худалдааны алдагдал өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурахад нөлөөлөв. Харин хөрөнгө, санхүүгийн тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 43 хувиар буурч, урсгал тэнцлийн алдагдлыг санхүүжүүлж чадахгүйд хүрснээр гадаад валютын улсын нөөц 2013 оны эхнээс 33.9 хувиар буураад байна. Гадаад эх үүсвэрийн энэхүү бууралт нь М2 мөнгөний 12 хувийг эзэлж байна.

...
Дотоод эх
үүсвэрийг
нэмэг-
дүүлсний
нөлөөгөөр
М2
мөнгөний
нийлүүлэлт
20.2 хувиар
өсөв...


Харин М2 мөнгөний дотоод эх үүсвэр нь Монголбанкнаас хувийн хэвшлээр дамжуулж эдийн засагт нийлүүлсэн төгрөгийн нийлүүлэлт, Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн зээлүүд, Чингис бондын хөрөнгийн зарцуулалтын нөлөөгөөр оны эхнээс 91 хувиар өссөн байна.

Гадаад эх үүсвэр ийнхүү огцом буурсан ч, дотоод эх үүсвэрийн өсөлтийн нөлөөгөөр М2 мөнгөний нийлүүлэлт 2013 оны 8 дугаар сард жилийн 20.2⁵ хувиар өсөөд байна. Энэ нь 2012 оны 6 дугаар сараас хойш М2 мөнгөний жилийн өсөлт анх удаа 20 хувиас давсан үзүүлэлт боллоо.

М2 мөнгөний өсөлтийг пассив талаас нь төгрөгийн хадгаламжийн өсөлт голлон тайлбарлаж байна.


⁵ Улирлын зохицуулалт хийснээр 18.4 хувь

Зураг 15: M2 мөнгө, жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалжууд: Монголбанк


Зураг 16: M2 мөнгө, жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



4.1.3 Зээлийн өсөлт

2013 оны 8 дугаар сарын байдлаар банкны системийн нийт зээл жилийн 46.6 хувийн өсөлттэй байна. Тухайн сарын эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ 9783.1 тэрбум төгрөг хүрсэн нь 8410.1 тэрбум төгрөгийн M2 нийт мөнгөний нийлүүлэлттэй харьцуулахад 1.3 их наяд төгрөгөөр их байна. Зээлийн энэхүү өсөлтийн 54.6 хувийг хувийн хэвшлийн зээл, 44.6 хувийг иргэдийн зээл эзэлж байгаа юм.


Зураг 17: Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Монголбанк

Иргэдэд олгож байгаа зээлийн өсөлт 2012 оны эцэс хүртэл буурч байсан хэдий ч, орон сууцны ипотекийн болон цалингийн зээлийн нөлөөгөөр 2013 оны 2 дугаар улиралд 37.2 хувиар өсөөд байна.

Зураг 18: Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар ангилбал 2013 оны 2 дугаар улирлын байдлаар барилга болон үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээний салбарт 28 хувь, худалдааны салбарт 18 хувь, уул уурхай ба аж үйлдвэрийн салбарт 11 хувь нь тус тус ногдож байна. Бусад гэсэн ангилалд багтаж буй зээлүүд нь нийт зээлийн 22 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүний дийлэнх хувийг дээр дурдсан иргэдийн зээл эзэлж байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцооны хүрээнд 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 7-ны өдрийг дуустлах хугацаанд нийт 8924 иргэн 510.9 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр авчээ. Энэ нь банкны системд олгогдож байгаа зээлийн бүтцэд хэрэглээний зээл зонхилж байсан хандлагаас дундаж давхаргын хуримтлалын зээлд шилжих эерэг хандлага гарч байгаагийн илэрхийлэл юм.

4.1.4 Улсын төсөв

2013 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2013 оны эхний 8 сарын байдлаар 3450.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3581.4 тэрбум төгрөгт хүрч тэнцвэржүүлсэн төсвийн нийт тэнцэл 131.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хүснэгт 5: Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, тэрбум төгрөг (2013 оны эхний 8 сар)

	2012 I-VIII		2013 I-VIII		I-VIII 2013/2012
	Гүйцэтгэл	Хувийн жин	Гүйцэтгэл	Хувийн жин	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,126.1	100.0	3,484.5	100.0	111.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	25.5	0.8	34.3	1.0	134.5
1. УТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	23.1	0.7	7.6	0.2	32.7
2. УТ - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	0.8	0.0	6.0	0.2	728.0
3. УТ - Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	1.6	0.1	20.7	0.6	1,308.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,100.6	99.2	3,450.2	99.0	111.3
А. УРСГАЛ ОРЛОГО	3,089.5	98.8	3,449.5	99.0	111.7
I. ТАТВАРЫН ОРЛОГО	2,780.2	88.9	3,030.6	87.0	109.0
1. Орлогын албан татвар	544.5	17.4	672.0	19.3	123.4
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	418.7	13.4	528.4	15.2	126.2
3. Өмчийн татвар	12.4	0.4	21.6	0.6	174.2
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1,035.5	33.1	1,183.7	34.0	114.3
5. Гадаад худалдааны орлого	223.8	7.2	231.6	6.6	103.4
6. Бусад татвар	545.3	17.4	393.3	11.3	72.1
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309.3	9.9	418.9	12.0	135.4
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	10.0	0.3	0.7	0.0	6.7
Б. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1.0	0.0	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,582.6	100.0	3,581.4	100.0	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,761.0	77.1	2,816.0	78.6	102.0
1. Бараа, үйлчилгээний зардал	1,197.2	33.4	1,440.3	40.2	120.3
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	63.3	1.8	128.5	3.6	203.0
3. Татаас ба шилжүүлэг	1,500.6	41.9	1,247.3	34.8	83.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	779.9	21.8	718.0	20.0	92.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	41.6	1.2	47.3	1.3	113.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	328.5		633.5		192.8
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(482.1)		(131.2)		27.2

Эх сурвалж: Улсын төсвийн сарын гүйцэтгэл, Сангийн яам

Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 3484.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 11.5 хувь буюу 358.4 тэрбум төгрөгөөр их байна. Төсвийн нийт орлого ба тусламжийн 99 хувийг бүрдүүлсэн урсгал орлого 11.7 хувь буюу 360.0 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Урсгал орлогын 87.9 хувийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 9.0 хувь буюу 250.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 3030.6 тэрбум төгрөгт, татварын бус орлого 35.4 хувь буюу 109.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 418.9 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 73.8 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татвар 5.4 хувь буюу 44.9 тэрбум төгрөгөөр, тусгай зориулалтын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 2.5 хувь) 7.6 хувь буюу 2.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Харин онцгой албан татварын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 23.7 хувь) 56.6 хувь буюу 101.2 тэрбум төгрөгөөр огцом өссөн нь өмнөх онд түр цуцлаад байсан автобензин, дизель түлшинд ногдуулах онцгой албан татварыг сэргээсэн болон архи, тамхины онцгой албан татварыг нэмсэнтэй холбоотой юм. Түүнчлэн гадаад худалдааны орлогын 99.9 хувийг бүрдүүлдэг импортын барааны албан татварын орлогын өсөлт сүүлийн 2 жилд удааширч байна ⁶. Импортын барааны татварын орлого 2012 онд жилийн 1.6 хувиар өссөн бол энэ оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувь буюу 7.7 тэрбум төгрөгөөр өсчээ.

⁶ 2011 онд жилийн 74.6 хувийн өсөлттэй байв.

Зураг 21: Банкуудын хадгаламж, зээлийн хүү⁷



Эх сурвалж: Монголбанк


Хүснэгт 6: Хөтөлбөрийн зээл, шинээр олгосон зээл

	Шинээр олгосон зээлийн хэмжээ	Хөтөлбөрийн зээлийн хэмжээ	Хөтөлбөрийн зээлийн эзлэх хувь
2012.11	356.2	34.4	9.7%
2012.12	539.2	158.1	29.3%
2013.01	462.5	15.4	3.3%
2013.02	331.0	21.3	6.4%
2013.03	472.8	24.0	5.1%
2013.04	649.1	60.0	9.2%
2013.05	943.7	228.3	24.2%
2013.06	857.7	204.9	23.9%
2013.07	882.9	264.3	29.9%
2013.08	936.1	270.9	28.9%

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүүг 2013 оны 1, 4 болон 6 дугаар саруудад харгалзан 0.75, 1, 1 нэгж хувиар бууруулж, 3 дугаар сараас эхлэн “Хүүний коридор” шинээр нэвтрүүлсэн зэргээс шалтгаалан банк хоорондын захын хүү сүүлийн саруудад тогтмол буурч, мөнгөний бодлогын хүүтэй ойролцоо түвшинд байна.

2013 оны 7 дугаар сард банк хоорондын зах дээрх хэлцлийн хүүнүүд огцом буурч мөнгөний бодлогын хүүнээс бага түвшинд очсон. Үүний шалтгаан нь Монголбанкнаас ТБҮЦ-ны хэмжээг 6 дугаар сарын 10-наас 7 дугаар сарын 19 хүртэлх хугацаанд хязгаарласантай холбоотой байлаа. Гэвч 7 дугаар сарын сүүл, 8 дугаар сард валютын захад үүссэн сөрөг хүлээлт, огцом цочролын улмаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл нэмэгдсэнтэй уялдан ТБҮЦ-ны дээрх хязгаарлалтыг зайлшгүй зогсоох шаардлага гарсан. Ингэснээр энэ оны 8 дугаар сарын байдлаар банк хоорондын захын хүүнүүд эргэн өсч, мөнгөний бодлогын хүүний орчимд ирсэн байна.

Зураг 22: Банк хоорондын захын хүү



Эх сурвалж: Монголбанк

⁷ 2012 оны 12-р сараас хойш банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүүг тооцохдоо Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулан тооцсон.

4.1.6 Гадаад сектор, ханиш

Гадаад худалдаа, түүхий эдийн зах зээл

Гадаад худалдааны нийт эргэлт, худалдааны нөхцөл. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2013 оны эхний 8 сарын байдлаар 6,960.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7.6 хувиар буюу 571 сая ам.доллараар буурчээ. Үүнд экспорт 168.3 сая ам.доллараар, импорт 402.6 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 3,522 сая ам.доллар буюу 50.6 хувийг БНХАУ-тай, 1,032 сая ам.доллар буюу 14.8 хувийг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 10.7 хувиар, ОХУ-тай хийсэн худалдаа 21.4 хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 7: Гадаад худалдааны эргэлт, сая ам.доллар

Төрөл	Эхний 8 сар			Өөрчлөлт	
	2013	2012	2011	13/12	12/11
Эргэлт	6,960	7,531	7,039	-8%	7%
Экспорт	2,703	2,872	2,848	-6%	1%
Импорт	4,257	4,660	4,191	-9%	11%
Тэнцэл	(1,554)	(1,788)	(1,343)	-13%	33%

Зураг 23: Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2000 оны суурьтай) энэ оны 8 дугаар сарын байдлаар 1.422-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буураад байна. Үүнд зэсийн баяжмал, нүүрс болон бусад голлох экспортын бүтээгдэхүүний хилийн үнэ буурсан нь нөлөөлжээ. Гадаад худалдааны нөхцөл муудсан хэвээр байгаа энэхүү хандлага сүүлийн 23 сарын турш үргэлжилж байна.

Экспорт. Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 5.9 хувиар буурсан нь ашигт малтмалын экспорт 9.5 хувиар буурснаас шалтгаалж байна. 2013 оны 8 дугаар сарын байдлаар нийт экспортод ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 86.9 болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурлаа.


Хүснэгт 8: Экспорт, сая ам.доллар (2013 оны эхний 8 сар)

	2013		2012		Өөрчлөлт	
	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	Дүн	%
1. Ашигт малтмал	2,348		2,594		(245) ↓	-9%
Чулуун нүүрс	9,593	693	12,084	1,247	(554) ↓	-44%
Зэсийн баяжмал	395	563	382	558	5 ↑	1%
Төмрийн хүдэр/баяж.	4,327	442	4,309	356	86 ↑	24%
Боловсруулаагүй нефть	3,052	298	2,146	207	91 ↑	44%
Цайрын хүдэр ба баяж.	86	80	77	73	7 ↑	10%
Мөнгөжөөгүй алт	4,727	195	1,413	61	134 ↑	221%
Жонш, лейцит, нефелинг	221	56	282	66	(9) ↓	-14%
Молибдений хүдэр/баяж	3	21	3	26	(6) ↓	-21%
2. Ноос, ноолуур	211		164		46 ↑	28%
Ямааны угаа.ноолуур	3,915	181	3,418	137	43 ↑	32%
Ямааны сам.ноолуур	309	30	297	27	3 ↑	11%
3. Бусад	144		114		31 ↑	27%
Нийт дүн		2,703		2,872	(168) ↓	-6%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Ашигт малтмалын экспорт. Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт нь ашигт малтмалын экспортын 85 хувь, нийт экспортын 73.7 хувийг тус тус бүрдүүлж байгаа бөгөөд энэхүү хувь хэмжээ нь өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 6.3 нэгж хувь, 8.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 24: Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ



Эх сурвалж: Блүмберг, China coal resource

Хүснэгт 9: БНХАУ-ын түүхий эдийн импорт

	Эхний 7 сар		
	2013	2012	YoY, %
Нүүрс (сая тонн)	41.2	31.6	30%
Монгол	17%	35%	-18%
ОХУ	10%	8%	3%
Зэс (сая тонн)	5.4	4.0	37%
Монгол	5%	8%	-3%
Төмрийн хүдэр (мян.тонн)	457.7	424.9	8%
Монгол	1%	1%	0%
Түүхий нефть (мян.тонн)	164.3	161.9	1%

Эх сурвалж: Блүмберг

Экспортын биет хэмжээний бууралтаас гадна 2013 оны эхнээс дэлхийн зах зээл дээрх

коксжих нүүрсний үнэ 32 хувиар, А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ 11 хувиар, төмрийн хүдрийн үнэ 9 хувиар, түүхий газрын тосны үнэ 3 хувиар тус тус буурсан нь манай голлох бүтээгдэхүүнүүдийн экспорт буурахад мөн нөлөөллөө. Олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх үнийн тогтворгүй байдал дараагийн 12-18 сарын хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна.

БНХАУ-ын коксжих нүүрс болон зэсийн баяжмалын импортын хэмжээ эхний 7 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 30 хувь, 37 хувиар өссөн боловч түүнд эзлэх Монголын эрдэс бүтээгдэхүүний хувь буурсан байна. Энэ нь Монголын экспортын нүүрсний өрсөлдөх чадвар буурсан, БНХАУ руу нүүрс экспортлогч бусад орнууд зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлж нэмэгдүүлэхийн тулд нүүрсний үнэ буурснаас үл хамааран экспортын биет хэмжээгээ нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10: БНХАУ-ын аж үйлдвэрлэл, нүүрсний салбар

	Эхний 7 сар		
	2013	2012	YoY, %
Хятадын аж үйлдвэрлэлийн PMI индекс	50.5	51.4	-2% ▼
Түүхий гангийн үйлдвэрлэл (сая тонн)	455.8	419.5	9% ▲
Ган бүтээгдэхүүний үйлдвэрлэл (сая тонн)	609.5	549.2	11% ▲
Нүүрсний үйлдвэрлэл (сая тонн)	1750.0	1869.4	-6% ▼
Нүүрсний нөөцийн индекс (CR)			
Коксжих нүүрсний нөөц (CRCS)	401.5	498.8	-20% ▼
Эрчим хүчний нүүрсний нөөц (CRTS)	263.8	265.9	-1% ▼

Эх сурвалж: Блүмберг, China coal resource


БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн PMI индекс энэ оны эхний 7 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 0.9 нэгжээр буурч 50.5-д хүрсэн байна.

Хятадын аж үйлдвэрлэлийн индекс ийнхүү буурсан байгаа хэдий ч, коксжих нүүрс болон төмрийн хүдрийг үндсэн түүхий эд болгон хэрэглэдэг гангийн үйлдвэрлэл нь өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өсчээ.

БНХАУ-ын коксжих нүүрсний нөөц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар, үйлдвэрлэл 6 хувиар тус тус буурсан байна.

Алтны дэлхийн зах зээл дэх үнэ 2013 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар унц тутамд 1,395.3 хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 17.5 хувиар буурсан байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2013 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар харгалзан 7,077.5 болон 1,868.5 ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн үнэ 7 хувиар буурсан бол цайрынх 2.8 хувиар өсчээ.

Зураг 25: Лондоны металлын бирж дэх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ



Эх сурвалж: Блүмберг

Зураг 26: Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (сараар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импорт. 2013 оны эхний 8 сарын байдлаар нийт импортын 27 хувийг өргөн хэрэглээ, 51 хувийг аж үйлдвэрлэлийн түүхий эд материал, 20 хувийг шатахууны бүтээгдэхүүн, 1 хувийг бусад төрлийн бүтээгдэхүүн тус тус эзэлж байсан бөгөөд шатахууны бүтээгдэхүүний 37 хувийг уул уурхайн салбарт ашиглагддаг дизель түлш бүрдүүлж байгаагаас үзэхэд манай улсын нийт импортын 60 хувь нь аж үйлдвэрлэлийн зориулалттай, 40 хувь нь хэрэглээний зориулалттай байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар оны эхнээс 16.1 хувиар суларснаас шалтгаалан өргөн хэрэглээний бүтээгдэхүүний импорт энэ хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хувиар буурч, үүний дотор автомашин, түүний сэлбэг хэрэгсэл 13 хувиар, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл 21 хувиар, бусад гэр ахуйн бараа 17 хувиар тус тус буурчээ. Ханш ийнхүү эдийн засгийн суурь нөхцөлөө даган уян хатан тогтож байгаа нь гадаад худалдаа, эдийн засагт зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлж, хэрэглээний импорт буурч байгаа эерэг хандлага ажиглагдаж байна. Үүнтэй зэрэгцээд импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих боломж бас бүрдэж байна.

2013 он гарсаар гадаад, дотоодын хүчин зүйлсээс шалтгаалан уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт 40 гаруй хувиар буурсан нь хөрөнгө оруулалтаар санхүүжигддэг импорт, түүний дотор уул уурхайн машин, тоног төхөөрөмж ба түүний эд ангийн импорт 17 хувиар буурчээ.

Зураг 27: Дэлхийн зах зээл дэх Брент газрын тосны сарын дундаж үнэ



Эх сурвалж: Блүмберг

Дэлхийн зах зээлд газрын тосны үнэ 2013 онд 10 хувиар буурсан нь эдийн засгийн идэвхжил, аж үйлдвэрлэл төдийлөн сэргэж чадаагүйтэй шууд холбоотой.

Гэхдээ ОХУ-ын нефтийн бүтээгдэхүүний экспортын татвар, ойрхи дорнодын орнуудын улс төрийн нөхцөл байдал, дэлхийн ба бүс нутгийн геополитикийн олон асуудлаас шалтгаалж Монгол Улсын нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ өсөх эрсдэл байсаар байна.

Энэ тохиолдолд хилийн үнийн өсөлтийг дотоодын зах зээл дэх түлш шатахууны үнэд алгуурхан, жигд шингээх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй байх талаасаа чухал зохицуулалт болох билээ.

Хүснэгт 11: Импорт, сая ам.доллар (2013 оны эхний 8 сар)

Төрөл	2013		2012		Өөрчлөлт	
	Дүн	% жин	Дүн	% жин	Дүн	%
Өргөн хэрэглээ	1,167	27%	1,244	27%	(77)	↓ -6%
1.1 Хүнс	363	9%	358	8%	5	↑ 1%
1.2 Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл	35	1%	44	1%	(9)	↓ -21%
1.3 Гэр ахуйн бараа	163	4%	197	4%	(33)	↓ -17%
1.4 Хувцас	55	1%	49	1%	5	↑ 11%
1.5 Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	278	7%	318	7%	(40)	↓ -13%
1.6 Бусад	273	6%	277	6%	(4)	↓ -1%
Аж үйлдвэрлэлийн орц	2,183	51%	2,419	52%	(237)	↓ -10%
2.1 Машин,механик тоног төхөөрөмж	1,324	31%	1,599	34%	(276)	↓ -17%
2.2 Барилгын материал	636	15%	647	14%	(11)	↓ -2%
2.3 Химийн бүт	96	2%	94	2%	2	↑ 3%
2.4 Цахилгаан эрчим хүч	56	1%	15	0%	42	↑ 280%
2.5 Цемент	70	2%	64	1%	6	↑ 10%
Шатахууны бүтээгдэхүүн	853	20%	948	20%	(94)	↓ -10%
Бусад	54	1%	71	2%	(18)	↓ -25%
Нийт дүн	4,257	100%	4,682	100%	(426)	↓ -9%


Эх сурвалж: ГЕГ, Монголбанкны 2013 оны 9 сард шинэчилж тооцсон ангилал

2013 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах хандлагатай байснаас шалтгаалан өргөн хэрэглээний барааны импорт 6 хувиар буурсан, уул уурхайн салбарын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт өмнөх оноос буурсантай холбоотойгоор аж үйлдвэрлэлд шаардлагатай бүтээгдэхүүн болон шатахууны импорт 10 хувиар багассан нь нийт импорт 9 хувиар буурахад нөлөөллөө.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл


2013 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар нэмэгдэж -2,384.2 сая ам.доллар, хөрөнгө ба санхүүгийн тэнцлийн ашиг 48.9 хувиар буурч 1,281.5 сая ам.долларт хүрсэн бөгөөд төлбөрийн нийт тэнцэл 1,397.0 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Зураг 28: Төлбөрийн тэнцэл




Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 29: Урсгал тэнцэл




Урсгал данс. Төлбөрийн тэнцэл дэх урсгал тэнцлийн алдагдал 2013 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2,384.2 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй ойролцоо түвшинд байна. Үүнд барааны гадаад худалдааны алдагдал өмнөх оноос 17.5 хувиар буурч 1,014 сая ам.долларт хүрсэн хэдий ч, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 23.6 хувиар өсч 907.1 сая ам.долларт хүрсэн нь нөлөөлжээ. Урсгал тэнцэл 2007 он хүртэл харьцангуй тогтвортой бага түвшинд буюу дунджаар ДНБ-ий 6 хувьтай тэнцүү хэмжээнд байсан бол 2008 оноос эхлэн уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт, түүгээр санхүүжигдсэн машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын импортын өсөлт болон нефтийн бүтээгдэхүүн, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өсөлтөөс шалтгаалж 2008 онд ДНБ-ий 12 хувь, 2011 онд 31 хувь, 2012 онд 32 хувьд хүрсэн бөгөөд 2013 оны эхний хагас жилийн байдлаар 33 хувьд хүрээд байна.

Зураг 30: Барааны гадаад худалдаа



Зураг 31: Үйлчилгээний гадаад худалдаа



Эх сурвалж: Монголбанк


Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн: Үйлчилгээний гадаад худалдааны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тогтвортой байсан бол зардал нь 12.7 хувиар өссөнөөс шалтгаалж үйлчилгээний дансны алдагдал 173.1 сая ам.доллараар өсөв. Үүнд барилгын үйлчилгээний зардал 77.2 сая ам.доллараар, зорчигч болон ачаа тээврийн зардал 62.1 сая ам.доллараар өсч, аялал жуулчлалын үйлчилгээний орлого 31.1 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Орлогын дансны алдагдал өнгөрсөн оны түвшинд байна: Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж /ААН/, иргэд нь эдийн засгийн харьяат бусаас авсан гадаад зээл, өрийн бичиг болон харилцах, хадгаламжийн хүүний төлбөр, ногдол ашигт 425.6 сая ам.долларын төлж, Монгол Улсын ААН-үүдэд ажиллаж буй эдийн засгийн харьяат бус иргэдэд 162.3 сая ам.долларын цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогыг гадагш нь шилжүүлснээр цэвэр орлогын данс 553.7 сая ам.долларын алдагдалтай гараад байна.

Урсгал шилжүүлгийн дансны ашиг буурчээ: Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулга, гадаадын Засгийн газар, олон улсын байгууллагын шилжүүлсэн хандив тусламжийн дүн нь өмнөх оны мөн үеэс 134 сая ам.доллараар буурч, гадаад улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулга, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн зардлын дүн 22.8 сая ам.доллараар буурсан нь урсгал шилжүүлгийн дансны ашиг 2.2 дахин буурч 90.7 сая ам.доллар болоход нөлөөлөв.

Хөрөнгө, санхүүгийн данс. 2013 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 2 дахин буурч 1,281.5 сая ам.долларт хүрэв.

Зураг 32: Хөрөнгө, санхүүгийн данс



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 33: Гадаад валютын улсын нөөц



Дотоодын болон олон улсын зах зээл дэх тодорхой бус нөхцөл байдлын улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 46.8 хувиар буурч 1,814.5 сая ам.долларт хүрсэн, Монгол Улсын Засгийн газар, аж ахуйн нэгжүүд олон улсын зах зээлд шинээр үнэт цаас гаргаагүй тул багцын хөрөнгө оруулалтын дансны орох урсгал эрс буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын орлого буурснаас шалтгаалан бэлэн мөнгө ба харилцах данс 873.3 ам.доллараар буурсан нь хөрөнгө санхүүгийн дансны нийт ашиг огцом буурахад нөлөөллөө.

Гадаад валютын улсын нөөц. 2013 оны эхний 8 сарын байдлаар урсгал дансны алдагдлыг хөрөнгө, санхүүгийн дансны ашгаар нөхөж чадаагүй тул гадаад валютын улсын нөөц оны эхнээс 1,400.1 сая ам.доллараар буурч 2,725.5 сая ам.долларт хүрлээ.

Сүүлийн жилүүдэд урсгал дансны өндөр алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад зээлээр бүрэн санхүүжүүлж ирсэн боловч 2013 онд урсгал тэнцлийн алдагдал өнгөрсөн онтой харьцуулахад мэдэгдэхүйц буураагүй байхад гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан нь төлбөрийн тэнцэлд дарамт үүсгэж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах чиглэлд нөлөөллөө.

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц. Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2013 оны 2-р улирлын эцэст -17,806.1 сая ам.доллар байв. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа томоохон компаниудын хөрөнгө оруулагчаасаа авсан зээлийн өсөлтөөс голлон шалтгаалж байна.


Хүснэгт 12: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллар (2013 оны II улирал)

		/Сая ам.доллар/		
А. ГАДААД АКТИВ		4,682.0	Б. ГАДААД ПАССИВ	22,488.0
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)		521.1	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас) 15,014.8	
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт		509.7	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт 4,985.7	
1.2 Бусад хөрөнгө		11.3	6.2 Бусад хөрөнгө 10,029.0	
2. Багцын хөрөнгө оруулалт		118.3	7. Багцын хөрөнгө оруулалт 2,673.7	
2.1 Хөрөнгийн хувьцаа		109.0	7.1 Хөрөнгийн хувьцаа 99.6	
2.2 Өрийн бичиг		9.3	7.2 Өрийн бичиг 2,574.2	
3. Санхүүгийн дериватив		0.0	8. Санхүүгийн дериватив 0.0	
4. Бусад хөрөнгө оруулалт		935.1	9. Бусад хөрөнгө оруулалт 4,799.5	
4.1 Худалдааны зээл		425.3	9.1 Худалдааны зээл 261.4	
4.2 Зээл		14.5	9.2 Зээл 3,838.9	
4.2.1 Төв банк		0.0	9.2.1 Төв банк 74.7	
4.2.2 Засгийн газар		0.0	9.2.2 Засгийн газар 2,132.1	
4.2.3 Банк санхүүгийн байгууллага		14.5	9.2.3 Банк санхүүгийн байгууллага 440.1	
4.2.4 Аж ахуйн нэгж		0.0	9.2.4 Аж ахуйн нэгж 1,192.1	
4.3 Бэлэн мөнгө ба харилцах		495.4	9.3 Бэлэн мөнгө ба харилцах 202.6	
4.4 Бусад актив		0.0	9.4 Бусад пассив 496.6	
5. Нөөц актив		3,107.5	В. ПОЗИЦ (17,806.1)	
5.1 Мөнгөжсөн алт		165.1	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр) (14,493.7)	
5.2 Зээлжих тусгай эрх		65.6	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр) (2,555.5)	
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)		0.2	12. Санхүүгийн дериватив (цэвэр) 0.0	
5.4 Бэлэн валют ба харилцах		1,948.5	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр) (3,864.4)	
5.5 Үнэт цаас		928.0	14. Нөөц актив 3,107.5	
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)		0.0		
5.7 Бусад нөөц актив		0.0		

Эх сурвалж: Монголбанк


Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дүн 4,682.0 сая ам.доллар байна. Үүний 66 хувийг гадаад валютын улсын нөөц, 20 хувийг бусад хөрөнгө оруулалтын актив, 11 хувийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 3 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна. Гадаад активын дүн харьцангуй тогтвортой байдаг бөгөөд өөрчлөлт нь гадаадад хийсэн шууд хөрөнгө оруулалт, нөөц активаас голлон хамаарна.

Зураг 34: Гадаад актив



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 35: Гадаад пассив



Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын нийт үлдэгдэл дүн 22,488.0 сая ам.долларт хүрчээ. Үүний 67 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 21 хувийг бусад хөрөнгө оруулалтын пассив,


үлдсэн 12 хувийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 33 хувийг буюу 4,985.7 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 67 хувь буюу 10,029.0 сая ам.долларыг толгой компаниас охин компанийн авсан зээл эзэлж байна.

Монгол Улсын нийт гадаад өр. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл (Засгийн газар, Төв банк, хувийн хэвшлийн нийт гадаад өрийн дүн) сүүлийн жилүүдэд тасралтгүй өссөөр байна. Тухайлбал уг үзүүлэлт 2013 оны 2-р улирлын байдлаар 17,402.7 сая ам.долларт хүрч оны эхнээс 2,017.1 сая ам.доллараар буюу 13.1 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 13: Нийт гадаад өрийн үлдэгдэл, сая ам.доллар

Зураг 36: Гадаад өрийн үлдэгдэл

Үзүүлэлт	12/31/2012	6/30/2013	YoY, %
Нийт гадаад өр	15,385.7	17,402.7	13%
I. Засгийн газар	4,264.1	4,222.5	-1%
II. Төв банк	413.9	481.2	16%
III. Банк	1,074.4	1,216.5	13%
Богино хугацаат	58.2	61.3	5%
Урт хугацаат	1,016.1	1,155.2	14%
IV. Бусад сектор	1,276.0	1,453.5	14%
Богино хугацаат	508.2	468.6	-8%
Урт хугацаат	767.7	985.0	28%
V. Хөрөнгө оруулагч зээл	8,357.4	10,029.0	20%



Эх сурвалж: Монголбанк

Гадаад өрийг салбараар нь авч үзвэл:

- Төрийн байгууллага: Засгийн газар, Монголбанкны гадаад өр 1,928 сая ам.доллараар нэмэгдэж 4,703.7 сая ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь 2012 оны ДНБ-ий 46 хувьтай тэнцүү байна.
- Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд оны эхнээс 1,991.3 сая ам.доллараар нэмэгдэж 12,699 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2013 оны 2-р улирлын байдлаар 1,216.5 сая ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 13.2 хувиар буюу 142.1 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 40 хувийг бонд, өрийн бичиг, 31 хувь нь урт хугацаат зээл, 17 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг, 7 хувийг бусад өглөг, үлдсэн 5 хувийг богино хугацаат зээлийн эх үүсвэр тус тус бүрдүүлж байна.

Банкнаас бусад хувийн хэвшлийн гадаад өр. Банкнаас бусад салбар буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2013 оны 2-р улирлын эцэст 11,482.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны эцсийн гүйцэтгэлээс 19.2 хувиар буюу 1,849.2 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Салбарын нийт зээлийн 87.3 хувь буюу 10,029 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл (компани хоорондын өглөг) бөгөөд үүний 95 хувь нь уул уурхайн салбарт ашиглагджээ. Энэ

төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарьгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 1,646.5 төгрөгт хүрч, тайлант оны эхнээс 18.2 хувиар буюу 254.1 төгрөгөөр суларчээ.


Төгрөгийн ханш ийнхүү сулрах болсон суурь шалтгаан нь гадаад валютын орох урсгал эрс татарсан, гадаад худалдааны нөхцөл тасралтгүй муудсан явдал юм. Тухайлбал, 2013 оны эхний 8 сард экспортын орлого 28 хувиар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 47 хувиар тус тус буураад байна.

Зураг 37: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Зураг 38: Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл



2013 оны 8 дугаар сарын байдлаар ханшийн нэг өдөрт ногдох хэлбэлзэл нийт өдрийн 80 хувьд нь 0-4 төгрөг, үлдсэн 20 хувьд нь хамгийн ихдээ 1.69 хувиар хэлбэлзсэн бөгөөд дундаж хэлбэлзэл нь 0.21 хувь буюу 2012 оны мөн үеэс 0.04 нэгж хувиар өсч, 2011 оны мөн үеэс 0.03 нэгж хувиар буурсан байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр, зах зээлийн орчны өөрчлөлттэй уялдан чөлөөтэй тогтож, өнгөрөгч оны дунд үеэс эхлэн суларч байгаа хандлага нь гадаад зах зээлийн эрсдэлийн дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг ханшид шингээх замаар зөөлрүүлэн, дотоодын эдийн засаг, гадаад худалдаа, санхүүгийн зах зээлд шаардлагатай тохиргоог хийж байна.

Засгийн газрын үнэт цаас

Зураг 39: Засгийн газрын үнэт цаасны арилжаа



Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны арилжааг идэвхижүүлэх, захыг хөгжүүлэх, тогтмол арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг 2012 онд, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг 2013 онд баталж, ЗГҮЦ-ыг Монголбанкаар дамжуулан банк, аж ахуй нэгж байгууллага, иргэдэд амжилттай арилжаалж байна.

2013 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 41 удаагийн ЗГҮЦ-ны анхдагч захын арилжааг Монголбанк зохион байгуулсан бөгөөд хугацааны хувьд 12 долоо хоног, 28 долоо хоног, 52 долоо хоног, 3 жил, 5 жилийн хугацаатай үнэт цааснуудыг арилжаалсан байна. 2013 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар Монголбанкаар дамжуулан арилжаалсан ЗГҮЦ-ны нийт үлдэгдэл 1,026 тэрбум төгрөг болж байна.

4.1.7 Инфляци

2013 оны 8 дугаар сарын байдлаар хэрэглээний үнийн улсын индекс өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 8.4 хувиар тус тус өссөн. Харин сарын инфляци улсын хэмжээнд 1.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 2.6 хувь байсан бол Улаанбаатар хотын суурь инфляци 8 дугаар сарын байдлаар 9.6 хувь байлаа.


Зураг 40: Улсын болон Улаанбаатар хотын инфляци



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

8 дугаар сар дахь Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан үзвэл 9.3 хувийг (0.8 нэгж хувь) мах, 12.8 хувийг (1.1 нэгж хувь) махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 15.4 хувийг (1.3 нэгж хувь) төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, 1.4 хувийг (0.1 нэгж хувь) шатахууны үнийн өсөлт тайлбарласан бол үлдсэн 61.1 хувь (5.1 нэгж хувь)-ийг бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна. Сүүлийн саруудад нийлүүлэлтийн шалтгаантай болон Засгийн газраас хамааралтай үнийн өсөлтийн жилийн инфляцид эзлэх хувь, хэмжээ буурч байгаа бөгөөд 8 дугаар сарын байдлаар тухайн шалтгаантай инфляци жилийн инфляцийн 38.9 хувийг бүрдүүлж байв.

Зураг 41: Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа, бүлгээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4.1.8 Банкны салбарын тогтвортой байдал

Санхүүгийн институциудын харилцан уялдаатай тогтолцоо болох санхүүгийн салбар нь санхүүгийн хөрөнгийг бий болгож, түүнийг зах зээлд үр ашигтай хуваариалан, оновчтой хөрөнгө оруулалтад байршуулах замаар бодит эдийн засгийн өсөлт, хөгжилд голлох нөлөөг үзүүлдэг. Дэлхий нийтийг хамарсан даяарчлалын үр нөлөөгөөр улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа өргөжин тэлэхийн хэрээр санхүүгийн салбарын бодит эдийн засагт гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө нь улам бүр өсөн нэмэгдэж, түүнийг дагасан өөрчлөлт, шинэчлэлт санхүүгийн зах зээлд хөгжил, дэвшил авчирч, зах зээлд оролцогчдод өргөн боломжийг нээхийн зэрэгцээ, санхүүгийн системийн эмзэг байдал, эрсдэлийг ч өсгөөд байна. 2008 оноос эхлэн үргэлжилж буй дэлхийн нийтийг хамарсан санхүүгийн системийн хүндрэлтэй нөхцөл байдал нь дээрхийн тод жишээ бөгөөд хүрээгээ хурдацтай тэлж буй санхүүгийн салбарт тодорхой хяналт, зохицуулалт, түүний тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого зайлшгүй шаардлагатай болохыг харуулсан.


Зураг 42: Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг) ба хөрөнгөөр тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо.

Тэмдэглэл: Үнэт цаасны оролцогч компаниудын хөрөнгийг тооцохдоо андеррайтерын үйл ажиллагаа явуулж буй Голомт банкныг хасч тооцсон.

Зураг 43: Ашиг (тэрбум төгрөг) ба ашигаар тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах Хороо.

Тэмдэглэл: Үнэт цаасны оролцогч компаниудын ашигийг тооцохдоо андеррайтерын үйл ажиллагаа явуулж буй Голомт банкныг хасч тооцсон.

Монгол Улсын санхүүгийн системийн 95 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж, санхүүгийн зах зээл нь хөгжлийнхөө эхэн үед явж буй хэдий ч, санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудалд дан ганц мөнгөний бодлого, банкны салбарыг тойрсон асуудлаар хандах бус санхүүгийн дэд салбарууд дахь тэнцвэртэй хөгжил, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн үр ашигтай, харилцан уялдаатай макро болон микро түвшний бодлогууд, нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилттой уялдсан санхүүгийн институци, дэд бүтцийн оновчтой шат дараалсан реформ, олон нийтийн санхүүгийн салбарын талаарх суурь ойлголт, мэдлэг, төлөвшилийг хамарсан санхүүгийн тогтвортой байдлын ерөнхий хүрээ байдлаар авч үзэх нь зүйн хэрэг юм. Дэлхий нийтэд ч энэ хандлага хүрээгээ тэлж, багагүй өөрчлөлтийг бий болгож байна.

Санхүүгийн систем дэх Монголбанкны үндсэн үүрэг нь санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах явдал мөн бөгөөд манай улсын хувьд банкны салбарын тогтвортой байдал нь санхүүгийн тогтвортой байдлын гол цөм юм. Энэхүү үүргийг хэрэгжүүлэх хүрээнд банкны үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж байна. Монголбанк санхүүгийн системийн үр ашигтай, тогтвортой байдлыг дэмжих, банкны үйл ажиллагааны доголдлоос санхүүгийн системд учруулж болзошгүй хор хохирлоос зайлсхийх зорилгоор банкуудад хяналт, шалгалтыг тогтмол хийсээр ирсэн. Мөн 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталснаар хадгаламжийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, улмаар банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чухал алхам болов.

Түүнчлэн, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль” 2013 оноос хэрэгжиж байгаатай холбогдуулан уул уурхайн цөөн нэр төрлийн эрдэс, түүхий эдийн экспортоос хамаарал бүхий эмзэг эдийн засгийн хувьд мөчлөг дагасан төсвийн бодлогын санхүүгийн системд үзүүлэх сөрөг нөлөө буурч, санхүүгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлөх хандлагатай байна.

Санхүүгийн систем банкны салбарт суурилж буй хэдий ч, иргэдийн багагүй хэсэг нь банк

бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлж, тэдгээр байгууллагын үйл ажиллагаа ойрын жилүүдэд эрчимтэй идэвхжих хандлагатай байна. Тухайлбал, 2013 оны эхний хагас жилийн байдлаар нийт бүртгэлтэй 229 Банк бус санхүүгийн байгууллага, 142 Хадгаламж зээлийн хоршоо, 94 Брокер диллерийн байгууллага, 17 Даатгалын компани, 326 Хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх бүр нэмэгдэж, үйл ажиллагааных нь цар хүрээ тэлсээр байна. Санхүүгийн салбарыг тэнцвэртэй хөгжүүлэх зорилгоор холбогдох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр зохих арга хэмжээг, шат дараатайгаар авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийг батлагдаж, улмаар түүнд нийцүүлсэн салбар хууль, журмууд ар араасаа батлагдахаар төлөвлөгдөж байгааг дурьдаж болно.


Олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, санхүүгийн салбарын талаарх бодит мэдээллийг нийтэд тэгш, цаг тухайд нь хүргэж, бодит хүлээлтийг төлөвшүүлэх нь санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн анхны дугаарыг бэлтгэж, олон нийтийн хүртээл болгоод байгаа бөгөөд цаашид хагас жил тутам гаргахаар шийдвэрлэсэн болно.

Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Банкны салбарт 13 банк (эрх хүлээн авагч томилогдсон нэг банк) нийт 1404 салбар нэгж, 14,217 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Банкуудын нийт харилцах данс эзэмшигчдийн тоо 2013 оны 8 дугаар сарын байдлаар 7.9 сая болж өмнөх оны мөн үеэс 0.7 саяар өссөн байна. Мөн нийт хадгаламж эзэмшигчид 2.4 сая, зээлдэгчид 684.5 мянгад хүрлээ.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2013 оны эхний 8 сарын байдлаар 16.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 64.2 хувиар буюу 6.4 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилт, банкуудын хадгаламжийн өсөлтөөс шалтгаалан эх үүсвэрийн хэмжээ 14.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.2 их наяд төгрөгөөр нэмэгдлээ.

Зураг 44: Нийт хөрөнгийн динамик, тэрбум.төгрөг, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Банкуудын хөрвөх чадвар өндөртэй активын хэмжээ 5.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх

оны мөн үеэс 90.5 хувиар буюу 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Хөрвөх чадвар өндөртэй активын 41.6 хувь болох 2.2 их наяд төгрөгийг богино хугацаат хөрөнгө оруулалтад, 58.4 хувь болох 3.1 их наяд төгрөгийг мөнгөн хөрөнгөд байршуулжээ. Эх үүсвэрийн өсөлттэй уялдуулан банкууд хөрвөх чадвар өндөртэй активын хэмжээг нэмэгдүүлсээр байгаа бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 40.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 8.5 нэгж хувиар нэмэгджээ.

Зураг 45: Хөрвөх чадвар, эх үүсвэрийн динамик, тэрбум.төгрөг, хувиар




Эх сурвалж: Монголбанк

хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

Зээлийн тасалдлаас сэргийлэх, нийт эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр Монголбанкнаас өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд зээлийн өсөлт 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар жилийн 46.6⁸ хувийн өсөлттэй байна. Зээлийн өрийн үлдэгдэл 9.7⁹ их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.1 их наяд төгрөгөөр, оны эхнээс 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Чанаргүй зээлийн хэмжээ 320 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 91.1 хувиар буюу 152.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Чанаргүй зээлийн энэхүү өсөлт нь Хадгаламж банкинд Монголбанкнаас "Банкны тухай хууль"-ийн дагуу эрх хүлээн авагч томилол албадлагын арга

Зураг 46: Зээлийн динамик, тэрбум.төгрөг, хувиар



Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн хэмжээнд чанаргүй зээлийн харьцаа 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар, оны эхнээс 1.1 нэгж хувиар нэмэгдлээ. Зээлийн үлдэгдэл нийт активын 58.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.5 нэгж хувиар буурчээ. Нийт зээлийн багцын 53.8 хувь буюу 5.2 их наяд төгрөгийг хувийн секторт, 42.3 хувь буюу 4.1 их наяд төгрөгийг иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна. Нийт зээлийн үлдэгдлийн 29.7 хувь болох 2.8

⁸ Энд арилжааны банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдлээс Анод, Зоос банкуудын зээлийн өрийн үлдэгдлийг хасч тооцсон.

⁹ Энд арилжааны банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдлээс Анод, Зоос банкуудын зээлийн өрийн үлдэгдлийг хасч тооцсон.

их наяд төгрөгийг гадаад валют, үлдэх 70.3 хувь болох 6.8 их наяд төгрөгийг дотоодын валютаар олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Зураг 47: Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбараар




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн голлох салбаруудаар ангилахад үндсэн таван салбарт нийт зээлийн багцын 66.5 хувь болох 5.6 их наяд төгрөг ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт багатай байна. Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 1.5 их наяд, барилга угсралтын салбарт 1.2 их наяд, үл хөдлөх эд хөрөнгийн салбарт 1.1 их наяд, боловсруулах үйлдвэрлэлд 0.9 их наяд, уул уурхайд 0.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Чанаргүй зээлийн харьцааг салбараар авч үзэхэд уул уурхайн салбарт 3.4 хувь, боловсруулах салбарт 3.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаанд

2.4 хувь, барилгын салбарт 1.7 хувь, үл хөдлөх эд хөрөнгийн салбарт 0.8 хувь тус тус ногдож байна.

Банкны салбарын активын бүтцэд эзлэх зээлийн хэмжээ 2013 он хүртэл тогтмол өсч байсан бол 2013 оны 8 дугаар сарын байдлаар уг үзүүлэлт буурсан байна. Энэ нь банкууд төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Монголбанк дахь харилцах данс зэрэг хөрвөх чадвартай активаа нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

Зураг 48: Хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк, арилжааны банкуудын нэгдсэн тайлан


Богино хугацаат хөрөнгө оруулалтын эзлэх хэмжээ 2013 оны 8 дугаар сарын байдлаар 13.3 хувьтай байгаа нь оны эхнээс 3 нэгж хувиар их байна. Түүнчлэн банкуудын урт хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байгаа нь Засгийн газрын 1 жилээс дээш хугацаатай үнэт цаасны хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд бусад активын хэмжээг өсгөж нийт активын 10.5 хувийг бүрдүүлж байна.

Банкны салбарын нийт эх үүсвэр 14.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс

6.2 их наяд төгрөгөөр буюу 70 хувиар нэмэгдэн, дотоодын нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувьд хүрээд байна. Эх үүсвэрийн өсөлтөд харилцах, хадгаламж болон банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт голлох нөлөөг үзүүлээ.

Банкуудын харилцах 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 2.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 17.5 хувиар буюу 0.4 их наяд төгрөгөөр, нийт хадгаламж 6.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өслөө.

Зураг 49: Харилцах, хадгаламж (тэрбум.төгрөг, хувиар)



Эх сурвалж: Монголбанк

Хувийн хэвшлийн харилцах 210.6 тэрбум төгрөгөөр, иргэдийн харилцах 114.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь харилцахын өсөлтөд голлох нөлөөг үзүүлсэн бол хугацаатай хадгаламжийн хэмжээ 53.4 хувиар буюу 1.7 их наяд төгрөгөөр өсч, 5 их наяд төгрөгт хүрсэн нь хадгаламжийг өсгөсөн гол шалтгаан боллоо.

Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ оны эхний 8 сарын байдлаар 3.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.1 дахин буюу 3 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Банкуудын Монголбанкнаас авсан эх үүсвэрийн хэмжээ 2.2 их наяд төгрөгөөр, гадаадын банкнаас авсан эх үүсвэрийн хэмжээ 228.6 тэрбум төгрөгөөр, бусад зээл 348.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.


Өөрийн хөрөнгийн хэмжээ 2013 оны эхний 8 сарын байдлаар 1.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 20.3 хувиар буюу 234.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн, системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлсэн, бүх банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн шаардлагыг өсгөсөн, ашигт ажиллагаа сайжирсантай холбоотой байна. Нийт өөрийн хөрөнгийн 76.8 хувь болох 1.1 их наяд төгрөг нь дотоодын валютаар байршсан бол 23.2 хувь болох 321.2 тэрбум төгрөг нь гадаад валютаар байршжээ.

Банкны системийн хэмжээнд ашигт ажиллагаа сайжирсаар байгаа бөгөөд 2013 оны эхний 8 сарын байдлаар цэвэр ашгийн хэмжээ 170.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.3 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Банкуудын ашигт ажиллагаа ийнхүү нэмэгдэхэд хүүний орлого, ханшийн тэгшитгэл, арилжааны орлогын өсөлт нөлөөлжээ. Хүүний орлогын хэмжээ 845 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 192.2 тэрбум төгрөгөөр өссөн бол хүүний зардал 536.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 143.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Эх үүсвэрийг хугацааны бүтцээр нь авч үзвэл 2013 оны 8 дугаар сарын байдлаар харилцах, хадгаламжийн эзлэх хувь буурсан байна. Энэ нь банкны салбарын бусад санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэрийн өсөлттэй холбоотой юм.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хүрээнд банкны салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын өсөлт нь бусад эх үүсвэрийг нэмэгдүүлснээр 2013 оны 8 дугаар сарын байдлаар банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ нийт эх үүсвэрийн 22 хувийг эзлэх болсон байна. Нийт эх үүсвэрт эзлэх харилцах, хадгаламжийн хувийн жин 56.4 хувь байгаа нь оны эхний үзүүлэлтээс 13.7 нэгж хувиар бага байна.

Зураг 50: Эх үүсвэрийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк, Арилжааны банкуудын нэгдсэн тайлан

Энгийн сценарит суурилсан мэдрэмтгий байдлын шинжилгээ (стресс тест)


Гэнэтийн шок бий болсноор банкны салбарт үзүүлэх нөлөөг тооцох мэдрэмтгий байдлын шинжилгээг зээлийн эрсдэлээс үүдэлтэйгээр банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөх, эх үүсвэр гадагшилснаас үүдэлтэйгээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт хэрхэн буурах эрсдэл талаас нь хийв¹⁰.

Зураг 51: Зээлийн эрсдэлийн стресс тест



Эх сурвалж: Монголбанк

Зураг 52: Хөрвөх чадварын эрсдэлийн стресс тест



Тайлбар: Зээлийн эрсдэлийн хувьд сул, дунд болон хүчтэй сценариудыг сонгохдоо

¹⁰ Шинжилгээг хоёрдугаар улирлын байдлаархи тоон үзүүлэлтүүд дээр хийв.

одоогийн чанарын ангилалд бүртгэлтэй байгаа зээлийн үлдэгдэл нь харгалзан 10, 20 болон 30 хувиар нэг ангиллаар буурах (муу зээлийн ангилалд байгаа зээл ангилал шилжихгүй) тохиолдлуудыг сонголоо. Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь нь гадагшлах тохиолдолд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанд орох өөрчлөлтүүдийг харуулав.

Сул сценарийн хувьд банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 0.4 нэгж хувь, дунд сценарийн хувьд 1.1 нэгж хувь, харин хүчтэй сценарийн хувьд 1.6 нэгж хувиар тус тус буурахаар байна. Шинжилгээнээс харахад өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд нь дээрх сценариудын дараах байдлаар зохистой харьцааны хамгийн доод шаардлагаас 2.3-3.4 нэгж хувиар өндөр байна. Харин системийн нөлөө бүхий банкуудад тавигдаж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээний хамгийн бага шаардлагаас 0.3-1.4 нэгж хувиар илүү байна. Нийт эх үүсвэрийн 5, 10 болон 15 хувь гадагшлахад банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 3-9.9 нэгж хувиар буурах төсөөлөл гарч байна. Энэ нь Монголбанкнаас тавьдаг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны хамгийн доод шаардлагаас 8.9-15.8 нэгж хувиар илүү байна.

Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, түүнд хяналт тавих журам”-ын дагуу өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт системийн хэмжээнд 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 14.4 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурлаа. Энэ нь банкуудын өөрийн хөрөнгийн өсөлт нь активын өсөлтийн хурдаас бага байсныг харуулж байна.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 10.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар бага байна. Нийт эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 9.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ. 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээг бүх банк ханган¹¹ ажиллаж байна.

Зураг 53: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт, тэрбум төгрөг, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 2013 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 40.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 8.5 нэгж хувиар өслөө.

¹¹ Монголбанкнаас эрх хүлээн авагч томилогдсон хадгаламж банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан.

Зураг 54: Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (ТТГЧ)-ын харьцаа

Эх сурвалж: Монголбанк

Банкуудын эх үүсвэрийн өсөлт өндөр байсан ч ТТГЧ-ын үзүүлэлт өндөр байгаа нь Монголбанк дахь харилцах, Төв банкны болон Засгийн газрын үнэт цаасны хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд банкуудын хөрвөх чадвар бүхий активын хэмжээ нэмэгдсэн нь нөлөөллөө. "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур" үзүүлэлтийг (25%) бүх банкууд хангаж байна.

Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн хязгаарлалт болон банкны холбогдох этгээдэд олгосон зээлийн хязгаарлалтыг хангаагүй байгаа зарим банкуудад албадлагын арга хэмжээг авч ажиллаж байна. Зээлийн зах зээлийн төвлөрөл өндөр хэвээр байсаар байгаа ба Херфиндалын индексээр зээлийн зах зээлийн үзүүлэлт 2013 оны 8 дугаар сарын байдлаар 17.4 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурлаа.

Гадаад валютын цэвэр нээлттэй позицийн хэмжээ оны эхний 8 сарын байдлаар (23.6) тэрбум төгрөгт хүрэв. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларч байгаа нь банкуудаас зах зээлийн эрсдэлийн оновчтой удирдлагыг шаардаж байна. Банкны салбарын хэмжээнд гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд ($\pm 15\%$) (4.8) хувь байгаа бол нийт валютын хувьд ($\pm 40\%$) 7 хувь болжээ. Хоёр банк хамгийн их эрсдэлийн аргаар зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтээ тооцож байгаа бол үлдсэн банкууд гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлтээ хангаж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын үндсэн үзүүлэлтүүд


Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт банкны салбарын хэмжээнд 14.4 хувь байгаа нь бусад орнуудын¹² үзүүлэлтүүдээс 0.5-3.4 нэгж хувиар доогуур байна. Олон улсын Базелийн хяналт шалгалтын хорооноос гишүүн улс орнуудын банкны системийг Базел III-т шилжих төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүний дагуу өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлсэн. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 10.3 хувь байна. Банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах, өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үүднээс хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хоёр дахин өсгөж, 16 тэрбум төгрөгт хүргэсэн бөгөөд бүх банкууд уг шаардлагыг

¹² WHD – (Western hemisphere countries), ED (emerging and developing economies) – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд, OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд (organization for economic cooperation and development), G20-их 20 орнууд (group of 20 countries), EUR- европын орнууд (European countries), APD – ази, номхон далайн орнууд (asian and pacific countries)

Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар нь авсан болно.


ханган биелүүллээ. Мөн системийн нөлөө бүхий банкуудад тавих нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг өсгөж 2013 оны эхний хагас жилээс эхлэн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн доод шаардлагыг 14 хувьд хүргэсэн бөгөөд бүх банкууд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод шаардлагыг ханган ажиллаж байна.

Зураг 55: Өөрийн хөрөнгийн хүрэлцээ




Эх сурвалж: Монголбанк, ОУВС

Зураг 56: 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Зээлийн чанарыг хэмжих гол үзүүлэлт болох чанаргүй зээлийн харьцаа нь бүс нутгийн түвшний үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй бага хэмжээнд байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ буурч байгаа нь нийт зээлийн өөрийнх нь өсөлттэй холбоотой юм. Зээлийн өндөр өсөлтийн ард зээлийн чанаргүйдэлт нуугдаж болзошгүй байдаг. Монголбанкнаас Хадгаламж банкинд "Банкны тухай хууль"-ийн дагуу албадлагын арга хэмжээг авч, үйл ажиллагааг хязгаарласнаар банкны салбарын чанаргүй зээл 2013 оны 6 дугаар сараас 7 дугаар сар дуусталх хугацаанд 135.9 тэрбум төгрөгөөр буюу 78.9 хувиар нэмэгдсэн билээ.


Зураг 57: Чанаргүй зээл нийт зээлийн харьцаа




Эх сурвалж: Монголбанк, ОУВС

Банкны салбарын ашигт ажиллагаа сайн байна. Бүс нутгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад Монголын банкуудын активын өгөөж 0.3-1.4 нэгж хувиар илүү байгаа нь банкуудын ашигт ажиллагаа өндөр байгааг харуулж байна. Евро бүсийн өрийн хямралтай холбоотойгоор Европын банкуудын активын өгөөжийн хэмжээ хамгийн бага буюу 0.8 хувьд хүрчээ.

Зураг 58: Активын өгөөж




Зураг 59: Өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Монголбанк, ОУВС

Тайлбар: Активын өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцоолохдоо жилийн хугацаанд дундажлан тооцооллыг хийсэн болно. Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт бүс нутгийн түвшинтэй харьцуулахад өндөр байна. Европын бүс нутагт хамгийн бага буюу 4.3 хувь байна. Зээлийн хүүний орлого, үнэт цаасны хүүний орлогын өсөлттэй холбоотойгоор банкуудын ашигт ажиллагаа сайжирч байгаа бөгөөд энэ нь өөрийн хөрөнгийн өгөөж, активын өгөөжийг нэмэгдүүлэхэд голлох нөлөөг үзүүлээ.

Зураг 60: Хөрвөх актив нийт активын харьцаа, хувиар



Эх сурвалж: Монголбанк, ОУВС

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 213 тоот тушаалаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг банкуудад тогтоосон бөгөөд уг харьцаа нь хамгийн багадаа 25 хувь байхаар заасан байдаг. Нийт активт эзлэх хөрвөх активын хэмжээ бүс нутгийн үзүүлэлтүүдтэй ойролцоо түвшинд байгаа бөгөөд манай орны хувьд банкууд нийт активынхаа 27.8 хувийг түргэн борлогдох чадвар бүхий хөрвөх чадвар өндөртэй активт байршуулжээ.

4.2 ЭДИЙН ЗАСГИЙН ОЙРЫН ТӨЛӨВ¹³

4.2.1 Гадаад эдийн засгийн төлөв

Ирэх 12-18 саруудад гадаад эдийн засгийн орчин төдийлөн сайжрахгааргүй байх хүлээлттэй байна.

Зураг 61: Худалдааны нөхцөл ба экспортын жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Хэдийгээр 2014 онд АНУ, Евро бүсийн эдийн засаг ялимгүй сэргэхээр байгаа боловч Төв банкууд нь мөнгөний тэлэх бодлогоо аажмаар хязгаарлах, Хятадын хөрөнгө оруулалтын өгөөж буурч, эдийн засгийн өсөлт саарч байгаа зэрэг нь түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлснөөр ирэх онд манай гадаад худалдаа, хөрөнгө оруулалт эрс сайжрах төлөв харагдахгүй байна.

Ийнхүү экспортын бүтээгдэхүүний үнэ төдийлөн өсөхөөргүй, гадаад худалдааны нөхцөл дорвитой сайжрахгааргүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом нэмэгдэхээргүй байгаа өнөө үед урсгал тэнцлийн алдагдал нь үйлчилгээний гадаад худалдааны алдагдлын өсөлтөөс шалтгаалан буурахгүй байх, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг багасах, улмаар төлбөрийн тэнцлийн дарамт арилахгүй байх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт үргэлжлэх эрсдэлтэй байна.

Хүснэгт 14: Гадаад эгзоген хувьсагчдын төсөөлөл

		Гүйцэтгэл		Өнөөгийн байдал		Төсөөлөл (2013 оны эцэст)		Төсөөлөл (2014 оны эцэст)	
		2012 он				V сар	IX сар	Өөрчлөлт	IX сар
ДНБ-ий өсөлт (%)									
АНУ		2.6	2013Q2	1.7	2	1.7	-0.3	2.5	
БНХАУ		7.8	2013Q2	7.5	7.8	7.5	-0.3	7.3	
Түүхий эдийн үнэ									
Нүүрс	\$/тн	94	08.31	77	90.5	89	-1.3	93	
Зэс	\$/тн	7995	08.31	7077	7616	7210	-406	7160	
Алт	\$/унц	1689	08.31	1347	1495	1300	-195	1327	
Төмрийн хүдэр	\$/тн	127	08.31	137.7	115	113	-2.3	112	
Газрын тос (Урал)	\$/бар	110	08.31	109	105	103.4	-1.9	103.1	
Худалдааны нөхцөл /ToT/		1.30	08.31	1.42	1.34		1.29		

Эх үүсвэр: Bloomberg, EIU, Bloomsbery

¹³ Гадаад эдийн засгийн тоймыг бэлтгэхдээ Roubini Global Economics-н 6 дугаар сарын дэлхийн эдийн засгийн бүсчилсэн шинжилгээ, Оксфорд Аналитикагийн хамаарал бүхий нийтлэлүүд болон Economist Intelligence Unit-ийн 8 дугаар сарын Global Outlook тайланг тоймлож, түүхий эдийн үнийн төсөөлөл хэсэгт Bloomberg-н шинжээчдийн 8 дугаар сарын төсөөллийн медиан утга болон 8 дугаар сарын Global Outlook тайлангийн төсөөллийг оруулсан бөгөөд Монголбанкны зүгээс ямар нэгэн дүн шинжилгээ хийгээгүй болно.

АНУ, Хятад, Оросын эдийн засгийн төлөв

...АНУ
2013 онд
1.8 хувиар
өсөхөөр
байна....

2013 оны I, II улиралд АНУ-ын эдийн засаг 1.1, 1.7 хувиар (q-o-q) өсчээ. Хувийн хэрэглээ, экспорт, хөрөнгө оруулалт ДНБ-ий өсөлтөд эерэгээр нөлөөлж, төсвийн зардлыг бууруулснаас үүдэлтэй сөрөг нөлөөг саармагжуулсан байна. Үл хөдлөх хөрөнгө болон бусад салбарт хөрөнгө оруулалтууд тогтмол нэмэгдэж, 5 дугаар сард орон сууцны үнэ 2006 оноос хойшхи хугацаанд хамгийн ихээр буюу өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар өссөн нь АНУ-ын эдийн засаг сэргэж эхэлж байгааг харуулж байна. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин оны эхнээс тогтмол буурсаар 7 дугаар сард 7.4 хувь болж, сар бүр дунджаар 200 мянган ажлын байр шинээр бий болж байгаа зэрэгт үндэслэн Холбооны нөөцийн банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх QE3 хөтөлбөрөө 2014 оноос аажмаар бууруулах төлөвлөгөөтэй байна. 2013 оны 9 дүгээр сард төсвийн зардлыг дахин бууруулж, 2014 оноос мөнгөний бодлогоо чангаруулж болзошгүй байна. Иймд EIU, Roubini, Bloomberg зэрэг судалгааны байгууллагууд 2013, 2014 онд АНУ-ын өсөлтийг харгалзан 1.7%, 2.5% байна хэмээн таамаглаж байна.

...Хятадын
эдийн
засгийн
өсөлтийн
төсөөллийг
бууруулаа...

2012 оны IV улиралд жилийн 7.9% байсан БНХАУ-ын ДНБ-ий өсөлт 2013 оны I, II улиралд 7.7%, 7.5% (өмнөх оны мөн үеэс) болж буурчээ. Хятадын албан ёсны статистик мэдээнд аж үйлдвэрийн өсөлт 2013 оны 1, 2 дугаар сард 9.9% (өмнөх оны мөн үеэс) байсан бол 6 дугаар сарын байдлаар 8.9% болж буурсан, бараа, үйлчилгээний экспорт 1, 2 сард өмнөх оны мөн үеэс 25, 21.8 хувиар өсч байсан бол 6 дугаар сард 3.1%, импорт 0.1%-иар тус тус буурсан байна. Евро бүсийн эдийн засаг хямралтай байгаа нь ийнхүү Хятадын гадаад худалдаанд сөргөөр нөлөөлж байна. Хятадын шинэ удирдлагууд эдийн засгийн бодлогоо өөрчилж илүү тэнцвэртэй, дотоод эрэлт, хэрэглээнд суурилсан өсөлтийг бий болгох, чанаргүй зээлийг бууруулж, зээлийг хумих бодлого зарлаад байна. Иймд 2013 оны эдийн засгийн өсөлтийг 7-7.5% байна хэмээн төсөөллийг бууруулсан байна.

...ОХУ-
ын эдийн
засгийн
өсөлт
саарахаар
байна...

ОХУ-ын ДНБ-ний өсөлт 2012 онд 3.4 хувьд хүрсэн бол 2013 оны I улиралд 1.1% (өмнөх оны мөн үеэс) болж буурчээ. Цаашид гадаад эрэлт сэргэхээргүй, зээлийн хүү, инфляци өндөр байгаагаас дотоод хөрөнгө оруулалт, хэрэглээ хангалттай өсөхөөргүй байна. Иймд 2013 онд Орос улс ургац сайн хураан авч, хүүний түвшинг бууруулж чадвал эдийн засаг нь 2.8%-иар өсөх боломжтой хэмээн Bloomberg-ын судлаачид үзэж байна.

Түүхий эдийн үнэ

*...Түүхий
нефтийн
үнийн
төсөөллийг
ялимгүй
бууруулсан
байна...*

7 дугаар сарын 31-ний байдлаар 1 баррель Brent газрын тосны үнэ 109\$ байна. Ойрх Дорнодын улс төрийн хурцадмал байдлын улмаас нийлүүлэлт тасалдах эрсдэл өндөр байгаа тул газрын тосны үнэ өндөр хэвээр байна. Цаашид дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, АНУ-ын эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаагаас оны эцэст газрын тосны үнэ ялимгүй буурч 105\$/баррельд хүрнэ хэмээн таамаглаж байна. ОХУ-аас импортолдог боловсруулсан нефтийн хувьд оны эхэнд 308\$/тн байсан экспортын татвар 9 сард 312.5\$/тн болж өсөхөөр байна.

*...Зэсийн
үнийн
төсөөллийг
дахин
бууруулжээ...*

Дэлхийн банкны тооцоолсноор 2013 оны эхний хагаст өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хятадын зэсийн хэрэглээ 5.7%, дэлхийн нийт хэрэглээ 2.3%-иар тус тус буурчээ. Энэ нь 2012 онд Хятадад зэсийн нөөцлөлт их болсонтой холбоотой бөгөөд 2013 оны сүүлийн хагаст энэхүү нөөцийн хэмжээ багасмагц, зэсийн хэрэглээ нэмэгдэж 2013 онд дэлхийн хэрэглээ 2.8%-иар өснө хэмээн EIU-ийн шинжээчид таамаглаж байна. Энэ оны эхний саруудад зэсийн үнэ дэлхийн зах зээлд дунджаар 8000\$/тн байсан бол Хятадын эдийн засгийн өсөлт саарч, металлын эрэлт буурахын зэрэгцээ хөрөнгө оруулагчид илүү өндөр өгөөжтэй үнэт цаасанд хөрөнгө оруулах болсноор зэсийн үнэ тогтмол буурч, 6 дугаар сарын 31-ний байдлаар 6700\$/тн-д хүрсэн билээ. Цаашид агуулах дахь зэсийн нөөц буурч, хэрэглээ нэмэгдсэнээр зэсийн үнэ ялимгүй өсч оны эцэст 7210\$/тн-д хүрэх магадлалтай байна.

*...2013 оны
I, II улирлын
эдийн
засгийн
төлөвт
үндэслэн
нүүрсний
эрэлт, үнийн
төсөөллийг
дахин
бууруулжээ..*

Хятадын эдийн засгийн өсөлт саарч, 300 сая тонн нүүрсний хуримтлал бий болсон нь 2013 оны эхний хагаст нүүрсний үнэ оны эхнээс 20 орчим хувиар буурах гол шалтгаан болсон байна. 2013 оны 2 дугаар сараас эхлэн нүүрсний үнэ буурсаар 9 дүгээр сарын 1-ний байдлаар эрчим хүчний нүүрсний¹⁴ үнэ 77\$/тн¹⁵ байна. Энэ оны сүүлийн улиралд нүүрсний үнэ одоогийн түвшнээс ялимгүй өсөх боловч өмнөх оны мөн үеэс 7%-иар доогуур буюу 89\$/тн орчимд байхаар байна.

*...Алтны
үнийн
төсөөллийг
дахин
бууруулсан
байна...*


Алтны үнийн хувьд, Киприйн Төв банк их хэмжээгээр алт зарсан, Холбооны нөөцийн банк бонд худалдан авах хөтөлбөрөө дуусгах төлөвлөгөөтэй байгаагаар нийтэд зарласан тул 4, 5 сард огцом унав. 6 дугаар сарын байдлаар алтны үнэ оны эхнээс 28%-иар буурч, энэ онд алтны нийлүүлэлт нэмэгдэж зах зээлд 600 тоннын илүүдэл үүсэх төлөвтэй байгаа тул 7 сарын 31-ний байдлаар 1325\$/унц-д хүрээд байгаа алтны үнэ цаашид улам унасаар оны эцэст 1300\$/унц-д хүрэх төлөвтэй байна.

¹⁴ Нүүрснийг шатамхай байдал, ус чийг, бусад хольцын агууламж, чанараас хамааруулан ангилдаг. Эрчим хүчний нүүрс нь ихэвчлэн дулааны цахилгаан станцад ашиглагддаг, коксжих нүүрстэй харьцуулахад чанар муутай.

¹⁵ Энэ нь Австралийн АНУ – д нийлүүлдэг дулааны нүүрсний үнэ бөгөөд БНХАУ – руу экспортолдог манай нүүрсний үнийн төсөөллийн мэдээ байдаггүй тул үнийн ерөнхий динамикийг ажиглах зорилгоор Австралийн нүүрсний үнийг оруулав.

Худалдааны нөхцөл

Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн алт, зэс, нүүрс, төмрийн хүдрийн үнэ 2013 оны сүүлд одоогийн түвшнээс ялимгүй өндөр байх боловч, 2014 онд буурахаар байгаа бол импортын гол бүтээгдэхүүн болох газрын тос, улаан буудай, элсэн чихэр, хүнсний бүтээгдэхүүний үнэ буурахааргүй байгаа нь манай гадаад худалдааны нөхцөл 2013-2014 онд сайжрахааргүй төлвийг илэрхийлж байна. Тухайлбал 2013 оны экспортын дундаж үнэ 2012 оны дундаж үнэтэй харьцуулахад 8.4%-иар буурч, импортын үнэ 1.4%-иар өсч, худалдааны нөхцөл 9.8 хувиар муудах бол Оюу толгойн экспортыг хасч тооцсоноор 2013 онд нийт экспортын биет хэмжээ 2012 онтой харьцуулахад 2.5%-иар өсч байгаа боловч экспортын үнийн бууралтын улмаас экспорт 6%-иар буюу 257.3 сая ам.доллараар буурах төлөвтэй байна.¹⁶

Зураг 62: Гадаад худалдааны нөхцөл

Эх үүсвэр: Монголбанк

Дотоод эдийн засгийн төлөв

Дотоод эдийн засгийн төсөөллийг хийхдээ 1) Оюу Толгойн үйлдвэрлэл, 2) “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”, Чингис бондын хөрөнгөөр санхүүжигдэх төслүүдийн санхүүжилтийн хуваарь, 3) Улсын төсөв, 4) ДНБ-ий өсөлтийн таамаглал, 5) Төлбөрийн тэнцлийн төсөөлөл, 6) Мөнгөний үзүүлэлтүүдийн төсөөллийг авч үзлээ.

4.2.2 Оюу Толгой /ОТ/-н үйлдвэрлэлийн таамаглал ¹⁷

Оюу толгойн экспорт 2013 оны 2 дугаар улирлаас эхлэх төлөвлөгөөтэй байсан боловч 2 удаа хойшлогдсоны эцэст 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхэлсэн. Гэвч БНХАУ-ын дотоодын хууль эрх зүйн асуудлаас болж бүтээгдэхүүнийг хилээр гаргах үйл ажиллагаа удаашран 7 дугаар сарын 25-ны өдөр анхны экспортын бүтээгдэхүүнийг хилээр гаргасан байна.

Оюу толгой төсөл 2013 онд 93.2 мян.тонн цэвэр зэс агуулсан зэсийн баяжмал үйлдвэрлэж, түүнээс 57.2 мян.тонныг экспортлох, 9.9 тонн алт олборлож, үүнээс 4.0

¹⁶ Экспортын биет хэмжээ, орлогын төсөөллийг Төлбөрийн тэнцлийн төсөөллөөс авч ашиглалаа.

¹⁷ ОТ-н үйлдвэрлэлийн таамаглалыг тус компаниас 7-р сард ирүүлсэн мэдээ болон сүүлийн үеийн зарим шинэ мэдээлэлд үндэслэн хийв.

тонныг экспортлохоор тус тус төлөвлөсөн байна. Ингэснээр нийт экспортын жилийн өсөлтөд 10, бодит ДНБ-ий жилийн өсөлтөд 5.7 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр байна. Гаалийн мэдээнээс үзэхэд 7 сарын эцсийн байдлаар 0.77 мян.тонн цэвэр зэс агуулсан баяжмал буюу 3 дугаар улиралд төлөвлөсөн зэсийн экспортын 4.4%-ийг л экспортлоод байна. 2014 онд 174 мян.тн цэвэр зэс, 20.8 тн алт, 42 тн мөнгө олборлохоос 163.2 мян. тн цэвэр зэс, 19.7 тн алт, 37 тн мөнгийг экспортлохоор төлөвлөсөн байна.

ОТ компани одоогоор 1155.2 сая ам.долларын зээл авч зарцуулаад байгаа тул 2013 онд нийтдээ 1236 сая ам. долларын зээлийн эх үүсвэрийг оруулж ирнэ гэж үзлээ. 2012 онд 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж байсан бол 2013 онд ил уурхайн бүтээн байгуулалтын ажил гүйцсэн, далд уурхайн хөрөнгө оруулалт хойшилсны улмаас хөрөнгө оруулалтын хэмжээ буурч 2013 оны ДНБ-ий өсөлийг 1.7 нэгж хувиар бууруулах төлөвтэй байна. Далд уурхайн үйлдвэрлэл эхлэх хугацаа одоогоор тодорхой бус байгаагаас 2014 онд хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ мөн тодорхой бус байгаа тул тооцоонд оруулаагүй болно.

4.2.3 Хөтөлбөр, Чингис бонд

Монголбанкнаас эдийн засгийг тогтворжуулах, инфляцийг бууруулах, банкны салбарыг бэхжүүлэн эрсдэлээс хамгаалах, эдийн засгийн бодит секторыг дэмжих, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх зорилгоор нийлүүлсэн мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2013 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3101.5 тэрбум төгрөг байна¹⁸ (Хүснэгт 15).

Чингис бондын эх үүсвэрээр санхүүжүүлэх төслүүдийн хувьд энэ онд хийгдэх нийт 1.7 их наяд төгрөгийн зарцуулалтаас эхний 8 сарын байдлаар 625.4 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг төслүүдэд олгоод байна (Хүснэгт 16). Бондын зарцуулалт нь төсөвтэй адилтгах зардал бөгөөд 2013 онд хийгдэх санхүүжилт нь ДНБ-ий 10.3 хувьтай тэнцэх дүн юм. 2014 онд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хийгдэж буй авто зам, цахилгаан станц, дэд бүтцийн төслүүдэд 413.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгох бол төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй хийгдэх орон сууцны барилга, төмрийн хүдэр ангижруулах үйлдвэр барих төслүүдэд 100.5 тэрбум төгрөг олгохоор байна.

Хүснэгт 15: Монголбанкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд

тэрбум төгрөгөөр	2012	13.08.31
	Олгосон	Олгосон
1. Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах	111.0	24.7
1.1. Мажны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах	87.0	0.0
1.2. Гурилын нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах	24.0	24.7
1.3. Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн АА-г хөгжүүлэх		
1.3.1. Зоор, агуулахыг нэмэгдүүлэх		
1.3.2. Эрчимжэн АА-г хөгжүүлэх		
2. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах	93.7	98.3
3. Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах		22.0
3.1. УБ төмөр зам, шатахууны эргэлтийн хөрөнгө		22.0
3.2. Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх		
3.3. Вагоны паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх		
3.4. Зүтгүүрийн паркын хүчин чадлыг нэмэгдүүлэх		
4. Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах		1 412.0
4.1. Барилгын материал		287.1
4.1.1. Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын үйлдвэрлэл		161.7
4.1.2. Цемент, арматурын импорт		125.4
4.2. Орон сууцны ипотекийн зээл		1 124.9
5. Орон сууцны барилгын нийлүүлэлтийг дэмжих		429.5
6. Нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах		0.0
7. Монголбанкнаас банкуудад байршуулсан хадгаламж		900.0
8. Хадгаламж банкинд олгосон барьцаат зээл		165.0
9. Хадгаламжийн даатгалын корпорацид өөрийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэх		50.0
Нийт	204.7	3 101.5

Эх үүсвэр: Монголбанк

хувьд 2013 оны батлагдсан орлогоос 181.7 тэрбум төгрөгөөр, хүлээгдэж буй бодит гүйцэтгэлээс 1.2 их наяд төгрөгөөр өндөр байна. Төсвийн зарлагын хувьд төсвийн тогтвортой байдлын хуулийн хүрээнд хамгийн өндөр байхаар буюу төсвийн алдагдал ДНБ-ий 2 хувьтай тэнцүү байхаар авчээ.

Хүснэгт 17: Төсвийн хүрээний мэдэгдэл, тэрбум төгрөг

	2011	2012	2013 Бат	2014 ТХМ
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	батлагдсан	төлөвлөгөө
ТӨСВИЙН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4400.6	4952.2	7258.1	7514.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	241.0	87.4	169.8	244.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4159.6	4864.8	7088.3	7270.0
А. УРСГАЛ ОРЛОГО	4141.3	4824.7	7087.5	7269.2
1. ТАТВАРЫН ОРЛОГО	3636.9	4203.4	6461.5	6598.3
1.1 Орлогын албан татвар	831.8	870.0	1261.5	1586.3
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	450.4	688.0	732.0	806.1
1.3 Өмчийн татвар	16.9	21.6	23.8	26.1
1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар	1108.3	1287.2	1940.2	2043.4
1.5 Онцгой албан татвар	294.0	312.4	595.2	596.5
1.7 Гаалийн албан татвар	337.4	327.4	575.3	489.8
1.8 Бусад татвар (төлбөр, хураамж)	571.7	662.9	1296.3	1004.4
2. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	504.4	621.3	626.0	670.9
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	16.8	15.4	0.8	0.8
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1.5	24.7	0.0	0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4792.0	6116.7	7444.6	7686.3
А. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3234.4	4452.1	4906.1	5356.7
1. Бараа, үйлчилгээний зардал	1528.1	2072.8	2479.9	2718.0
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	37.3	126.4	397.8	441.0
3. Татаас ба урсгал шилжүүлэг	1669.0	2252.9	2028.4	2197.7
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1067.2	1575.3	2488.9	2299.5
1. ХО, тоног төхөөрөмж, их засвар	976.3	1362.2	2060.1	1858.6
2. Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалт	51.4	162.4	369.7	381.8
3. Хөрөнгийн бусад зардал	39.5	50.7	59.1	59.1
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	490.5	89.3	49.6	30.2
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	477.5	79.0	-27.4	30.2
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	13.0	10.3	77.0	0.0
ТЭНЦЭЛ	0.0	0.0	0.0	0.0
- Урсгал тэнцэл	906.9	372.6	2181.4	1912.5
- Тэнцвэржүүлсэн тэнцэл	-632.4	-1251.9	-356.3	-416.3

Эх сурвалж: Сангийн яам, төсвийн хүрээний мэдэгдэл

4.2.5 Мөнгөний үзүүлэлтүүдийн төлөв

2013 онд төлбөрийн тэнцлийн алдагдлаас үүдэн гадаад цэвэр актив цаашид үргэлжлэн буурахаар байгаа хэдий ч, Чингис бондын зарцуулалт, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр дотоод цэвэр актив өсөхөөр хүлээгдэж байгаа нь нийт М2 мөнгөний нийлүүлэлтийг 2013 оны эцэст 29 хувиар өсгөхөөр байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн төсөөллийг дараах таамаглал нөхцөлд үндэслэн хийв.

- Оюу толгойн үйлдвэрлэл төлөвлөсөн хуваарийн дагуу явагдана.
- 2013 онд батлагдсан төсвийн орлого 1.0 их наяд төгрөгөөр тасарна.
- 2013 онд батлагдсан төсвийн зарлагын хувьд Төсвийн зардал 945 тэрбум төгрөгөөр тасарна.

- 2014 оны төсвийн орлого, зарлага төсвийн хүрээний мэдэгдлийн дагуу хэрэгжинэ.
- Хөгжлийн банк нэмж гадаад бонд гаргахгүй.
- Чингис бондын зарцуулалт хуваарийн дагуу хийгдэнэ.
- Орон сууцны ипотекийн 2013 оны 4 дүгээр улиралд төлөгдөх 827.1 тэрбум төгрөгийн зээлийн 511.5¹⁹ тэрбум төгрөгийн зээл нь МИК-ийн бондоор хугацаандаа төлөгдөнө. Үлдсэн хэсэг нь 2014 оны 1 дүгээр улиралд МИК-ийн бонд руу хөрвөнө.
- Орон сууцны ипотекийн зээлээс гадна “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрүүд хуваарийн дагуу хэрэгжинэ.
- Монголбанкнаас банкуудад байршуулсан 900 тэрбум төгрөгийн хадгаламжийг 2013 оны 4 дүгээр улиралд эргүүлэн татна гэж үзэв.
- Самурай бонд гаргах хуваарь болон зарцуулалтын талаар албан ёсны мэдээ байхгүй байгаа тул төсөөлөлд оруулаагүй болно.

Иймд 2013 онд М0 мөнгө дэх гадаад цэвэр актив 2.9 их наяд төгрөгөөр буюу 57 хувиар буурч байна. Харин Чингис бондын зарцуулалт, Монголбанкны бодлого, хөтөлбөрийн хүрээнд банкинд олгосон зээл, байршуулсан эх үүсвэрээс шалтгаалж М0 мөнгө дэх дотоод цэвэр актив /ДЦА/ 2013 онд 3.5 их наяд төгрөгөөр өсч, нийлбэр дүндээ нөөц мөнгө 0.6 их наяд төгрөг буюу 26.7 хувийн өсөлттэй байх тооцоо гарч байна.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгох зээл, Чингис бондын зарцуулалт зэрэг дотоод эх үүсвэрээр зээлийн өрийн үлдэгдэл 2013 онд 47.1 хувиар өсч, мөнгөний нийлүүлэлт 29 хувиар өснө гэж таамаглав.

Цаашид гадаад эдийн засгийн төлөв сайжрах хандлага ажиглагдахгүй байгаагаас М2 мөнгөний гадаад эх үүсвэр 2014 онд үргэлжлэн буурахаар байна. Харин Чингис бондын зарцуулалт болоод зээлийн өсөлтийн хандлагаас хамаарч дотоод эх үүсвэрээр мөнгөний нийлүүлэлт ямар хэмжээгээр нэмэгдэх нь тодорхойлогдохоор байна. 2014 онд М2 мөнгө жилийн 18 хувиар өсөх таамаглалтай байна.

¹⁹ МИК-иас авсан мэдээнд үндэслэв.

Хүснэгт 18: Мөнгөний үзүүлэлтүүдийн төлөв

Мөнгөний тойм	2008	2009	2010	2011	2012				2013					2014			
	IV	IV	IV	IV	I	II	III	IV	I	II	M08	III	IV	I	II	III	IV
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйцэтгэл				Гүйцэтгэл			Төсөөлөл		Төсөөлөл			
M2 мөнгө	2270	2880	4680	6412	6105	7051	7112	7617	7301	8004	8410	8698	9827	10376	10949	11594	11595
M1 мөнгө	647	651	1158	1741	1488	1797	1658	1835	1589	2027	1950	2113	2416	2498	2644	2816	2808
Бараг мөнгө	1623	2229	3522	4671	4617	5254	5454	5782	5711	5977	6460	6585	7411	7878	8305	8777	8787
Гадаад цэвэр актив	683	1533	2739	3067	3355	3448	2867	4401	3938	2781	2273	1867	1313	1296	1189	831	603
Гадаад цэвэр нөөц	747	1694	3023	3400	3655	3785	3628	5160	4716	3563	3173	2801	2195	2178	2071	1713	1485
Төв банкны	808	1652	2628	3153	3495	3645	3513	5053	4721	3740	3180	2808	2202	2185	2078	1720	1492
Арилжааны банкны	-60	41	395	247	160	139	115	107	-6	-177	-7	-7	-7	-7	-7	-7	-7
Бусад цэвэр зүйл	-64	-161	-283	-333	-300	-336	-761	-759	-777	-782	-900	-934	-882	-882	-882	-882	-882
Дотоод цэвэр актив	1587	1347	1941	3345	2750	3603	4246	3216	3362	5223	6137	6831	8514	9081	9760	10763	10993
Дотоодын цэвэр зээл	2062	1938	2430	4271	4404	5288	5863	3951	4380	6075	7456	8150	9372	9130	9810	10813	11042
ЗГ-ын цэвэр зээл	-574	-717	-835	-1370	-1378	-1030	-1004	-3040	-3011	-2533	-2328	-1894	-910	-738	-588	-343	-275
Зээл	2636	2655	3265	5641	5782	6318	6867	6991	7391	8608	9783	10044	10283	9869	10398	11156	11317
Үүнээс хөтөлбөрийн зээл								193	251	699	1158	1480	1917	1784	1692	1745	1451
Бусад зээл								6798	7140	7909	8625	8564	8365	8085	8706	9411	9865
Бусад цэвэр зүйл	-475	-591	-489	-926	-1654	-1685	-1618	-735	-1018	-852	-1319	-1319	-858	-50	-50	-50	-50
Төв банк																	
Нөөц мөнгө	634	733	945	1660	1815	2281	2404	2166	2468	3509	2602	2772	2744	3311	3342	3159	2906
	0	0	0	0													
Гадаад цэвэр актив	805	1538	2529	3044	3391	3542	3404	5166	4794	3791	3222	2851	2246	2230	2122	1764	1536
Дотоод цэвэр актив	-171	-805	-1584	-1384	-1576	-1261	-1000	-3000	-2326	-282	-620	-80	497	1081	1220	1395	1370
ЗГ-ын цэвэр зээл	-183	-265	-492	-714	-608	-440	-347	-2774	-2917	-2728	-2594	-2009	-1002	-871	-775	-835	-876
Үүнээс Нэгдсэн төсөв								-686	-802	-995	-1176	-713	-502	-523	-560	-775	-876
Чингис бонд								-2088	-2115	-1734	-1418	-1296	-500	-348	-215	-60	0
Банкинд олгосон зээл	243	198	131	342	544	404	258	401	1215	2883	3194	3493	2190	1250	1151	1218	1106
Үнэ тогтворжуулах хөтөлбөр								205	254	1880	2076	2421	1917	1030	939	991	697
Засгийн газрын хадгаламж									850	900	900	900	100	0	0	0	0
Бусад								196	111	103	218	172	173	220	213	227	408
Хасах нь: ТБҮЦ	120	393	1101	879	740	557	367	752	743	668	1356	1697	1286	747	605	437	309
Бусад цэвэр зүйл	-112	-346	-122	-133	60	114	26	157	125	232	139	139	599	1454	1454	1454	1454
Меморандум үзүүлэлтүүд:																	
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	34.6	26.9	62.5	37.0	23.2	22.2	17.5	18.8	19.6	13.5	20.2	22.3	29.0	42.1	36.8	33.3	18.0
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	19.7	15.7	29.0	75.5	78.0	81.1	71.9	30.5	36.0	53.8	33.9	15.3	26.7	34.1	-4.8	21.4	4.8
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	3.58	3.93	4.95	3.86	3.36	3.09	2.96	3.52	2.96	2.28	3.23	3.14	3.58	3.13	3.28	3.67	3.99
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	41.7	0.7	23.0	72.8	55.0	39.6	40.2	23.9	27.8	36.2	46.6	46.3	47.1	33.5	20.8	11.1	10.1
Хөтөлбөрөөс бусад зээлийн өсөлт(%)								20.5	23.5	25.2	29.2	26.0	17.2	13.2	10.1	9.9	17.9
Жилийн инфляци (%)	23.2	1.9	14.3	9.4	17.3	15.1	15.1	14.2	9.4	7.6	8.4	7.9	8.7				8.0
Хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл								205	49	1664		608	190	95	77	77	77
Хөтөлбөрийн хүрээнд төлөгдсөн зээл								0	1	57		67	611	982	168	25	370
Үүнээс МИК-ийн бондоор												460	855				

Эх үүсвэр: Монголбанк

Хүснэгт 19: Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд

	2009	2010	2011	2012	Төсөөлөл	
					2013	2014
Бодит сектор						
Бодит ДНБ	-1.3	6.4	17.5	12.3	14.7	7.7
Уул уурхайн ДНБ	5.8	3.6	7.3	8.9	42.5	15.1
Үүнээс ОТ:					43.1	32.0
Уул уурхайн бус ДНБ	-2.7	7.0	19.7	12.9	9.6	5.9
Хэрэглээний үнийн индекс (жил.дундаж)	6	10	8	15		
Хэрэглээний үнийн индекс (жил. эцэст)	2	14	9	14	8	
ДНБ-ний дефлятор	2	20	12	12	5	14
Нэг хүнд ногдох ДНБ						
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд						
Нийт орлого ба тусламжийн дүн	30.2	36.5	39.7	35.5	36.9	37.3
Тогтворжуулалтын сан	0.0	0.0	2.2	0.6	0.7	1.2
Нийт зардал ба цэвэр зээл	35.2	36.4	43.2	43.9	38.7	38.2
Нийт тэнцэл	-5	0	-6	-9	-2	-2
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр						
Уул уурхайн бус нийт тэнцэл				0.0		
Мөнгө ба зээлийн үзүүлэлтүүд						
M2 мөнгө	26.9	62.5	37.0	18.8	29.0	18.0
Нөөц мөнгө	15.7	29.0	75.5	30.5	26.7	4.8
Зээл	0.7	23.0	72.8	23.9	47.1	10.1
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	0.8	-0.2	-0.4	0.1	-0.1	-0.1
Худалдааны үнэ						
Экспортын үнийн индексийн өөрчлөлт, хувиар	33.4	28.2	19.5	-13.9		
Импортын үнийн индексийн өөрчлөлт, хувиар	-0.3	27.2	25.0	14.6		
Худалдааны нөхцлийн өөрчлөлт, хувиар	33.9	0.8	-4.4	-24.8		
Нийт зээлийн өрийн үлдэгдэл						
Дотоодын зээлийн өрийн үлдэгдэл	40.3	38.8	50.9	50.1	61.3	56.2
Гадаад зээлийн өрийн үлдэгдэл	65.1	95.7	109.9	148.7		
Үүнээс ОТ-н ШХО-г хассанаар			67.1	99.4		
Валютын ханш						
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш (жил.дундаж)	1438	1358	1266	1359		
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш (жил.эцэст)	1443	1256	1396	1392		
Бодит үйлчилж буй ханшийн өөрчлөлт, хувиар	-16.6	28.2	-5.7	8.1		
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн өөрчлөлт, хувиар	-16.2	16.7	-11.6	-5.7		
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөгөөр	6591	8415	11088	13944	16786	20135

Тайлбар: ДНБ-ий бодит өсөлтийн 2014 оны төсөөлөл нь гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдал арилахгүй, гадаад валютын орох урсгал сэргэж нэмэгдэхгүй тохиолдолд мөнгөний бодлогыг чангаруулах хувилбарт үндэслэсэн таамаглал болно.


Эх сурвалж: Монголбанк

4.2.6 Эдийн засгийн бодит өсөлт

ДНБ 2013 оны 3, 4-р улиралд өмнөх оны мөн улирлуудаас харгалзан 17.4, 16.5 хувиар тус тус өсөхөөр байгаа нь энэ оны өсөлтийг 14 орчим хувьд хүргэхээр байна. Энэхүү өсөлтөд Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн нөлөөнөөс гадна Оюу Толгойн үйлдвэрлэлээс улбаатай²⁰ уул уурхайн салбарын өсөлт голчлон хувь нэмэр оруулахаар байна.

Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн нөлөөгөөр энэ онд хөдөө аж ахуй, барилгын салбар өндөр өсөлттэй гарахаар байгаа нь өсөлтөд мөн өндөр хувь нэмэр оруулж байна. Оны сүүл рүү бүтээгдэхүүний цэвэр татвар буурахаар байгаа нь дотоодын болон импортын бараа, үйлчилгээнд ногдуулдаг татварын орлого буурч байгаагаар холбоотой.

Зураг 65: ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, үйлдвэрлэлийн аргаар



Эх сурвалж: Монголбанк


ДНБ-ий өсөлтийг эрэлт талаас нь төсөөлбөл 2013 оны III улиралд өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өсөх буюу жилийн эцэст өрхийн хэрэглээ болон экспортын өсөлтийн нөлөөгөөр эдийн засаг 13.2 хувиар өсөхөөр байна. Өрхийн хэрэглээний өсөлт оны III улиралд ДНБ-ий өсөлтийн 11.6 нэгж хувийг бүрдүүлэхээр байгаа юм. Засгийн газрын бараа, бүтээгдэхүүний худалдан авалт төсвийн орлогын гүйцэтгэл дутуугаас шалтгаалан 2013 оны сүүлийн хагаст өмнөх оны мөн үеэс бага зэрэг буурахаар байна.

Засгийн газрын бондын эх үүсвэр, үнэ тогтворжуулах хөтөлбөр болон Оюу толгойн хөрөнгө оруулалт зэрэг дотоод эх үүсвэр дээр төлбөрийн тэнцлийн төсөөллийн дагуу гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмж хөрөнгийн хуримтлалын өсөлтийг таамаглав. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 онд нийтдээ 47.5%-иар буурахаар байгаа боловч дотоодын эх үүсвэр үүнийг нөхөхөөр байна.

Гадаад худалдааны тэнцлийн төсөөллийг төлбөрийн тэнцлийн төсөөлөл ашиглан төгрөгт шилжүүлж экспорт, импортын үнийн индексээр үнийн нөлөөллийг арилгаж төсөөллөө. Цэвэр экспорт оны сүүлийн хагаст уул уурхайн экспортын өсөлтийн нөлөөгөөр нийт эрэлтэд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

²⁰ Оюу Толгой төслийн талаар дэлгэрэнгүйг “Оюу Толгой /ОТ/-н үйлдвэрлэлийн таамаглал” хэсгээс үзнэ үү.

Зураг 66: ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, зардлын аргаар




Эх сурвалж: Монголбанк

... 2013 онд
бодит ДНБ 14%
(ОТ-г хасвал
8%)..

2014 онд бодит
ДНБ 7% (ОТ-г
хасвал 5%)-иар
тус тус өсөхөөр
төсөөлөгдөж
байна...

Оюу толгой төслийн үйлдвэрлэл, Чингис бондын эх үүсвэрийн зарцуулалт, Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн нөлөөгөөр энэ оны сүүлийн хагаст ДНБ-ий бодит өсөлт 14 орчим хувьд гарахаар байгаагийн 6 орчим хувийг Оюу толгойн үйлдвэрлэл дангаараа бий болгохоор байна. 2014 оны өсөлтийн хувьд Оюу толгойн үйлдвэрлэлийг оруулснаар 7 орчим хувь, ОТ-г хассанаар 5 орчим хувь гарахаар байна. Гэхдээ энэхүү төсөөлөл нь гадаад эдийн засгийн орчин сайжрахгүй, валютын орох урсгал сэргэхгүй байх тохиолдол буюу ийм сөрөг орчинд мөнгөний бодлогыг чангаруулсан нөхцөлд гарах төсөөлөл болох юм.

Зураг 67: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

4.2.7 Инфляцийн төсөөлөл

... 2013 оны эцэст
жилийн инфляци
8.7%-д хүрэхээр

...2014 оны эцэст
жилийн инфляци
10.3%-д хүрэхээр
төсөөлөгдөж
байна...

...Өмнө хийгдсэн
инфляцийн
төсөөллөөс
одоогийн төсөөлөл
бага байна...

Инфляцийн интервалан үнэлгээгээр 2013 оны эцэст инфляци 8.7 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 5.0-13.7 хувийн хооронд, 2014 онд 10.3 хувийн голчтой, 90 хувийн магадлалын итгэх түвшинд 5.4-17.3 хувийн хооронд байхаар байна (Зураг 56). Инфляцийн төсөөллийг хийхдээ эрэлтийн талыг голчлон авч үзсэн бөгөөд нийлүүлэлтийн гаралтай инфляци, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт зэрэг нь төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж болзошгүй.

6-р сард хийгдсэн инфляцийн төсөөллөөс одоогийн төсөөлөл 2013 онд 0.1, 2014 онд 1.1 нэгж хувиар бага байна. Үүнд төсвийн гүйцэтгэл нь төлөвлөгөөнөөс бага байсан, 2013 оны төсвийн зарцуулалт орлогын тасалдлаас үүдэн таналт хийгдэнэ гэж үзсэн, мөн Чингис бондын зарцуулалтын зарим хэсэг хойшлогдож байгаа зэрэг нь инфляцийн төсөөллийг бууруулахад нөлөөлөв.

Зураг 68: Инфляцийн интервалан үнэлгээ



Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ 1. Пребиш-Зингерийн нөлөө буюу түүхий эдийн үнэ цаашид яах бол?

20 дугаар зууны дундуур Пребиш ба Зингер (Prebish-Singer) нар нэгэн таамаглал дэвшүүлжээ. Өдгөө Пребиш-Зингерийн нөлөө гэж нэрлэгддэг энэхүү таамаглалын гол агуулга нь түүхий эдийн үнэ бол үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүний үнээс удаан өсдөг гэсэн таамаглалд үндэслэдэг.



Харин саяхан ОУВС-гаас түүхий эдийн сүүлийн 350 жилийн үнийн хандлагыг судалсны эцэст дээрх таамаглал үндэслэлтэй болохыг тогтоосон байна. Ингэснээр түүхий эд экспортлогч орнууд нь нэмүү өртөг шингэсэн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, улмаар экспортлодог орнуудтай харьцуулахад гадаад худалдааны нөхцөл, нийт эдийн засгийн өрсөлдөх чадварын хувьд үргэлж тааруу нөхцөлд байдаг гэж хэлж болох юм. Энэ нь техник,

технологийн дэвшил үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах болсон, түүхий эдийг синтетик бүтээгдэхүүнээр орлох явдал түгээмэл болсонтой бас холбоотой.

Үүний зэрэгцээ түүхий эдийн үнэ урт хугацааны мөчлөгтэй байдгийг олон улсын түвшинд хийгдсэн судалгаанууд нотолдог. Өөрөөр хэлбэл, нэг төрлийн түүхий эдийн үнийг өөр бусад төрлийн түүхий эдийн үнийг тодорхой хэмжээгээр дагадаг, өөр хоорондоо харилцан хамааралтай байдаг хандлага сүүлийн 350 жилийн турш ажиглагдсан байна. Судлаачид 1650 оноос эхлэн түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүнээр 25 хос үзүүлэлтийг бүрдүүлж, өөр хооронд нь харьцуулан үзэхдээ юуны өмнө бүтцийн хугарал буюу үнэ, үйлдвэрлэлийн хэмжээ, хандлагад эрс өөрчлөлт орсон үеүдийг онцгойлон авч үзсэн байна.

Дэлхийн 2 дугаар дайн дууссанаас хойшхи хугацаанд түүхий эдийн үнэ 1950, 1973 болон 2003 онуудад огцом өсч байжээ. Эдгээр өсөлт нь дэлхийн эдийн засгийн хурдацтай өсөлт буюу эрэлтийн нөлөөгөөр голлон тайлбарлагдахаар байна.

Харин өнөө цагт түүхий эдийн үнийн өсөлтийг дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэл, бизнесийн мөчлөгөөс гадна мөнгөний тэлэх бодлогын нөлөө, хөгжиж буй орнуудын эрэлт голлон тодорхойлох болжээ. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр 2008-2009 оны хямралаар огцом унаж байсан түүхий эдийн үнэ эргээд сэргэсэн хэдий ч, үнийн чиг хандлага нь урт хугацааны өсөх мөчлөгөөс эргээд уруудаж байгаа гэдэгт судлаачдын дийлэнх нь санал нэг байна. Ийнхүү түүхий эдийн үнийн урт хугацааны өсөх мөчлөг дуусгавар болж, уруудах мөчлөгт орсноор түүхий эд экспортлогч орнуудад ногдох өгөөж нь багасах, харин түүхий эдийг импортолж, түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орнуудын хүртэх өгөөж нэмэгдэх чиг хандлагатай гэж үзэх боллоо.

Шигтгээ 2: “Төсөөлөл, бодлогын шинжилгээний систем”-ийг хөгжүүлэх нь

Монголбанк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Чех улсын OGR судалгааны байгууллага хамтран “Төсөөлөл, бодлогын шинжилгээний систем” (ТБШС)-ийг 2012-2014 онуудад хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү систем нь Төв банк инфляцийн зорилтдоо амжилттай хүрэхийн тулд авах шаардлагатай бодлогын арга хэмжээг тодорхойлоход шийдвэр гаргагчдыг макро эдийн засгийн хэрэгцээт цогц мэдээллээр хангах үйл ажиллагааны систем юм.

Улирлын төсөөлөл хийх үе шат

Төсөөлөл, бодлогын шинжилгээний системийн хүрээнд Монголбанк дараах алхмуудаар улирлын төсөөллийг хийж байна.

Зураг 1: Улирлын төсөөлөл хийх үе шат

1. Тоон мэдээллийг шинэчилж, гарсан гол өөрчлөлтүүдийг тайлбарлах.
2. Салбаруудын богино хугацааны төлвийг шинжлэх, ажиглах, макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн богино хугацааны төсөөллийг хийх.
3. Дээрхалхмуудадүндэслэнурьдач нөхцөлүүдийн танилцуулгыг бэлтгэн Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-д танилцуулж, гишүүдээс санал, нэмэлт мэдээлэл авах.
4. Урьдач нөхцөл, МБЗ-ийн гишүүдийн саналд үндэслэн загвараар дунд хугацааны төсөөлөл, бодлогын шинжилгээг хийх.
5. Дунд хугацааны төсөөлөл, бодлогын шинжилгээ, эрсдэлийг агуулсан мөнгөний бодлогын саналыг боловсруулж МБЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх.
6. МБЗ оруулсан санал, эрсдэл, тодорхой бус байдлыг хэлэлцэн бодлогын шийдвэр гаргаж, зах зээлд мэдээлнэ.



ТБШС дэх улирлын төсөөллийн загвар

Монголбанк олон улсын төв банкуудын мөнгөний бодлогын шинжилгээнд нийтлэг ашигладаг улирлын төсөөллийн загварыг хөгжүүлэн бодлогын шинжилгээнд ашиглаж байна. Загварын гол давуу тал нь түүхэн тоон өгөгдлийн шинж чанарыг хуулбарлах бус түүний цаана орших эдийн засгийн зүй тогтлыг харуулах юм.

Загварт нэрлэсэн, бодит үнэ, үйлдвэрлэлийг нийт эрэлтээр төлөөлүүлсэн Шинэ Кейнсийн загварыг төгс хүлээлттэй ДСЕТ-ийн загварын бодит мөчлөгийн уламжлалт аргачлалтай нийлүүлсэн. Загвар нь нийт эрэлт буюу IS муруй, үнэ тогтолт буюу Филиппсийн муруй, хүлээлт агуулсан валютын ханшийн UIP нөхцөл болон үйлдвэрлэлийн зөрүү, хүлээгдэж буй инфляцид хариу үйлдэл үзүүлэх бодлогын хүүний дүрэм гэсэн гол тэгшитгэлүүдээс бүрдэнэ.

Салбарын ажиглалт болон богино хугацааны төсөөллүүд нь эдийн засгийн богино хугацаан дахь чиг хандлагыг тодорхойлдог бол улирлын төсөөллийн загвар нь

онолын хувьд нийцтэй дунд хугацааны үр дүнг харуулдаг.

ТБШС-ийг хөгжүүлэхийн ач холбогдол

Мөнгөний бодлогын шийдвэр нь эдийн засагт тодорхой хугацааны дараа бүрэн нөлөөгөө үзүүлж байдаг. Иймд ирээдүйн инфляцийг төсөөлж, түүнийг зорилт болгож буй түвшинд авчрахын тулд урьдчилж бодлогын арга хэмжээ авах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнийг олон улсад урагшаа харсан мөнгөний бодлого (Forward looking monetary policy) гэж нэрлэнэ. Төсөөлөл, бодлогын шинжилгээний системийг хөгжүүлснээр шийдвэр гаргагч, төсөөлөл боловсруулагч хоорондын нягт уялдаа бүхий бодлогын шинжилгээг боловсруулж, эрсдэл, тодорхой бус байдлыг хэлэлцүүлэх замаар Мөнгөний бодлогын зөвлөлд бодлогын оновчтой, зөв шийдвэр гаргахад туслах болно. Ингэснээр инфляцийн төсөөллийг сайжруулж, бодлогын эерэг нөлөөг нэмэгдүүлэх юм.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцооны хэрэгжилт	20
Хүснэгт 2: Эдийн засгийн бодит секторыг дэмжив	26
Хүснэгт 3: Зарим гадаад, дотоод үзүүлэлтийн урьдчилсан таамаглал	40
Хүснэгт 4: Бодит ДНБ, салбараар (тэрбум төгрөг)	40
Хүснэгт 5: Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, тэрбум төгрөг (2013 оны эхний 8 сар)	44
Хүснэгт 6: Хөтөлбөрийн зээл, шинээр олгосон зээл	46
Хүснэгт 7: Гадаад худалдааны эргэлт, сая ам.доллар	47
Хүснэгт 8: Экспорт, сая ам.доллар (2013 оны эхний 8 сар)	48
Хүснэгт 9: БНХАУ-ын түүхий эдийн импорт	48
Хүснэгт 10: БНХАУ-ын аж үйлдвэрлэл, нүүрсний салбар	49
Хүснэгт 11: Импорт, сая ам.доллар (2013 оны эхний 8 сар)	51
Хүснэгт 12: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллар (2013 оны II улирал)	54
Хүснэгт 13: Нийт гадаад өрийн үлдэгдэл, сая ам.доллар	55
Хүснэгт 14: Гадаад эгзоген хувьсагчдын төсөөлөл	69
Хүснэгт 15: Монголбанкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд	74
Хүснэгт 16: Чингис бондын эх үүсвэрээр санхүүжигдэх төслүүд	75
Хүснэгт 17: Төсвийн хүрээний мэдэгдэл, тэрбум төгрөг	76
Хүснэгт 18: Мөнгөний үзүүлэлтүүдийн төлөв	78
Хүснэгт 19: Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд	79

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Махны үнийн жилийн өсөлт, 7 дугаар сард	17
Зураг 2: Махны үнийн жилийн өсөлт	17
Зураг 3: А-92 шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр).....	23
Зураг 4: Дизель түлшний жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр).....	23
Зураг 5: М2 мөнгө -10.9 хувиар огцом унахаас сэргийлж, нийт мөнгөний өсөлтийг тогтворжуулав	25
Зураг 6: ДНБ -9.6 хувиар буурахаас сэргийлж, эдийн засгийн бодит өсөлтийг тогтворжуулж, ажлын байр, иргэдийн бодит орлогыг хамгаалав... 25	
Зураг 7: Зээлийн тасалдлыг зогсоож, санхүү эдийн засгийн болзошгүй хямралаас сэргийлэв	26
Зураг 8: Улаанбаатар хотын сарын ба жилийн инфляци	27
Зураг 9: Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)	27
Зураг 10: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш ба гадаад секторын үндсэн үзүүлэлтүүд.....	31
Зураг 11: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт (интервалаар)	32
Зураг 12: Монголбанкнаас зарласан ханшийн хэлбэлзэл /2013 оны 7-9 сар/	32
Зураг 13: ДНБ-ий бодит өсөлт, салбараар	41
Зураг 14: Эрэлт талаас тооцсон ДНБ	41
Зураг 15: М2 мөнгө, жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал	42
Зураг 16: М2 мөнгө, жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал	42
Зураг 17: Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа.....	42
Зураг 18: Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар.....	43
Зураг 19: Төсвийн нийт орлого ба тусламж	45
Зураг 20: Төсвийн нийт зарлага ба цэвэр зээл.....	45
Зураг 21: Банкуудын хадгаламж, зээлийн хүү7.....	46
Зураг 22: Банк хоорондын захын хүү.....	46
Зураг 23: Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт.....	47
Зураг 24: Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ	48
Зураг 25: Лондоны металлын бирж дэх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ	50
Зураг 26: Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (сараар).....	50
Зураг 27: Дэлхийн зах зээл дэх Брент газрын тосны сарын дундаж үнэ	50
Зураг 28: Төлбөрийн тэнцэл.....	51
Зураг 29: Урсгал тэнцэл.....	51
Зураг 30: Барааны гадаад худалдаа	52
Зураг 31: Үйлчилгээний гадаад худалдаа	52
Зураг 32: Хөрөнгө, санхүүгийн данс.....	53
Зураг 33: Гадаад валютын улсын нөөц.....	53
Зураг 34: Гадаад актив	54
Зураг 35: Гадаад пассив.....	54

Зураг 36: Гадаад өрийн үлдэгдэл	55
Зураг 37: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	56
Зураг 38: Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл	56
Зураг 39: Засгийн газрын үнэт цаасны арилжаа	57
Зураг 40: Улсын болон Улаанбаатар хотын инфляци	57
Зураг 41: Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа, бүлгээр	58
Зураг 42: Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг) ба хөрөнгөөр тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ	59
Зураг 43: Ашиг (тэрбум төгрөг) ба ашгаар тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ	59
Зураг 44: Нийт хөрөнгийн динамик, тэрбум.төгрөг, хувиар	60
Зураг 45: Хөрвөх чадвар, эх үүсвэрийн динамик, тэрбум.төгрөг, хувиар	61
Зураг 46: Зээлийн динамик, тэрбум.төгрөг, хувиар	61
Зураг 47: Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбараар	62
Зураг 48: Хөрөнгийн бүтэц	62
Зураг 49: Харилцах, хадгаламж (тэрбум.төгрөг, хувиар)	63
Зураг 50: Эх үүсвэрийн бүтэц	64
Зураг 51: Зээлийн эрсдэлийн стресс тест	64
Зураг 52: Хөрвөх чадварын эрсдэлийн стресс тест	64
Зураг 53: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт, тэрбум төгрөг, хувиар	65
Зураг 54: Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (ТТГЧ)-ын харьцаа	66
Зураг 55: Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	67
Зураг 56: 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	67
Зураг 57: Чанаргүй зээл нийт зээлийн харьцаа	67
Зураг 58: Активын өгөөж	68
Зураг 59: Өөрийн хөрөнгийн өгөөж	68
Зураг 60: Хөрвөх актив нийт активын харьцаа, хувиар	68
Зураг 61: Худалдааны нөхцөл ба экспортын жилийн өөрчлөлт	69
Зураг 62: Гадаад худалдааны нөхцөл	72
Зураг 63: Төсвийн гүйцэтгэл	75
Зураг 64: Төсвийн тэнцэл, орлогын тасалдал	75
Зураг 65: ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, үйлдвэрлэлийн аргаар	80
Зураг 66: ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, зардлын аргаар	81
Зураг 67: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	81
Зураг 68: Инфляцийн интервалан үнэлгээ	82

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1: Пребиш-Зингерийн нөлөө буюу түүхий эдийн үнэ цаашид яах бол?	83
Шигтгээ 2: “Төсөөлөл, бодлогын шинжилгээний систем”-ийг хөгжүүлэх нь	84

Тэмдэглэл